

Тунхаглалын эцсийн хувилбар
2019 оны 01 дүгээр сар

УСНББОУС™

Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт™

УСНББОУС 42, Нийгмийн Халамжийн Тэтгэмж

IPSASB

Улсын Секторын Нягтлан
Бодох Бүртгэлийн Олон
Улсын Стандартын Зөвлөл™



Улсын Секторын Нягтлан
Бодох Бүртгэлийн Олон
Улсын Стандартын Зөвлөл™

Энэхүү баримт бичгийг Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (УСНББОУСЗ™) боловсруулж, баталсан.

УСНББОУСЗ-ийн зорилго нь улсын секторын нягтлан бодох бүртгэлийн өндөр чанартай стандартуудыг тогтоох, тэдгээрийн мөрдөлт ба хэрэгжүүлэлтэнд туслалцаа үзүүлэх, ингэснээр дэлхий дахины практикын чанар ба тууштай байдлыг сайжруулах, улсын секторын санхүүгийн ил тод, хариуцлагатай байдлыг бэхжүүлэх замаар олон нийтийн эрх ашигт үйлчлэх явдал юм.

Энэхүү зорилтыг биелүүлэхийн тулд УСНББОУСЗ нь улсын секторын байгууллагууд, үүн дотроо үндэсний, бүсийн, орон нутгийн засгийн газрууд болон засгийн газрын холбогдох агентлагууд ашиглахад зориулсан УСНББОУС-ууд™ ба Санал Болгосон Практик Удирдамж (СБПУ)-уудыг гаргадаг.

УСНББОУС нь нийтлэг зорилготой санхүүгийн тайлан (санхүүгийн тайлан)-д хамааралтай бөгөөд бүрэн эрхтэй байдаг. СБПУ-ууд нь санхүүгийн тайланг биш, харин нийтлэг зориулалттай санхүүгийн тайлан илтгэл (НЗСТИ)-ийг бэлтгэх сайн практикын талаархи заавар удирдамжаар хангадаг тунхаглалууд юм. УСНББОУС-аас ялгаатай нь, СБПУ нь шаардлагуудыг тогтоодоггүй. Санхүүгийн тайлан биш, харин НЗСТИ-тэй холбоотой бүх тунхаглалууд нь одоогоор СБПУ-ууд байна. СБПУ-ууд нь мэдээлэлд хамаарах баталгааны (хэрэв байгаа бол) түвшний талаархи заавар удирдамжаар хангадаггүй.

УСНББОУСЗ-ийн үйл ажиллагаагаа явуулах бүтэц болон үйл явцад Дэлхийн Нягтлан Бодогчдын Холбоо™ (ДНБХ™) дэмжлэг үзүүлдэг.

Зохиогчийн эрх © 2019 оны 01 дүгээр сар, Дэлхийн Нягтлан Бодогчдын Холбоо (ДНБХ). Зохиогчийн эрх, худалдааны тэмдэг, зөвшөөрлийн талаархи мэдээллийг [70-р хуудаснаас](#) үзнэ үү.

УСНББОУС 42–НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТЭТГЭМЖ

АГУУЛГА

	Параграф
Зорилго	1-2
Цар хүрээ	3-4
Тодорхойлолт	5
Ерөнхий хандлага	6-25
Нийгмийн халамжийн тэтгэмжийн хөтөлбөрийн өр төлбөрийн хүлээн зөвшөөрөлт	6-9
Нийгмийн халамжийн тэтгэмжийн хөтөлбөрийн зардлын хүлээн зөвшөөрөлт	10-11
Нийгмийн халамжийн тэтгэмжийн хөтөлбөрийн өр төлбөрийн хэмжилт	12-20
Нийгмийн халамжийн тэтгэмжийн хөтөлбөрийн зардлын хэмжилт	21
Тодруулга	22-25
Даатгалын хандлага	26-31
Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт	26-28
Тодруулга	29-31
Байгууллагын санхүүгийн урт хугацааны тогтвортой байдлын тайлагнал	32
Шилжилтийн нөхцлүүд	33-34
Ерөнхий хандлага	33
Даатгалын хандлага	34
Хүчин төгөлдөр болох хугацаа	35-36
Мөрдөх заавар удирдамж	
Бусад УСНББОУС-уудад оруулсан нэмэлт өөрчлөлтүүд	
Дүгнэлтийн үндэслэл	
Хэрэгжүүлэх заавар удирдамж	
Үлгэрчилсэн жишээ	
ЗГСС-тай харьцуулалт	

Зорилго

1. Энэ Стандартын зорилго нь түүнд тодорхойлсон нийгмийн халамжийн тэтгэмжийн талаар тухайн тайлагнагч байгууллага өөрийн санхүүгийн тайландаа тусган харуулдаг тэрхүү мэдээллийн хамааралтай, үнэн зөв ба зэрэгцүүлэгдэх боломжтой байдлыг сайжруулахад оршино. Тусган харуулах мэдээлэл нь санхүүгийн тайлангийн болон нийтлэг зорилготой санхүүгийн тайлан илтгэлийн хэрэглэгч нар дараах зүйлсийг үнэлэхэд туслалцаа үзүүлнэ:
 - (а) Тухайн байгууллагын олгох нийгмийн халамжийн тэтгэмжийн шинж төрөл;
 - (б) Тэдгээр нийгмийн халамжийн тэтгэмжийн хөтөлбөрийн үйл ажиллагааны гол онцлог;
 - (в) Үзүүлсэн нийгмийн халамжийн тэтгэмж нь тухайн байгууллагын санхүүгийн үр дүн, санхүүгийн байдал, мөнгөн гүйлгээнд үзүүлэх үр нөлөө.
2. Эдгээр зорилтыг хэрэгжүүлэхийн тулд энэхүү УСНББОУС нь доорх зүйлсэд хамаарах зарчим ба шаардлагуудыг тогтоодог:
 - (а) Нийгмийн халамжийн тэтгэмжийн зардал ба өр төлбөрийг хүлээн зөвшөөрөх;
 - (б) Нийгмийн халамжийн тэтгэмжийн зардал ба өр төлбөрийг хэмжих;
 - (в) Нийгмийн халамжийн тэтгэмжийн талаархи мэдээллийг санхүүгийн тайланд толилуулах;
 - (г) Тайлагнагч байгууллагын үзүүлдэг нийгмийн халамжийн тэтгэмжийн шинж төрөл ба санхүүгийн үр нөлөөг үнэлэх боломжийг санхүүгийн тайлангийн хэрэглэгчдэд олгохын тулд ямар мэдээллийг тодруулах эсэхийг тодорхойлох.

Цар хүрээ

3. Нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурийн дагуу санхүүгийн тайлангаа бэлтгэж, толилуулдаг байгууллага нь нийгмийн халамжийн тэтгэмжийг тайлагнахдаа энэ Стандартыг мөрдөнө.
4. Нийгмийн халамжийн тэтгэмжийн тодорхойлолтыг хангадаг ажил гүйлгээнд энэ Стандартыг мөрдөнө. Доорх бусад Стандартын дагуу тайлагнадаг мөнгөн шилжүүлгийн хувьд энэ Стандартыг мөрдөхгүй:
 - (а) УСНББОУС 41, *Санхүүгийн Хэрэглүүр* (байгууллага нь УСНББОУС 41-ийг мөрдөхийн өмнө, УСНББОУС 29, *Санхүүгийн Хэрэглүүр: Хүлээн Зөвшөөрөлт ба Хэмжилт*)-ийн цар хүрээнд хамаарах санхүүгийн хөрөнгө;
 - (б) УСНББОУС 39, *Ажилтны Тэтгэмж*-ийн цар хүрээнд хамаарах ажилтны тэтгэмж;
 - (в) Даатгалын гэрээг зохицуулдаг олон улсын буюу үндэсний нягтлан бодох бүртгэлийн холбогдох стандартын цар хүрээнд хамаарах даатгалын гэрээнүүд.

Энэхүү Стандартын цар хүрээний талаархи нэмэлт заавар удирдамжийг МЗУ1-МЗУ3-р параграфт харуулав.

Тодорхойлолт

5. Энэ Стандартад дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгож хэрэглэнэ:

Нийгмийн халамжийн тэтгэмж нь дараах байдлаар олгодог мөнгөн шилжүүлэг юм:

- (а) Зохих шалгуурыг хангасан тусгай хувь хүн ба/буюу айл өрхөд;
- (б) Нийгмийн эрсдлийн үр нөлөөг бууруулахын тулд;
- (в) Нийгмийн хэрэгцээ шаардлагыг бүхэлд нь авч үзэх үүднээс.

Энэхүү тодорхойлолтын талаархи нэмэлт заавар удирдамжийг МЗУ4-МЗУ8-р параграфт харуулав.

Нийгмийн эрсдэл гэдэг нь дараах үйл явдал буюу нөхцөл байдал юм:

- (а) Хувь хүн ба/буюу өрхийн шинж байдалтай, тухайлбал нас, эрүүл мэнд, ядуурал, ажил эрхлэлтийн байдалтай холбоотой;
- (б) Хувь хүн ба/буюу өрхийн мөнгө нөөцөд нэмэлт эрэлт хэрэгцээ үүсгэх эсвэл тэдний орлогыг бууруулах байдлаар хувь хүн ба/буюу өрхийн аж байдалд сөргөөр нөлөөлж болох.

Нийгмийн эрсдэлд юу хамаарах эсэх талаархи нэмэлт заавар удирдамжийг МЗУ9-МЗУ10-р параграфт тусгав.

Ерөнхий хандлага

Нийгмийн халамжийн тэтгэмжийн хөтөлбөрийн өр төлбөрийн хүлээн зөвшөөрөлт

- 6. Дараах тохиолдолд байгууллага нь нийгмийн халамжийн тэтгэмжийн хөтөлбөрийн хувьд өр төлбөрийг хүлээн зөвшөөрнө:
 - (а) Байгууллага нь өнгөрсөн үйл явдлын үр дүнд нөөцийг гадагш зарцуулах одоогийн үүрэгтэй байх; ба
 - (б) Чанарын шинжүүдийг биелүүлэх ба *Улсын Секторын Байгууллагуудын Нийтлэг Зорилготой Санхүүгийн Тайлагналын Онолын Үзэл Баримтлал*-д заасан, нийтлэг зорилготой тайлан илтгэл дэх мэдээллийн хязгаарлагдмал байдлыг харгалзах байдлаар одоогийн үүргийг хэмжиж чадах.

Нөөцийн зарлагын гүйлгээ

- 7. Өр төлбөр нь түүнийг барагдуулахын тулд тухайн байгууллагаас хийгдэх нөөцийн зарлагын гүйлгээг агуулсан байх ёстой. Тухайн байгууллагаас нөөцийн зарлагын гүйлгээ хийхгүйгээр барагдуулж болох үүрэг нь өр төлбөр биш юм.
- 8. Өр төлбөрийн хэмжилтэй холбоотой тодорхойгүй байдал үүсэж болох юм. Тооцоолол ашиглалт нь нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурийн нэг чухал хэсэг байдаг. Нөөцийн зарлагын гүйлгээний талаархи тодорхойгүй байдлын түвшин нь хамааралтай ба үнэн зөв илэрхийлэл гэсэн чанарын шинжүүд биелэгдэхгүй болоход хүргэх тийм өндөр байхаас бусад тохиолдолд тодорхойгүй байдал нь өр төлбөрийн хүлээн зөвшөөрөлтөнд саад учруулахгүй. Тодорхойгүй байдлын түвшин нь өр төлбөрийн хүлээн зөвшөөрөлтөнд саад учруулахгүй байх тохиолдолд уг өр төлбөрийг хэмжихдээ түүнийг харгалзан үзнэ.

Өнгөрсөн үйл явдал

- 9. Нийгмийн халамжийн тэтгэмжийн хөтөлбөрийн өр төлбөр үүсэхэд хүргэдэг өнгөрсөн үйл явдал нь нийгмийн халамжийн тэтгэмж авах бүх зохих шалгуурыг тухайн тэтгэмж авагч бүр ханган биелүүлэх явдал юм. Нийгмийн халамжийн тэтгэмж бүрийн зохих шалгуурын хангалалт нь өнгөрсөн, тусдаа үйл явдал юм.

Өр төлбөрийн хүлээн зөвшөөрөлтийн талаархи нэмэлт заавар удирдамжийг МЗУ11-МЗУ14-р параграфт харуулав.

Нийгмийн халамжийн тэтгэмжийн хөтөлбөрийн зардлын хүлээн зөвшөөрөлт

- 10. Байгууллага нь өр төлбөрийг хүлээн зөвшөөрөх тухайн агшинд нийгмийн халамжийн хөтөлбөрийн хувьд зардлыг хүлээн зөвшөөрнө.

УСНББОУС 42-НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТЭТГЭМЖ

11. Байгууллага нь дараагийн төлбөр хийх бүх зохих шалгуур хангагдахаас өмнө нийгмийн халамжийн тэтгэмжийн төлбөр хийсэн тохиолдолд үүнийг нийгмийн халамжийн тэтгэмжийн хөтөлбөрийн зардал гэж хүлээн зөвшөөрөхгүй. Харин байгууллага нь уг дүн буцаан нөхөгдөхгүй байхаас бусад тохиолдолд тэрхүү урьдчилсан төлбөрийг санхүүгийн байдлын тайланд хөрөнгө гэж хүлээн зөвшөөрнө. Урьдчилсан төлбөр нь буцаан нөхөгдөхөөргүй бол түүнийг зардал гэж хүлээн зөвшөөрнө.

Нийгмийн халамжийн тэтгэмжийн хөтөлбөрийн өр төлбөрийн хэмжилт

Өр төлбөрийн анхны хэмжилт

12. **Нийгмийн халамжийн тэтгэмжийн өр төлбөрөөр илэрхийлэгдэх одоогийн үүргийг ханган биелүүлэхэд тухайн байгууллагын гаргах өртөг зардлын (өөрөөр хэлбэл, нийгмийн халамжийн тэтгэмжийн төлбөрийн) хамгийн сайн тооцооллын дүнгээр уг өр төлбөрийг хэмжинэ.**
13. Уг өртөг зардлын (өөрөөр хэлбэл, нийгмийн халамжийн тэтгэмжийн төлбөрийн) талаар байгууллагын хийх хамгийн сайн тооцоолол нь тэдгээр нийгмийн халамжийн тэтгэмжийн төлбөрт дараагийн тайлант үеийн үйл явдлуудын үзүүлэх боломжит үр нөлөөг харгалзан тусгасан байна.
14. Нийгмийн халамжийн тэтгэмжийн хөтөлбөрийн хувьд өр төлбөрийг хүлээн зөвшөөрсөн тайлант үеийн эцсээс хойшхи арван хоёр сарын дотор тухайн өр төлбөрийг барагдуулахаар хүлээгдээгүй (өөрөөр хэлбэл, нийгмийн халамжийн тэтгэмжийн дараагийн төлбөрийг арван хоёр сараас урт хугацаанд хийхээргүй) бол 19-р параграфт тусгайлан заасан, дискаунтын хувийг ашигласнаар тэрхүү өр төлбөрийг дискаунтчилна.
15. Өр төлбөрийг хэмжих талаархи нэмэлт заавар удирдамжийг МЗУ15-МЗУ18-р параграфт тусгасан.

Дараагийн тайлант үеийн хэмжилт

16. **Нийгмийн халамжийн тэтгэмжийг төлснөөр тухайн нийгмийн халамжийн тэтгэмжийн хөтөлбөрийн өр төлбөрийг бууруулна. Нийгмийн халамжийн тэтгэмжийн төлбөр барагдуулах өртөг зардал ба нийгмийн халамжийн тэтгэмжийн хөтөлбөрт хамаарах тухайн өр төлбөрийн дансны үнэ хоорондох аливаа зөрүүг тэрхүү өр төлбөрийг барагдуулсан тайлант үед ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.**
17. **Өр төлбөрийг 14-р параграфын дагуу дискаунтчилдаг тохиолдолд дискаунтын нөлөөллийн багасалтыг тусгахын тулд уг өр төлбөрийг барагдуулах хүртэл тайлант үе бүрд өр төлбөрийг нэмэгдүүлж, хүүний зардлыг хүлээн зөвшөөрнө.**
18. **Өр төлбөрийг харахан төлж барагдуулаагүй байгаа тохиолдолд тайлант үе бүрийн эцэст өр төлбөрийг нягталж шалгах ба тэрхүү өр төлбөрөөр илэрхийлэгдэх одоогийн үүргийг биелүүлэхийн тулд байгууллагын гаргах өртөг зардлын (өөрөөр хэлбэл, нийгмийн халамжийн тэтгэмжийн төлбөрүүдийн) одоогийн хамгийн сайн тооцооллыг тусгахын тулд залруулга хийнэ.**

Дискаунтын хувь

19. **Нийгмийн халамжийн тэтгэмжийн хөтөлбөртэй холбоотой өр төлбөрийг дискаунтчилахад ашигласан дискаунтын хувь нь мөнгөний цаг хугацааны үнэ цэнийг тусгасан байна. Мөнгөний цаг хугацааны үнэ цэнийг тусгахын тулд сонгосон санхүүгийн хэрэглүүрийн валют ба нөхцөл нь нийгмийн халамжийн тэтгэмжийн өр төлбөрийн валют болон тооцоолсон нөхцөлтэй нийцсэн байвал зохино.**
20. Ашиглах дискаунтын хувийн талаархи нэмэлт заавар удирдамжийг МЗУ18-р параграфт тусгасан.

Нийгмийн халамжийн тэтгэмжийн хөтөлбөрийн зардлын хэмжилт

21. **Нийгмийн халамжийн тэтгэмжийн хөтөлбөрийн хувьд байгууллага нь зардлыг 12-р параграфын дагуу хэмжсэн өр төлбөрийн дүнтэй тэнцүү дүнгээр анх хэмжинэ. Байгууллага нь дараагийн төлбөр хийх бүх зохих шалгуур хангагдахаас өмнө нийгмийн халамжийн тэтгэмжийн төлбөр хийсэн тохиолдолд тус байгууллага нь 11-р параграфын дагуу хүлээн зөвшөөрсөн урьдчилгаа төлбөр буюу зардлыг уг шилжүүлсэн мөнгөний дүнгээр хэмжинэ.**

Тодруулга

22. **Санхүүгийн байдлын тайлан, санхүүгийн үр дүнгийн тайлан, цэвэр хөрөнгө/өмчийн тайлан, мөнгөн гүйлгээний тайланд тусгасан мэдээллийн хамтаар ерөнхий хандлагын дагуу хийх тодруулгын зорилго нь байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээнд тэрхүү нийгмийн халамжийн тэтгэмжийн үзүүлж болох үр нөлөөг үнэлэх суурь үндэслэлээр тухайн санхүүгийн тайлангийн хэрэглэгчдийг хангах боломжийг уг байгууллагад олгох явдал юм. Энэхүү зорилгыг хэрхэн ханган биелүүлэх талаархи шаардлагуудыг 23-25-р параграфт тусгайлан заасан болно.**
23. **Байгууллага нь дараах мэдээллийг тодруулна:**
- (a) **Түүний нийгмийн халамжийн тэтгэмжийн хөтөлбөрийн шинж чанаруудыг тайлбарлах; ба**
 - (б) **Түүний нийгмийн халамжийн тэтгэмжийн хөтөлбөрт нөлөөлж болох хүн ам зүйн, эдийн засгийн болон бусад гаднын хүчин зүйлсийг тайлбарлах.**
24. 23-р параграфын шаардлагуудыг хангахын тулд байгууллага нь дараах зүйлсийг тодруулна:
- (a) **Нийгмийн халамжийн тэтгэмжийн хөтөлбөрийн шинж чанаруудын талаархи мэдээлэл, үүнд:**
 - (i) **Тухайн хөтөлбөрөөр олгох нийгмийн халамжийн тэтгэмжийн шинж төрөл (жишээлбэл; тэтгэврийн тэтгэмж, ажилгүйдлийн тэтгэмж, хүүхдийн тэтгэмж).**
 - (ii) **Нийгмийн халамжийн тэтгэмжийн хөтөлбөрийн гол онцлог шинжүүд, үүнд: тухайн хөтөлбөрийг зохицуулдаг эрх зүйн хүрээний тайлбар тодорхойлолт, уг нийгмийн халамжийн тэтгэмжийг хүлээн авахын тулд хангах шаардлагатай зохих гол шалгуурын товч тойм, хөтөлбөрийн талаархи нэмэлт мэдээллийг хэрхэн олж авч болох талаархи нэмэлт мэдээлэл.**
 - (iii) **Хөтөлбөрийг хэрхэн санхүүжүүлэх талаархи тайлбар тодорхойлолт, үүнд: хөтөлбөрийн санхүүжилтийг төсвийн хуваарилалтаар, улсын секторын өөр байгууллагаас олгох шилжүүлгээр эсвэл бусад арга хэрэгслээр бүрдүүлдэг эсэх. Хэрэв хөтөлбөрийг нийгмийн даатгалын шимтгэлээр (бүрэн буюу хэсэгчлэн) санхүүжүүлдэг бол тухайн байгууллага нь дараах зүйлсийг ханган бүрдүүлнэ:**
 - a. **Тэдгээр нийгмийн даатгалын шимтгэл болон аливаа зориулагдсан хөрөнгийн талаархи мэдээллийн байршилд хийсэн (энэхүү мэдээллийг тухайн байгууллагын санхүүгийн тайланд хаана нь тусгасан эсэх) харилцан лавлагаа; эсвэл**
 - б. **Өөр байгууллагын санхүүгийн тайлан дахь тэдгээр нийгмийн даатгалын шимтгэл болон аливаа зориулагдсан хөрөнгийн талаархи мэдээллийн бэлэн боломжтой байдал ба уг мэдээллийг хэрхэн олж авах тухай мэдэгдэл.**
 - (iv) **Нийгмийн халамжийн тэтгэмжийн хөтөлбөрийн дагуу гарах зарлагын түвшинд нөлөө үзүүлэх хүн ам зүй, эдийн засгийн гол хүчин зүйлс болон бусад гаднын хүчин зүйлсийн талаархи тайлбар тодорхойлолт. Тухайн нэг хүн ам зүйн, эдийн засгийн хүчин зүйлс болон бусад гаднын хүчин зүйлс нь нийгмийн халамжийн**

УСНББОУС 42-НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТЭТГЭМЖ

тэтгэмжийн олон хөтөлбөрт ижил төсөөтэй байдлаар нөлөө үзүүлдэг тохиолдолд энэхүү тайлбар тодорхойлолтыг нэгтгэсэн байдлаар толилуульж болох юм.

- (б) Санхүүгийн үр дүнгийн тайланд хүлээн зөвшөөрсөн нийгмийн халамжийн тэтгэмжийн нийт зарлагыг тухайн нийгмийн халамжийн тэтгэмжийн хөтөлбөр бүрээр задалж шинжилнэ.
- (в) Тайлант үеийн туршид нийгмийн халамжийн тэтгэмжийн хөтөлбөрт хийсэн аливаа мэдэгдэхүйц нэмэлт өөрчлөлтийн тайлбар тодорхойлолтыг уг нэмэлт өөрчлөлтийн хүлээгдэж буй үр дүнгийн тайлбар тодорхойлолтын хамт тодруулна. Нийгмийн халамжийн тэтгэмжийн хөтөлбөрийн нэмэлт өөрчлөлтүүдэд доорх зүйлс хамаарах боловч үүгээр хязгаарлагдахгүй:
 - (i) Үзүүлсэн нийгмийн халамжийн тэтгэмжийн түвшний өөрчлөлтүүд; ба
 - (ii) Зохих шалгуурын, үүн дотроо нийгмийн халамжийн тэтгэмжийн хөтөлбөрт хамаарах хувь хүн ба/буюу өрхийн өөрчлөлтүүд.

Энэ параграфтаар шаардсан тодруулгыг хийхдээ, байгууллага нь материаллаг байдал ба нэгтгэн нийлүүлэлтийн талаархи заавар удирдамжаар хангадаг УСНББОУС 1, *Санхүүгийн Тайлангийн Толилуулга*-ын 45-47-р параграфын шаардлагуудыг харгалзан үзнэ.

- 25. Хэрэв нийгмийн халамжийн тэтгэмжийн хөтөлбөр нь даатгалын хандлага ашиглахыг зөвшөөрдөг 28-р параграфын шаардлагыг хангадаг бол энэ тухай мэдэгдэн илэрхийлнэ.

Даатгалын хандлага

Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт

- 26. **Нийгмийн халамжийн тэтгэмжийн хөтөлбөр нь 28-р параграфт заасан шалгуурыг хангадаг тохиолдолд даатгалын гэрээг зохицуулдаг олон улсын буюу үндэсний нягтлан бодох бүртгэлийн холбогдох стандартын шаардлагуудыг адилтган мөрдсөнөөр байгууллага нь нийгмийн халамжийн тэтгэмжийн хөтөлбөртэй холбоотой хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлыг хүлээн зөвшөөрч, хэмжихийг түүнд зөвшөөрдөг боловч заавал мөрдөхийг шаардахгүй¹.**

Даатгалын гэрээг зохицуулдаг бөгөөд нийгмийн халамжийн тэтгэмжийн тайлагналд адилтган мөрдөж болох нягтлан бодох бүртгэлийн стандартуудын талаархи нэмэлт заавар удирдамжийг МЗУ19-р параграфт тусгасан.

- 27. Байгууллага нь даатгалын гэрээг зохицуулдаг олон улсын буюу үндэсний нягтлан бодох бүртгэлийн холбогдох стандартын шаардлагуудыг адилтган мөрдөхгүй байх сонголт хийсэн тохиолдолд тус байгууллага нь уг нийгмийн халамжийн тэтгэмжийн хөтөлбөртэй холбоотой өр төлбөр болон зардлыг хүлээн зөвшөөрч, хэмжих ба энэ Стандартын 6-25-р параграфын дагуу тухайн санхүүгийн тайланд тодруулгыг тусган оруулна.
- 28. Дараах тохиолдолд байгууллага нь даатгалын гэрээг зохицуулдаг олон улсын буюу үндэсний нягтлан бодох бүртгэлийн холбогдох стандартын шаардлагуудыг адилтган мөрдсөнөөр нийгмийн халамжийн тэтгэмжийн хөтөлбөртэй холбоотой хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлыг хүлээн зөвшөөрч, хэмжиж болох юм:
 - (а) Тухайн нийгмийн халамжийн тэтгэмжийн хөтөлбөрийг нийгмийн даатгалын шимтгэлээр бүрэн санхүүжүүлэх санаа зорилготой байх; ба

¹ Энэ Стандартын даатгалын хандлага хэсэг дэх “даатгалын гэрээг зохицуулдаг олон улсын буюу үндэсний нягтлан бодох бүртгэлийн холбогдох стандарт” гэсэн нэр томъёо нь СТОУС 17, *Даатгалын гэрээ* болон СТОУС 17-той бараг ижил зарчмыг баримталдаг үндэсний стандартуудыг илэрхийлнэ.

УСНББОУС 42-НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТЭТГЭМЖ

- (б) Байгууллага нь даатгалын гэрээ гаргагчтай ижил арга замаар хөтөлбөрийг удирддаг, үүн дотроо уг хөтөлбөрийн санхүүгийн үр дүн ба санхүүгийн байдлыг тогтмол үнэлдэг гэсэн нотолгоотой байх.

Эдгээр шалгуур хангагдсан эсэхийг тодорхойлох талаархи нэмэлт заавар удирдамжийг МЗУ20-МЗУ25-р параграфт тусгасан

Тодруулга

29. Санхүүгийн байдлын тайлан, санхүүгийн үр дүнгийн тайлан, цэвэр хөрөнгө/өмчийн тайлан, мөнгөн гүйлгээний тайланд тусгасан мэдээллийн хамтаар даатгалын хандлагын дагуу хийх тодруулгын зорилго нь байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээнд тэрхүү нийгмийн халамжийн тэтгэмжийн үзүүлж болох үр нөлөөг үнэлэх суурь үндэслэлээр тухайн санхүүгийн тайлангийн хэрэглэгчдийг хангах боломжийг уг байгууллагад олгох явдал юм. Энэхүү зорилгыг хэрхэн ханган биелүүлэх талаархи шаардлагуудыг 30, 31-р параграфт тусгайлан заасан болно.
30. Байгууллага нь даатгалын гэрээг зохицуулдаг олон улсын буюу үндэсний нягтлан бодох бүртгэлийн холбогдох стандартын шаардлагуудыг адилтган мөрдсөнөөр нийгмийн халамжийн тэтгэмжийн хөтөлбөртэй холбоотой хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлыг хүлээн зөвшөөрч, хэмждэг тохиолдолд тухайн байгууллага нь дараах зүйлсийг тодруулна:
- (а) Даатгалын хандлага тохиромжтой эсэхийг тодорхойлох суурь үндэслэл;
 - (б) Даатгалын гэрээг зохицуулдаг олон улсын буюу үндэсний нягтлан бодох бүртгэлийн холбогдох стандартаар шаардсан мэдээлэл; ба
 - (в) Энэ Стандартын 31-р параграфтаар шаардсан аливаа нэмэлт мэдээлэл.
31. Энэ Стандартын 30(в) параграфын шаардлагуудыг хангахын тулд байгууллага нь дараах зүйлсийг тодруулна:
- (а) Нийгмийн халамжийн тэтгэмжийн хөтөлбөрийн шинж чанаруудын талаархи мэдээлэл, үүнд:
 - (i) Тухайн хөтөлбөрөөр олгох нийгмийн халамжийн тэтгэмжийн шинж төрөл (жишээлбэл; тэтгэврийн тэтгэмж, ажилгүйдлийн тэтгэмж, хүүхдийн тэтгэмж); ба
 - (ii) Нийгмийн халамжийн тэтгэмжийн хөтөлбөрийн гол онцлог шинжүүд, үүнд: тухайн хөтөлбөрийг зохицуулдаг эрх зүйн хүрээний тайлбар тодорхойлолт, уг нийгмийн халамжийн тэтгэмжийг хүлээн авахын тулд хангах шаардлагатай зохих гол шалгуурын товч тойм, хөтөлбөрийн талаархи нэмэлт мэдээллийг хэрхэн олж авч болох талаархи нэмэлт мэдээлэл;
 - (б) Тайлант үеийн туршид нийгмийн халамжийн тэтгэмжийн хөтөлбөрт хийсэн аливаа мэдэгдэхүйц нэмэлт өөрчлөлтийн тайлбар тодорхойлолтыг уг нэмэлт өөрчлөлтийн хүлээгдэж буй үр дүнгийн тайлбар тодорхойлолтын хамт тодруулна. Нийгмийн халамжийн тэтгэмжийн хөтөлбөрийн нэмэлт өөрчлөлтүүдэд доорх зүйлс хамаарах боловч үүгээр хязгаарлагдахгүй:
 - (i) Үзүүлсэн нийгмийн халамжийн тэтгэмжийн түвшний өөрчлөлтүүд; ба
 - (ii) Зохих шалгуурын, үүн дотроо нийгмийн халамжийн тэтгэмжийн хөтөлбөрт хамаарах хувь хүн ба/буюу өрхийн өөрчлөлтүүд.

Энэ параграфтаар шаардсан тодруулгыг хийхдээ, байгууллага нь материаллаг байдал ба нэгтгэн нийлүүлэлтийн талаархи заавар удирдамжаар хангадаг УСНББОУС 1-ийн 45-47-р параграфын шаардлагуудыг харгалзан үзнэ.

Байгууллагын санхүүгийн урт хугацааны тогтвортой байдлын тайлагнал

32. Нийгмийн халамжийн тэтгэмж бүхий байгууллагууд нь өөрсдийн санхүүгийн урт хугацааны тогтвортой байдлын талаархи мэдээллээр хангах нийтлэг зорилготой санхүүгийн тайлан илтгэл бэлтгэхийг сайшаан дэмждэг боловч заавал шаарддаггүй. Санал Болгосон Практик Удирдамж (СБПУ) 1, *Байгууллагын Санхүүгийн Урт Хугацааны Тогтвортой Байдлын Тайлагнал* нь ийм тайлан илтгэлийг бэлтгэх талаархи заавар удирдамжаар хангадаг.

Шилжилтийн нөхцлүүд

Ерөнхий хандлага

33. Ерөнхий хандлагын (6-25-р параграфыг үзнэ үү) дагуу хүлээн зөвшөөрч, хэмжсэн ба тодруулга хийсэн нийгмийн халамжийн тэтгэмжийн хөтөлбөрийн тайлагналын хувьд байгууллага нь УСНББОУС 3, *Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлого, Нягтлан Бодох Бүртгэлийн Тооцооллын Өөрчлөлт ба Алдаа*-нд заасанчлан, энэхүү Стандартыг буцаах горимоор мөрдөнө.

Даатгалын хандлага

34. Даатгалын хандлагын (26-31-р параграфыг үзнэ үү) дагуу хүлээн зөвшөөрч, хэмжсэн ба тодруулга хийсэн нийгмийн халамжийн тэтгэмжийн хөтөлбөрийн тайлагналын хувьд байгууллага нь даатгалын гэрээг зохицуулдаг олон улсын буюу үндэсний нягтлан бодох бүртгэлийн холбогдох стандартын шилжилтийн нөхцлүүдийг мөрдөнө.

Хүчин төгөлдөр болох хугацаа

35. Байгууллага нь энэ Стандартыг 2022 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамарсан жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2022 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед энэ Стандартыг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийнэ.
36. УСНББОУС 33, *Аккруэл Суурьт Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Анх Удаа Мөрдөх*-д тодорхойлсон, нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурьт УСНББОУС-ыг байгууллага нь энэхүү хүчин төгөлдөр болох хугацаанаас хойш, санхүүгийн тайлагналын зорилгоор мөрдсөн тохиолдолд УСНББОУС-ыг мөрдсөн өдөр буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах уг байгууллагын жилийн санхүүгийн тайланд энэ Стандартыг мөрдөнө.

Хавсралт А

Мөрдөх заавар удирдамж

Энэ хавсралт нь УСНББОУС 42-ын салшгүй бүрэлдэхүүн хэсэг юм.

Цар хүрээ (3-4-р параграфыг үзнэ үү)

- МЗУ1. Энэ Стандартын 5-р параграфт заасан, нийгмийн халамжийн тэтгэмжийн тодорхойлолтыг хангадаг ажил гүйлгээ болон үүргийн тайлагналд энэхүү Стандартыг мөрдөнө. Бусад Стандартаар зохицуулдаг ажилтны тэтгэмж (УСНББОУС 39, *Ажилтны Тэтгэмж*-ийн дагуу тайлагнадаг), түүнчлэн оюутны зээл гэх мэт хөнгөлөлттэй зээлтэй холбоотой (УСНББОУС 41, *Санхүүгийн Хэрэглүүр*-ийн (байгууллага нь УСНББОУС 41-ийг мөрдөхийн өмнө УСНББОУС 29, *Санхүүгийн Хэрэглүүр: Хүлээн Зөвшөөрөлт ба Хэмжилт*-ийн) дагуу тайлагнадаг) ажил гүйлгээг энэ Стандартад авч үзэхгүй.
- МЗУ2. Даатгалын гэрээнд хамаарах эрсдэл нь энэ Стандартын 5-р параграфт тодорхойлсон, нийгмийн эрсдэл байлаа ч гэсэн даатгалын гэрээнд энэ Стандартыг мөн адил мөрдөхгүй. Даатгалын гэрээг зохицуулдаг олон улсын буюу үндэсний нягтлан бодох бүртгэлийн холбогдох стандартын дагуу даатгалын гэрээг тайлагнана.
- МЗУ3. Энэ Стандартыг хамтын болон хувийн үйлчилгээнд мөрдөхгүй. Нийгмийн халамжийн тэтгэмжийн тодорхойлолт нь үзүүлэх үйлчилгээг биш, харин мөнгөн шилжүүлгийг зөвхөн агуулдаг. Нийгмийн эрсдэлд чиглээгүй, жишээлбэл; яаралтай тусламж гэх мэт хувь хүн болон айл өрхөд олгох мөнгөн шилжүүлгэд энэ Стандартыг мөрдөхгүй.

Тодорхойлолт (5-р параграфыг үзнэ үү)

Нийгмийн халамжийн тэтгэмжийн тодорхойлолтын талаархи заавар удирдамж

- МЗУ4. Нийгмийн халамжийн тэтгэмж нь хувь хүн ба/буюу айл өрхөд олгодог мөнгөн шилжүүлэг (үүнд: мөнгөтэй адилтгах хөрөнгө хэлбэртэй шилжүүлэг хамаарна, жишээлбэл; урьдчилсан төлбөрт дебит карт) юм. Улсын секторын байгууллагын үзүүлдэг үйлчилгээ нь нийгмийн халамжийн тэтгэмж биш юм. Зарим улс орны хувьд улсын секторын байгууллага нь үйлчилгээнд хандан нэвтрэх боломжийг хувь хүн ба/буюу айл өрхөд олгосон ваучерыг өгдөг, эсвэл тухайн үйлчилгээг ашиглахын тулд гаргасан өртөг зардлыг тэрхүү хувь хүн ба/буюу айл өрхөд нөхөн төлдөг байж болно. Эдгээр ажил гүйлгээний эдийн засгийн мөн чанар нь тухайн үзүүлсэн үйлчилгээний төлбөрийг улсын секторын байгууллага төлж байгаа гэсэн утгатай болно; иймээс уг ажил гүйлгээ нь нийгмийн халамжийн тэтгэмжийн тодорхойлолтыг хангахгүй. Улсын секторын байгууллага нь ваучер олгох эсвэл зардлыг нөхөн төлөх тохиолдолд тухайн хувь хүн ба/буюу айл өрх нь тэтгэмжийг ашиглах талаар өөрийн сонголт, эрх мэдэлгүй байдаг. Харин эсрэгээр, нийгмийн халамжийн тэтгэмж нь бусад эх үүсвэрээс орж буй орлогоос үл ялгагдах байдлаар ашиглаж болох мөнгөн шилжүүлэг олгодог.
- МЗУ5. Зарим улс орон нь мөнгөний ашиглалт зарцуулалтын хувьд цөөн хязгаарлалт бүхий, мөнгөтэй адилтгах хөрөнгө хэлбэрээр мөнгөн шилжүүлгийг олгодог байж болно. Жишээлбэл; засгийн газар нь согтууруулах ундаа, тамхинаас бусад, аливаа зүйлийг худалдан авахад ашиглаж болох урьдчилсан төлбөрт дебит картыг олгож болох юм. Ийм цөөн хязгаарлалт нь бусад эх үүсвэрээс орж буй орлогоос үл ялгагдах байдлаар ашиглаж болох мөнгөн шилжүүлгээр хангадаг нийгмийн халамжийн тэтгэмжийн зарчимтай зөрчилдөхгүй билээ. Цөөн хязгаарлалт бүхий урьдчилсан төлбөрт дебит карт нь засгийн газраас үзүүлэх үйлчилгээ биш, харин мөнгөн шилжүүлэг юм.
- МЗУ6. Нийгмийн халамжийн тэтгэмжийг хүлээн авах зохих шалгуур нь дараагийн төлбөр хийхээс өмнө хангагдсан, зөвхөн тийм тохиолдолд нийгмийн халамжийн тэтгэмжийг олгодог. Жишээлбэл; ажилгүй байх хугацааны орлого нь хүрэлцээгүй тийм хүмүүсийн хэрэгцээг

УСНББОУС 42-НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТЭТГЭМЖ

хангахын тулд засгийн газраас ажилгүйдлийн тэтгэмж олгож болох юм. Ажилгүйдлийн тэтгэмжийн хөтөлбөр нь хүн амыг бүхэлд нь хамардаг байж болох хэдий ч ажилгүйдлийн тэтгэмжийг зөвхөн ажилгүй хүмүүст, өөрөөр хэлбэл зохих шалгуур хангасан хүмүүст олгодог. Гэвч зарим үед тухайлбал, улсын секторын байгууллага нь насанд хүрсэн бүх иргэдэд нийтлэг суурь тэтгэмжийг олгодог тохиолдолд зохих шалгуур нь бүр иргэд буюу оршин суугчдад хамааралтай байж болно.

- МЗУ7. Нийгмийн эрсдлийн үр нөлөөг бууруулахын тулд тэтгэмж олгож буй эсэх үнэлгээг тухайн нийгмийг бүхэлд нь харгалзан лавлагаа болгосноор хийдэг; тэтгэмж нь түүнийг хүлээн авагч нэг бүрийн хувьд нийгмийн эрсдлийн үр нөлөөг бууруулах албагүй юм. Жишээлбэл; тэтгэвэрт гарсны дараа орлого нь хүрэлцээгүй тийм хүмүүсийн хэрэгцээг хангахын тулд засгийн газар нь орлого, хөрөнгө чинээнээс үл хамааран тодорхой наснаас дээш насны бүх хүмүүст тэтгэврийн тэтгэмж олгодог. Ийм тэтгэмж нь нийгмийн эрсдлийн үр нөлөөг бууруулахын тулд олгох гэсэн тодорхойлолтын шалгуурыг хангадаг.
- МЗУ8. Нийгмийн хэрэгцээ шаардлагыг бүхэлд нь авч үзсэн гэдгийг ханган магадлахын тулд нийгмийн халамжийн тэтгэмжийг зохион байгуулдаг. Энэ нь тодорхой хүмүүс буюу бүлэг хүмүүсийн ашиг тусын тулд зохион байгуулдаг даатгалын гэрээгээр олгох тэтгэмжээс энэхүү нийгмийн халамжийн тэтгэмжийг ялган зааглаж өгдөг. Нийгмийн хэрэгцээ шаардлагыг бүхэлд нь авч үзсэнээр тухайн нийгмийн бүх гишүүдийг нийгмийн халамжийн тэтгэмж бүрд хамруулах шаардлага тавихгүй юм; зарим улс орны хувьд нийгмийн янз бүрийн сегментүүдийг хамарсан, ижил төсөөтэй олон төрлийн тэтгэмжээр дамжуулан нийгмийн халамжийн тэтгэмжийг олгодог. Нийгмийн халамжийн илүү өргөн хүрээтэй системийн нэг хэсэг болох нийгмийн тодорхой нэг сегментийг хамарсан нийгмийн халамжийн тэтгэмж нь нийгмийн хэрэгцээ шаардлагыг бүхэлд нь харгалзсан байх гэсэн шаардлагыг ханган биелүүлдэг.

Нийгмийн эрсдлийн тодорхойлолтын талаархи заавар удирдамж

- МЗУ9. Нийгмийн эрсдэл нь хувь хүн ба/буюу өрхийн шинж байдалтай, тухайлбал нас, эрүүл мэнд, ядуурал, ажил эрхлэлтийн байдалтай холбоотой байдаг. Нийгмийн эрсдлийн шинж төрөл нь хувь хүн ба/буюу өрхийн шинж байдалтай шууд холбоотой байдаг. Төлөвлөөгүй буюу хүсээгүй үйл явдалд хүргэх эсвэл түүнд хувь нэмрээ оруулах нөхцөл, үйл явдал, төлөв байдал нь тэрхүү хувь хүн ба/буюу айл өрхийн шинж байдлаас үүсэн бий болдог. Энэ нь нийгмийн эрсдлийг бусад эрсдлээс ялган зааглаж өгдөг. Бусад эрсдлийн хувьд төлөвлөөгүй буюу хүсээгүй үйл явдалд хүргэх эсвэл түүнд хувь нэмрээ оруулах нөхцөл, үйл явдал, төлөв байдал нь тухайн хувь хүн эсвэл өрхийн шинж байдлаас өөр ямар нэг зүйлээс үүсэн бий болдог.
- МЗУ10. Тухайлбал; ажилгүйдлийн тэтгэмжид хамаарах нөхцөл, үйл явдал, төлөв байдал нь хувь хүний шинж байдлаас, энэ тохиолдолд тухайн хүний ажил эрхлэлтийн статусын өөрчлөлтөөс үүдэлтэй тул ажил эрхлэлтийн тэтгэмж нь нийгмийн халамжийн тэтгэмж болно. Харин эсрэгээр, газар хөдлөлтийн дараа, нэн даруй үзүүлэх тусламж нь нийгмийн халамжийн тэтгэмж биш юм. Төлөвлөөгүй буюу хүсээгүй үйл явдалд хүргэх эсвэл түүнд хувь нэмрээ оруулах нөхцөл, үйл явдал, төлөв байдал нь газрын гадаргуун чичрэлт, чулуулгийн эвдрэл бөгөөд эрсдэл нь уг болзошгүй газар хөдлөлтөөр учруулж болох хохирол байдаг. Эрсдэл нь хувь хүн ба/буюу айл өрхтэй биш, харин газар зүйтэй холбоотой тул энэ нь нийгмийн эрсдэл биш юм.

Ерөнхий хандлага (6-21-р параграфыг үзнэ үү)

Нийгмийн халамжийн тэтгэмжийн хөтөлбөрийн өр төлбөрийн хүлээн зөвшөөрөлт

- МЗУ11. Энэхүү Стандартын 9-р параграфт заасанчлан, нийгмийн халамжийн тэтгэмжийн хөтөлбөрийн хувьд өр төлбөр үүсэхэд хүргэдэг өнгөрсөн үйл явдал нь нийгмийн халамжийн тэтгэмж авах бүх зохих шалгуурыг тухайн тэтгэмж авагч бүр ханган биелүүлэх явдал юм. Зохих шалгуурыг хангах ёстой тэрхүү агшинд амьд мэнд байх нь шууд эсвэл шууд бусаар заан илэрхийлэгдэх нэгэн зохих шалгуур байж болох юм. Тасралтгүй ханган биелүүлж байх бусад зохих шалгуур нь нийгмийн халамжийн тэтгэмжийн зарим хөтөлбөрт хамааралтай байж болно. Жишээлбэл; ажилгүйдлийн олон тэтгэмжийг тухайн хувь хүн уг улс оронд оршин сууж байх хугацаанд

УСНББОУС 42-НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТЭТГЭМЖ

зөвхөн олгодог; оршин сууж байх нь тасралтгүй ханган биелүүлэх зохих шалгуур болно. Зохих шалгуурын биелэлтийг цөөн тохиолдолд албан ёсоор шалган баталгаажуулдаг боловч өр төлбөрийг хүлээн зөвшөөрөхийн тулд тэтгэмж авагч нь тэрхүү зохих шалгуурыг (нийгмийн халамжийн тэтгэмжийн төлбөр авах) тухайн тайлангийн өдрөөр буюу түүнээс өмнө хангасан байх ёстой.

МЗУ12. Тэтгэмж авагч нь дараагийн төлбөрийн хувьд тухайн зохих шалгуурыг өмнө нь ханган биелүүлээгүй, эсвэл зохих шалгуурын биелэлтэд тасалдал үүсэж байсан бол дараагийн төлбөрийн зохих шалгуурыг анх хангасан эсвэл бүх зохих шалгуурыг дахин бүрэн ханган биелүүлсэн үед өр төлбөрийг хүлээн зөвшөөрнө. Үүний жишээнд дараах зүйлс хамаарч болох юм:

- (а) Тэтгэврийн насанд хүрэх (тэтгэвэрт гарсны дараах тэтгэврийн хувьд);
- (б) Хань ижил нас барах (тэжээгчээ алдсаны тэтгэмж авах тохиолдолд);
- (в) Ажилгүй болох (хүлээн харгалзах хугацаагүй ажилгүйдлийн тэтгэмжийн хувьд); ба
- (г) Тодорхой хугацаанд ажилгүй байх (хүлээн харгалзах хугацаатай ажилгүйдлийн тэтгэмжийн хувьд).

Тэтгэмж авагч нь зохих шалгуурыг (нийгмийн халамжийн тэтгэмжийн төлбөр авах) тухайн тайлангийн өдрөөр буюу түүнээс өмнө хангадаг тохиолдолд байгууллага нь өр төлбөрийг хүлээн зөвшөөрнө. Тэтгэмж авагч нь нийгмийн халамжийн тэтгэмж авах зохих шалгуурыг уг нийгмийн халамжийн тэтгэмжийн дараагийн төлбөр хийгдэх хугацааны агшнаас өмнө боловч тайлангийн өдрөөс хойш хангадаг тохиолдолд тухайн тайлангийн өдрөөр одоогийн үүрэггүй тул өр төлбөрийг хүлээн зөвшөөрөхгүй.

МЗУ13. Тэтгэмж авагч нь зохих шалгуурыг өмнө нь ханган биелүүлсэн бөгөөд тэдгээр шалгуурын биелэлтэд тасалдал үүсэж байгаагүй бол тухайн зохих шалгуур хангагдан биелэгдэх бүр нийгмийн халамжийн тэтгэмжийн хувьд өр төлбөрийг хүлээн зөвшөөрнө.

МЗУ14. Амьд мэнд байх нь зохих тусдаа шалгуур болох эсэх нь нийгмийн халамжийн тэтгэмжийн бие даасан хөтөлбөр тус бүрийн онцлог шинжээс хамаардаг. Амьд мэнд байх эсэхийг бусад зохих шалгуураар шууд бусаар харгалзан үздэг учраас зарим хөтөлбөрийн хувьд түүнд тусгайлан анхаарал хандуулах шаардлагагүй байдаг. Тухайлбал:

- (а) Ажилгүйдлийн тэтгэмжийг зөвхөн ажилгүй болсон ба ажил хөдөлмөр эрхлэх боломжтой хүмүүст олгодог байж болох юм (энэ нь амьд байгаа гэдгийг шууд бусаар илэрхийлнэ).
- (б) Амьд байх эсэх нь нийгмийн халамжийн тэтгэмж авагчдын хувьд зохих шалгуур биш байж болно. Хүүхдийн мөнгийг эцэг эхэд эсвэл хүүхдийн асран хамгаалагчид олгодог байж болно; тэтгэмжийн төлбөр нь тухайн хүүхэд амьд байгаа эсэхээс хамаардаг боловч эцэг эх эсвэл асран хамгаалагч амьд эсэхээс хамаарахгүй байж болох юм.
- (в) Тухайн тэтгэмж авагч нас барсны дараа амьд үлдсэн тэжээгдэгчид нь тэтгэмжийг шилжүүлэн олгодог байж болно.

Амьд байх нь нийгмийн халамжийн тэтгэмжийн тухайн тодорхой хөтөлбөр тус бүрийн хүлээн зөвшөөрөлтөнд хэрхэн нөлөөлөх эсэхийг байгууллага нь холбогдох бүх хүчин зүйлсийг харгалзсанаар шалгаж үзэх шаардлагатай юм.

Нийгмийн халамжийн тэтгэмжийн хөтөлбөрийн өр төлбөрийн хэмжилт

МЗУ15. Энэ Стандартын 12-р параграфт заасанчлан, нийгмийн халамжийн тэтгэмжийн өр төлбөрөөр илэрхийлэгдэх одоогийн үүргийг ханган биелүүлэхэд тухайн байгууллагын гаргахаар хүлээгдэж буй өртөг зардлын (өөрөөр хэлбэл, нийгмийн халамжийн тэтгэмжийн төлбөрийн) хамгийн сайн тооцооллын дүнгээр байгууллага нь уг өр төлбөрийг хэмжинэ. Нийгмийн халамжийн тэтгэмжийн төлбөр тус бүрт тавигдах зохих шалгуурын ханган биелүүлэлт нь өнгөрсөн тусдаа үйл явдал бөгөөд төлбөр бүрийн хувьд өр төлбөрийг тусад нь хэмждэг. Өр төлбөр гэж хүлээн зөвшөөрөх хамгийн их дүн нь нийгмийн халамжийн тэтгэмжийн дараагийн

УСНББОУС 42-НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТЭТГЭМЖ

төлбөр хийхийн тулд уг байгууллагын гарган зарцуулахаар хүлээж буй өртөг зардал юм. Яагаад гэвэл, үүнээс цааши хугацааны нийгмийн халамжийн тэтгэмжийн төлбөр нь ирээдүйн үйл явдал бөгөөд түүний хувьд одоогийн үүрэг байхгүй.

МЗУ16. Дараагийн төлбөрийн хувьд хангах шаардлагатай зохих шалгуурыг тухайн тэтгэмж авагч нь нийгмийн халамжийн тэтгэмжийн дараагийн төлбөрийн өдрөөс өмнө хангахаа болих тийм боломжит байдлыг байгууллага нь уг өр төлбөрийг хэмжихдээ харгалзан үздэг. Үүний жишээг дурдвал:

- (а) Тухайн тэтгэмж авагч нас барах (амьд үлдсэн тэжээгдэгчид төлөх шимтгэл байхгүй тохиолдолд);
- (б) Ажил эрхэлж эхлэх (ажилгүйдлийн тэтгэмжийн хувьд); ба
- (в) Нийгмийн халамжийн тэтгэмж олгох хамгийн дээд хугацаанаас хэтрэх (ажилгүйдлийн тэтгэмжийг тодорхой хугацаанд олгодог тохиолдолд).

Өр төлбөрийн хэмжилтэнд ийм үйл явдлуудын нөлөөлөх хэмжээ нь тухайн хөтөлбөрийн нөхцлөөс хамаардаг. Жишээлбэл; ажилгүйдлийн тэтгэмжийг сар бүрийн 15-нд төлдөг ба тайлангийн өдөр нь 12-р сарын 31 юм. Хэрэв 01-р сарын 15-нд төлөх төлбөр нь 12-р сарын 15-ны өдөр хүртэлх ажилгүйдэлд хамааралтай байдаг бол нийгмийн халамжийн тэтгэмжийн дараагийн төлбөрийн зохих шалгуур хангагдсан хугацаанд тэрхүү төлөх дүн тодорхой болох бөгөөд тухайн тайлангийн өдрөөр хүлээн зөвшөөрдөг. Дараагийн тайлант үед шалгуур хангахаа больсон тэтгэмж авагчийн хувьд залруулга хийх шаардлагагүй юм.

Харин 01-р сарын 15-нд төлөх төлбөр нь 12-р сарын 16-наас 01-р сарын 15-ны өдөр хүртэлх ажилгүйдэлд хамааралтай байдаг бол тухайн тайлангийн өдрөөр хүлээн зөвшөөрөх өр төлбөрийн хэмжилт нь төлбөрийн зохих шалгуурыг хангасан хэмжээний талаархи тооцоололд үндэслэдэг.

МЗУ17. Дараагийн төлбөрийн хувьд зохих шалгуурыг хангасан хугацааны агшнаас цааш өр төлбөрийг сунган хамааруулж болохгүй учраас нийгмийн халамжийн тэтгэмжийн өр төлбөр нь ихэвчлэн богино хугацаат өр төлбөр байдаг. Иймээс санхүүгийн тайланг нийтэд гаргахыг зөвшөөрөхөөс өмнө, байгууллага нь тухайн нийгмийн халамжийн тэтгэмж авах тэдгээр тэтгэмж авагчдын шалгуур биелэлтийн талаархи мэдээллийг хүлээн авч болох юм. Энэхүү мэдээллийг ашиглах талаархи заавар удирдамжийг УСНББОУС 14, *Тайлангийн Өдрийн Дараах Үйл Явдал*-д заасан байдаг.

МЗУ18. Нийгмийн халамжийн тэтгэмжийн хөтөлбөрийн өр төлбөр нь ихэвчлэн богино хугацаат өр төлбөр байдаг тул мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ нь материаллаг нөлөөтэй биш байж болох юм. Гэвч өр төлбөрийг тухайн тайлангийн өдрөөс хойш арван хоёр сарын дотор барагдуулахаар хүлээгдээгүй бөгөөд дискаунтын нөлөө нь материаллаг байх тохиолдолд байгууллага нь өр төлбөрийг дискаунтчлахыг энэ Стандартаар шаардсан байдаг. Ашиглах дискаунтын хувийн талаархи нэмэлт заавар удирдамжийг УСНББОУС 39-д заасан байдаг.

Даатгалын хандлага (26-28-р параграфыг үзнэ үү)

МЗУ19. Энэ Стандартын даатгалын хандлага хэсэг дэх “даатгалын гэрээг зохицуулдаг олон улсын буюу үндэсний нягтлан бодох бүртгэлийн холбогдох стандарт” гэсэн нэр томъёо нь СТОУС 17, *Даатгалын гэрээ* болон СТОУС 17-той бараг ижил зарчмыг баримталдаг үндэсний стандартуудыг илэрхийлнэ. СТОУС 17 нь даатгалын гэрээний нягтлан бодох бүртгэлийн зарчмуудыг тогтоон баталсан бөгөөд даатгалын хандлагыг ашиглах шалгуурыг хангасан нийгмийн халамжийн тэтгэмжийн хөтөлбөрүүдэд түүнийг адилтган мөрдсөнөөр хэрэглэгчдийн мэдээллийн хэрэгцээг хангах ба чанарын шинжүүдийг биелүүлэх тийм мэдээллийг бүрдүүлдэг. Даатгалын гэрээг зохицуулдаг нягтлан бодох бүртгэлийн бусад стандартуудад ийм нөхцөл хамаарахгүй байж болох юм. Тухайлбал; НББОУСЗ нь СТОУС 4, *Даатгалын гэрээ*-г “өргөн хүрээтэй янз бүрийн практикыг хүлээн зөвшөөрдөг ба дараах “түр зуурын чөлөөлөх нөхцөл”-ийг агуулсан, завсрын түр Стандарт” гэж тодорхойлсон байдаг: “аж ахуйн нэгж нь тухайн санхүүгийн тайлангийн хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэр гаргалтын хэрэгцээ шаардлагад

УСНББОУС 42-НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТЭТГЭМЖ

түүний нягтлан бодох бүртгэлийн бодлого хамааралтай эсвэл тэдгээр нягтлан бодох бүртгэлийн бодлогууд найдвартай эсэхийг ханган магадлах албагүй гэдгийг уг түр зуурын чөлөөлөх нөхцөлд шууд илэрхийлдэг”.² СТОУС 4 болон СТОУС 4-тэй бараг ижил зарчмыг баримталдаг үндэсний стандартууд нь хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагыг хангах ба чанарын шинжүүдийг биелүүлэх тийм мэдээллийг бүрдүүлдэггүй байж болох юм. Иймээс СТОУС 17-той бараг ижил зарчмыг баримталдаггүй тийм стандартын шаардлагуудыг адилтган мөрдсөнөөр байгууллага нь нийгмийн халамжийн тэтгэмжийн хөтөлбөртэй холбоотой хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлыг хүлээн зөвшөөрч, хэмжихгүй байж болно.

Нийгмийн халамжийн тэтгэмжийн хөтөлбөрийг нийгмийн даатгалын шимтгэлээр бүрэн санхүүжүүлэх санаа зорилготой эсэхийг тодорхойлох заавар удирдамж

МЗУ20. Дараах тохиолдолд нийгмийн халамжийн тэтгэмжийн хөтөлбөрийг нийгмийн даатгалын шимтгэлээр бүрэн санхүүжүүлэх санаа зорилготой байдаг:

- (а) Нийгмийн халамжийн тэтгэмжийн хөтөлбөрийг удирдан зохицуулдаг хууль тогтоомж эсвэл бусад тохиролцоо нь боломжит тэтгэмж авагч буюу бусад этгээдийн төлсөн, эсвэл тэдний өмнөөс төлсөн нийгмийн даатгалын шимтгэл болон хураамжаар тухайн хөтөлбөрийг санхүүжүүлэхээр заасан байх. Боломжит тэтгэмж авагч буюу бусад этгээд гэдэг нь тэдний үйл ажиллагааны улмаас нийгмийн эрсдэл үүсдэг эсвэл нэмэгддэг бөгөөд тэрхүү эрсдлийг уг нийгмийн халамжийн тэтгэмжийн хөтөлбөрөөр, түүнчлэн тэдгээр нийгмийн даатгалын шимтгэл, хураамжаас үүссэн хөрөнгө оруулалтын өгөөжөөр сулруулан бууруулдаг тийм талууд юм; ба
- (б) Дараах үзүүлэлтүүдийн аль нэгийг, эсвэл хоёуланг нь (дангаар нь, эсвэл хамтад нь) хангах:
 - (i) Нийгмийн даатгалын шимтгэл болон хураамжаар бүрдүүлсэн орлого нь тухайн нийгмийн халамжийн хөтөлбөрийг бүрэн санхүүжүүлэхэд хүрэлцээтэй эсэхийг ханган магадлах зорилгоор уг нийгмийн даатгалын шимтгэл ба хураамжийн хувь хэмжээг тогтмол үечилсэн байдлаар, эсвэл тусгайлан заасан шалгуур хангагдсан үед нягталж шалгадаг (ба хэрэв шаардлагатай бол хөтөлбөрийн санхүүжилтийн бодлогын дагуу тохируулга хийдэг); ба/буюу
 - (ii) Олгох нийгмийн халамжийн тэтгэмжийн түвшин нь нийгмийн даатгалын шимтгэл болон хураамжаар бүрдүүлэх боломжтой санхүүжилтийн дүнгээс хэтрэхгүй гэдгийг ханган магадлах зорилгоор уг нийгмийн халамжийн тэтгэмжийн түвшинг тогтмол үечилсэн байдлаар, эсвэл тусгайлан заасан шалгуур хангагдсан үед нягталж шалгадаг (ба хэрэв шаардлагатай бол хөтөлбөрийн санхүүжилтийн бодлогын дагуу тохируулга хийдэг);

Дээрх (i) ба (ii) дэд параграфуудад дурдсан, нягтлах шалгалтыг тухайн хөтөлбөрийн хувьд тохиромжтой тийм давтамжтайгаар хийж байгаа бол түүнийг уг тогтмол үечилсэн байдлаар нь гүйцэтгэнэ. Нягтлах шалгалтыг жил бүр хийх нь түгээмэл байдаг боловч зарим хөтөлбөрийн хувьд үүнээс илүү богино эсвэл илүү урт хугацааны давтамжтай гүйцэтгэх нь тохиромжтой байдаг.

МЗУ21. Зарим нөхцөл байдалд улсын секторын байгууллага нь нийгмийн даатгалын шимтгэлээ төлж чадахгүй байгаа хувь хүн ба/буюу айл өрхийн өмнөөс нийгмийн халамжийн тэтгэмжийн хөтөлбөрт шимтгэл, хураамжийг төлөх шаардлагатай байж болох юм. Ийм шимтгэлийг тухайн хөтөлбөрийг захиран зарцуулж буй байгууллага эсвэл өөр бусад байгууллага төлж болно. Жишээлбэл; улсын секторын байгууллага нь ажилгүй болсон хувь хүмүүсийн өмнөөс тэтгэвэрт гарсны дараах тэтгэмжийн хөтөлбөрт тэдний шимтгэлийг төлөх шаардлагатай байж болох юм. Нийгмийн даатгалын шимтгэл нь тодорхой хувь хүмүүс ба/буюу айл өрхөд хамааралтай (зарим тохиолдолд нийгмийн даатгалын шимтгэлийг тухайн хувь хүмүүсийн шимтгэлийн дансанд кредитлэх шаардлагатай байдаг) бол 28(а) параграфт дурдсанчлан, тухайн нийгмийн халамжийн тэтгэмжийн хөтөлбөрийг нийгмийн даатгалын шимтгэлээр бүрэн санхүүжүүлэх

² Саналын Төсөл СТ/2013/7, *Даатгалын Гэрээ*.

УСНББОУС 42-НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТЭТГЭМЖ

санаа зорилготой эсэхийг тодорхойлох зорилгын хувьд улсын секторын байгууллагын төлсөн шимтгэлийг мөн нийгмийн даатгалын шимтгэл гэж үздэг. Улсын секторын байгууллага нь нийгмийн халамжийн тэтгэмжийн хөтөлбөрийн алдагдлыг санхүүжүүлэхийн тулд шимтгэл төлдөг тохиолдолд тухайн шимтгэл нь тодорхой хувь хүмүүс ба/буюу айл өрхөд хамааралгүй бөгөөд 28(а) параграфт дурдсанчлан, нийгмийн халамжийн тэтгэмжийн хөтөлбөрийг нийгмийн даатгалын шимтгэлээр бүрэн санхүүжүүлэх санаа зорилготой эсэхийг тодорхойлох зорилгын хувьд нийгмийн даатгалын шимтгэл гэж үзэхгүй юм.

МЗУ22. Нийгмийн халамжийн тэтгэмжийн хөтөлбөрийг нийгмийн даатгалын шимтгэлээр бүрэн санхүүжүүлэх санаа зорилготой эсэхийг үнэлэхдээ, байгууллага нь хэлбэрээс илүү мөн чанарыг харгалзан үзнэ. Тухайлбал; нийгмийн халамжийн тэтгэмжийн хөтөлбөр нь тайлант үед алдагдалтай боловч ирээдүйн шимтгэлийн хувь хэмжээ ба/буюу тэтгэмжийн өглөгийг тохируулах, ингэснээр тэрхүү алдагдлыг шийдвэрлэх чадвар боломжтой байгаа тохиолдолд уг хөтөлбөр нь түүнийг даатгалын хандлагын дагуу тайлагнах шалгуурыг хангасан хэвээр байж болно.

МЗУ23. МЗУ20(а) параграф дахь “тэдний үйл ажиллагааны улмаас нийгмийн эрсдэл үүсдэг эсвэл нэмэгддэг бөгөөд тэрхүү эрсдлийг уг нийгмийн халамжийн тэтгэмжийн хөтөлбөрөөр сулруулан бууруулдаг” гэсэн хэллэг нь гэнэтийн ослын даатгалын хөтөлбөр гэх мэт дараах нийгмийн халамжийн тэтгэмжийн хөтөлбөрийг хамран агуулах санаа зорилготой юм:

- (а) Тухайлбал, автомашины жолооч буюу тодорхой нэг салбарын ажиллагчдад ногдуулдаг хураамжаар санхүүждэг; ба
- (б) Илүү өргөн хүрээний хүн амд учрах нийгмийн эрсдлийн эсрэг хамгаалалт бий болгох.

Байгууллага нь даатгалын гэрээ гаргагчтай ижил арга замаар хөтөлбөрийг удирддаг эсэхийг тодорхойлох заавар удирдамж

МЗУ24. Нийгмийн халамжийн тэтгэмжийн хөтөлбөр нь гэрээний нөхцлөөс биш, харин хууль тогтоомжийн гажих нөхцлийн улмаас даатгалын гэрээний шинж чанартай тохиолдолд байгууллага нь даатгалын багцыг удирдан зохицуулах даатгалын гэрээ гаргагчтай ижил арга замаар тэрхүү нийгмийн халамжийн тэтгэмжийн хөтөлбөрийг удирдан зохицуулдаг. Нийгмийн халамжийн тэтгэмжийн хөтөлбөр нь даатгалын гэрээний талуудад хүлээлгэдэг эрх, үүрэгтэй ижил эрхийг эдэлж, үүргийг хүлээдэг.

МЗУ25. Даатгалын багцыг удирдан зохицуулдаг даатгалын гэрээ гаргагчтай ижил арга замаар тэрхүү нийгмийн халамжийн тэтгэмжийн хөтөлбөрийг удирдан зохицуулах эсэхийг тодорхойлохын тулд байгууллага нь дараах үзүүлэлтүүдийг харгалзан үзнэ:

- (а) Даатгалын гэрээний дагуу даатгагч үүрэг хүлээдэгтэй нэгэн адилаар, байгууллага нь тухайн хөтөлбөрийн хувьд өөрөө үүрэг хүлээдэг эсэхээ харгалзан үздэг үү? Тухайлбал; даатгагчийн хийж чадахааргүй тийм арга замаар байгууллага нь одоо байгаа оролцогчдын хувьд тухайн хөтөлбөрийн нөхцлийг өөрчилж чадах (байгууллага нь уг хөтөлбөрт буцаах өөрчлөлт хийж чадах гэх мэт) эсэхээ харгалзан үздэг гэсэн нотолгоо байж болох юм. Ийм тохиолдолд байгууллага нь даатгагчтай ижил төстэй байдлаар үүрэг хүлээхгүй бөгөөд нийгмийн халамжийн тэтгэмжийн хөтөлбөр нь даатгалын гэрээний шинж чанартай байдаггүй. Одоо байгаа оролцогчдод зориулан хөтөлбөрийг өөрчлөх байгууллагын чадвар боломж нь дараах байдлаар хязгаарлагддаг тохиолдолд уг байгууллага нь тухайн хөтөлбөрийн хувьд даатгагчтай ижил арга замаар үүрэг хүлээнэ.
 - (i) Хөтөлбөрийг тодорхойлдог хууль тогтоомжоор илэрхийлэгдэх нөхцөл байдал (тусгайлан заасан нөхцөл байдалд өөрчлөлт оруулахыг зөвшөөрсөн гэрээний нөхцөлтэй адил); эсвэл
 - (ii) Засгийн газар нь нийгмийн даатгалын шимтгэл буюу хураамжийн шинэ хувь хэмжээг тогтоосон тохиолдолд (нийгмийн даатгалын шимтгэл ба боломжит тэтгэмжийн хоорондох уялдаа тэнцвэр нь тохиромжтой хувь хэмжээг тодорхойлох үйл явцын нэг хэсэг юм).

УСНББОУС 42-НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТЭТГЭМЖ

- (б) Нийгмийн халамжийн тэтгэмжийн хөтөлбөртэй холбоотой хөрөнгийг тусдаа санд байршуулдаг уу, эсхүл өөр бусад байдлаар тусгайлан нөөцөлдөг ба оролцогчдод нийгмийн халамжийн тэтгэмж олгох үүднээс түүнийг ашиглахад хязгаарлалт тогтоодог уу? Хэрэв байгууллага нь нийгмийн халамжийн тэтгэмжид хамааралтай дүнгүүдийг тусад нь тодорхойлдоггүй бол энэ нь нийгмийн даатгалын шимтгэлийг тухайн байгууллага татварын нэг хэлбэр гэж үздэг гэдгийн нотолгоо болох юм. Нийгмийн халамжийн тэтгэмжийн хөтөлбөр нь даатгалын гэрээний шинж чанарыг агуулдаггүй. Нийгмийн халамжийн тэтгэмжийн хөтөлбөртэй холбоотой хөрөнгийг тусад нь тодорхойлдоггүй бол даатгалын гэрээг зохицуулдаг олон улсын буюу үндэсний нягтлан бодох бүртгэлийн холбогдох стандартын хэмжилтийн шаардлагуудыг мөрдөхөд мөн практик хүндрэлүүд тулгарах юм.
- (в) Нийгмийн халамжийн тэтгэмжийг тогтоон зохицуулдаг хууль тогтоомж нь нийгмийн эрсдэл үүссэн үед оролцогчдод хууль ёсны хүчин төгөлдөр эрх олгодог уу? Даатгалын гэрээ нь даатгуулагчдад ийм эрх олгодог. Хэрэв нийгмийн халамжийн тэтгэмжийн хөтөлбөр нь ийм эрхийг бас тусган агуулдаггүй бол тухайн байгууллагын үзүүлэх аливаа нийгмийн халамжийн тэтгэмж нь сайн дурын шинж чанартай, өөрөөр хэлбэл уг нийгмийн халамжийн тэтгэмжийн хөтөлбөр нь даатгалын гэрээний шинж чанартай байхгүй гэсэн үг юм. Эрх хууль ёсны хүчин төгөлдөр байхын тулд оролцогч тал нь тухайн байгууллагын гаргасан шийдвэрийн хувьд арбитр, маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа буюу түүнтэй адилтгах механизмаар дамжуулан шүүхэд гомдол гаргах эрхтэй байх шаардлагатай. Гомдол гарган маргалдаж болох шийдвэрт тодорхой үйл явдал нь тухайн хөтөлбөрт хамаарах эсэх, хөтөлбөрөөс төлөх нийгмийн халамжийн тэтгэмжийн түвшин, хөтөлбөрийн төлөх аливаа нийгмийн халамжийн тэтгэмжийн үргэлжлэх хугацаа зэргийн талаархи шийдвэр хамаарах боловч үүгээр хязгаарлагдахгүй.
- (г) Хөтөлбөрийн санхүүгийн үр дүнгийн талаар дотооддоо тайлагнах шаардлагатай бөгөөд хөтөлбөрийн аливаа хангалтгүй үр дүнг харгалзан үзэхийн тулд арга хэмжээ авах шаардлагатай тохиолдолд байгууллага нь уг нийгмийн халамжийн тэтгэмжийн хөтөлбөрийн санхүүгийн үр дүн ба санхүүгийн байдлыг тогтмол үечилсэн байдлаар үнэлдэг. Ийм үнэлгээнд актуар тооцооллын нягтлах шалгалт, математик загварчлал, түүнчлэн гарч тохиолдож болох боломжит янз бүрийн үр дагаврын талаархи дотоод шийдвэр гаргалтанд зориулсан мэдээллээр хангах адилтгах арга зүйг ашиглана гэж үздэг.
- (д) Нийгмийн халамжийн тэтгэмжийн хөтөлбөртэй холбоотойгоор даатгагчтай адил үүрэг гүйцэтгэх бөгөөд засгийн газраас үүсгэн байгуулсан тусдаа байгууллага байдаг уу? Ийм байгууллагын оршин байдал нь даатгалын багцыг тухайн даатгалын гэрээ гаргагч удирдан зохицуулдагтай ижил арга замаар нийгмийн халамжийн тэтгэмжийн хөтөлбөрийг уг байгууллага удирдан зохицуулдаг гэсэн нотолгоо болно. Гэхдээ тусдаа байгууллага үүсгэн байгуулах эсэх нь даатгалын хандлагыг мөрдөх зайлшгүй шаардлага биш юм. Даатгалын гэрээг зохицуулдаг олон улсын буюу үндэсний нягтлан бодох бүртгэлийн холбогдох стандартуудыг зөвхөн даатгалын компаниудад төдийгүй даатгалын гэрээнд бас мөрддөг.

Хавсралт Б

Бусад УСНББОУС-уудад оруулсан нэмэлт өөрчлөлтүүд

УСНББОУС 1, *Санхүүгийн Тайлангийн Толилуулга*-д оруулсан нэмэлт өөрчлөлт

88, 94, 112-115-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулж, 153О параграфыг шинээр нэмсэн. Шинэ текстийн доогуур, харин хасагдсан текстийн дундуур зурсан.

...

Бүтэц ба агуулга

...

Санхүүгийн байдлын тайлан

...

Санхүүгийн байдлын тайланд толилуулах мэдээлэл

88. **Санхүүгийн байдлын тайлан хамгийн наад зах нь дараах дүнгүүдийг илэрхийлэх мөрийн зүйлсийг агуулсан байна:**

(а) Үндсэн хөрөнгө;

...

(л) Татвар ба шилжүүлгийн өглөг;

(ла) Нийгмийн халамжийн тэтгэмжийн өр төлбөр;

(м) Арилжааны ажил гүйлгээний өглөг;

...

...

Санхүүгийн байдлын тайланд эсвэл тодруулгад толилуулах мэдээлэл

...

94. Дэд ангиллуудад дэлгэрэнгүй харуулах зэрэг хэмжээ нь УСНББОУС-ын шаардлага, түүнчлэн тухайн хамаарах дүнгийн хэмжээ, шинж төрөл, чиг үүргээс хамаарна. Дэд ангиллын суурийг тогтоохдоо 91-р параграфт заасан хүчин зүйлсийг мөн харгалзан үзнэ. Толилуулга нь мөрийн зүйл тус бүрийн хувьд ялгаатай байна. Тухайлбал;

(а) Үндсэн хөрөнгийн зүйлсийг УСНББОУС 17-гийн дагуу ангиудад салган задална;

...

(г) Татвар ба шилжүүлгийн өглөгийг татварын буцаалтын өглөг, шилжүүлгийн өглөг, эдийн засгийн нэгдмэл байгууллагын бусад гишүүдэд төлөх өглөг гэдгээр салган задална;

(га) Нийгмийн халамжийн тэтгэмжийн өр төлбөрийг материаллаг дүн бүхий нийгмийн халамжийн тэтгэмжийн тусдаа хөтөлбөрүүдэд салган задална;

(д) Нөөц санг ажилтны тэтгэмжийн болон бусад зүйлсийн нөөцийн сан гэдгээр салган задална;

УСНББОУС 42-НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТЭТГЭМЖ

- (е) Цэвэр хөрөнгө/өмчийн бүрэлдэхүүн хэсгүүдийг хувь нийлүүлсэн хөрөнгө, хуримтлагдсан ашиг буюу алдагдал, нөөц сан гэх мэт ангиллуудаар салган задална.

...

Санхүүгийн үр дүнгийн тайлан

...

Санхүүгийн үр дүнгийн тайланд эсвэл тодруулгад толилуулах мэдээлэл

...

112. Шинжилгээний эхний хэлбэр нь ‘зардлын шинж төрөл’-ийн арга юм. Зардлуудыг тэдгээрийн шинж төрлийн (жишээлбэл; элэгдэл, материалын худалдан авалт, тээврийн зардал, ажилтны тэтгэмж, зар сурталчилгааны зардал) дагуу санхүүгийн үр дүнгийн тайланд нэгтгэн тусгах ба тухайн байгууллагын хүрэн дэх чиг үүргээр тэдгээр зардлыг дахин хуваарилахгүй. Зардлуудыг чиг үүргийн ангиллаар хуваарилах шаардлагагүй учраас энэ арга нь хялбар байж болох юм. Зардлын шинж төрлийн аргыг хэрэглэн хийсэн ангиллын жишээг доор харуулав:

Орлого		X
Ажилтны тэтгэмжийн зардал	X	
<u>Нийгмийн халамжийн тэтгэмжийн зардал</u>	<u>X</u>	
Элэгдэл ба хорогдуулгын зардал	X	
Бусад зардал	X	
Нийт зардал		<u>(X)</u>
Ашиг		<u>X</u>

113. Шинжилгээний хоёр дахь хэлбэр нь ‘зардлын чиг үүрэг’-ийн арга бөгөөд тэдгээрийг зарцуулсан хөтөлбөр буюу зорилгын дагуу зардлыг ангилдаг. Энэ арга нь шинж төрлөөр хийсэн зардлын ангилалтай харьцуулахад хэрэглэгчдийг илүү их хамааралтай мэдээллээр хангадаг боловч өртөг зардлуудыг чиг үүргээр хуваарилахдаа тохиолдлын шинжтэй хуваарилалт ашиглах, субъектив дүгнэлт хийх шаардлагатай байж болох юм. Зардлын чиг үүргийн аргыг ашиглан хийсэн ангиллын жишээг доор харуулав:

Орлого		X
Зардал:		
<u>Нийгмийн халамжийн тэтгэмжийн зардал</u>		<u>(X)</u>
Эрүүл мэндийн зардал		(X)
Боловсролын зардал		(X)
Бусад зардал		(X)
Ашиг		<u>X</u>

114. Байгууллагын гүйцэтгэж буй үндсэн чиг үүрэгтэй холбоотой зардлуудыг тусад нь харуулна. Энэ жишээнд байгууллага нь нийгмийн халамж, эрүүл мэндийн болон боловсролын үйлчилгээ үзүүлэх чиг үүрэгтэй байна. Байгууллага нь эдгээр чиг үүрэг тус бүрийн хувьд зардлын мөрийн зүйлсийг толилуулна.

115. Зардлыг чиг үүргээр ангилж буй байгууллага нь зардлын шинж төрлийн, үүн дотроо элэгдэл ба хорогдуулгын зардал, нийгмийн халамжийн тэтгэмжийн зардал, ажилтны тэтгэмжийн зардлын талаархи нэмэлт мэдээллийг толилуулна.

УСНББОУС 42-НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТЭТГЭМЖ

...

Хүчин төгөлдөр болох хугацаа

...

1530. 2019 оны 01 дүгээр сард гаргасан, УСНББОУС 42, Нийгмийн Халамжийн Тэтгэмж-ээр 88, 94, 112-115-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь УСНББОУС 42-ыг мөрдсөн тухайн тайлант үеэс эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдөнө.

...

Хэрэгжүүлэх заавар удирдамж

...

Улсын секторын байгууллага - Санхүүгийн байдлын тайлан

20X2 оны 12-р сарын 31-ний өдөр

(мянгачилсан дүнгээр)

	20X2	20X1
ХӨРӨНГӨ		
...		
ӨР ТӨЛБӨР		
Богино хугацаат өр төлбөр		
Өглөг	X	X
Богино хугацаат зээл	X	X
Урт хугацаат зээлийн тайлант үед төлөх хэсэг	X	X
Богино хугацаат нөөц сан	X	X
<u>Нийгмийн халамжийн тэтгэмж</u>	<u>X</u>	<u>X</u>
Ажилтны тэтгэмж	X	X
Тэтгэвэр, тэтгэмжийн хөтөлбөр	X	X
	<u>X</u>	<u>X</u>
Урт хугацаат өр төлбөр		
Өглөг	X	X
Урт хугацаат зээл	X	X
Урт хугацаат нөөц сан	X	X
<u>Нийгмийн халамжийн тэтгэмж</u>	<u>X</u>	<u>X</u>
Ажилтны тэтгэмж	X	X
Тэтгэвэр, тэтгэмжийн хөтөлбөр	X	X
	<u>X</u>	<u>X</u>
Нийт өр төлбөр	<u>X</u>	<u>X</u>
Цэвэр хөрөнгө	<u>X</u>	<u>X</u>
	20X2	20X1
ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧ		
...		
Хяналтын бус хувь оролцоо	X	X
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	<u>X</u>	<u>X</u>

УСНББОУС 42-НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТЭТГЭМЖ

Улсын секторын байгууллага - 20X2 оны 12-р сарын 31-нээр дуусгавар болсон жилийн Санхүүгийн үр дүнгийн тайлан

(Зардлын ангиллыг чиг үүргээр үлгэрчлэн харуулах)
(мянгачилсан дүнгээр)

	20X2	20X1
Орлого		
...		
Зардал		
Нийтийн ерөнхий үйлчилгээ	(X)	(X)
Батлан хамгаалах	(X)	(X)
Нийгмийн хэв журам ба аюулгүй байдал	(X)	(X)
Боловсрол	(X)	(X)
Эрүүл мэнд	(X)	(X)
<u>Нийгмийн халамж</u>	<u>(X)</u>	<u>(X)</u>
Бусад нийгмийн хамгаалал	(X)	(X)
Орон сууц, нийтийн аж ахуйн үйлчилгээ	(X)	(X)
Амралт сувилгаа, соёл, шашин	(X)	(X)
Эдийн засгийн асуудлууд	(X)	(X)
Байгаль орчны хамгаалал	(X)	(X)
Бусад зардал	(X)	(X)
Санхүүгийн зардал	<u>(X)</u>	<u>(X)</u>
Нийт зардал	<u>(X)</u>	<u>(X)</u>
...		

Улсын секторын байгууллага - 20X2 оны 12-р сарын 31-нээр дуусгавар болсон жилийн Санхүүгийн үр дүнгийн тайлан

(Зардлын ангиллыг шинж төрлөөр үлгэрчлэн харуулах)
(мянгачилсан дүнгээр)

	20X2	20X1
Орлого		
...		
Зардал		
Цалин хөлс ба ажилтны тэтгэмж	(X)	(X)
<u>Нийгмийн халамжийн тэтгэмж</u>	<u>(X)</u>	<u>(X)</u>
Буцалтгүй тусламж ба бусад шилжүүлгийн төлбөр	(X)	(X)
Ашигласан хангамжийн материал ба хэрэглээний зүйлс	(X)	(X)
Элэгдэл, хорогдуулгын зардал	(X)	(X)
Үндсэн хөрөнгийн үнэ цэнийн бууралт ³	(X)	(X)
Бусад зардал	(X)	(X)
Санхүүгийн зардал	<u>(X)</u>	<u>(X)</u>
Нийт зардал	<u>(X)</u>	<u>(X)</u>
...		

³ Зардлыг шинж төрлөөр ангилдаг санхүүгийн үр дүнгийн тайланд үндсэн хөрөнгийн үнэ цэнийн бууралтыг тусдаа мөрийн зүйл байдлаар харуулдаг. Харин эсрэгээр, зардлыг чиг үүргээр ангилдаг бол үнэ цэнийн бууралтыг түүний хамаарах тухайн чиг үүрэгт (үүргүүдэд) тусган оруулна.

УСНББОУС 2, Мөнгөн Гүйлгээний Тайлан-д оруулсан нэмэлт өөрчлөлт

22-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулж, 52Ж параграфыг шинээр нэмсэн. Шинэ текстийн доогуур, харин хасагдсан текстийн дундуур зурсан.

...

Мөнгөн гүйлгээний тайлангийн толилуулга

...

Үндсэн үйл ажиллагаа

22. Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ нь юуны өмнө тухайн байгууллагын мөнгө бий болгох үндсэн үйл ажиллагаанаас үүсдэг. Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний жишээг доор дурдав:

(а) Татвар, хураамж, торгуулиас бий болсон мөнгөн орлого;

...

(г) Эрхийн шимтгэл, төлбөр, хураамж ба бусад орлогоос бий болсон мөнгөн орлого;

(га) Нийгмийн халамжийн тэтгэмжийн хөтөлбөрийн тэтгэмж авагчдад олгосон мөнгөн төлбөр;

(д) Улсын секторын бусад байгууллагуудад тэдгээрийн үйл ажиллагааг санхүүжүүлэхэд зориулан олгосон мөнгөн төлбөр (үүнд: зээл хамаарахгүй);

...

Үндсэн хөрөнгийн борлуулалт гэх мэт зарим ажил гүйлгээ нь олз эсвэл гарз үүсгэх ба түүнийг ашиг, алдагдалд тусган оруулж болох юм. Ийм ажил гүйлгээтэй холбоотой мөнгөн гүйлгээ нь хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ юм. Харин УСНББОУС 17 *Үндсэн Хөрөнгө*-ийн 83А параграфт заасан, бусдад түрээслэх ба дараа нь борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгийг барьж байгуулах эсвэл худалдан авахад төлсөн мөнгөн төлбөр нь үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ болно. Ийм хөрөнгийн түрээслэлт болон цаашдын борлуулалтаас үүссэн мөнгөн орлого нь мөн үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ болох юм.

...

Хүчин төгөлдөр болох хугацаа

...

63Ж. 2019 оны 01 дүгээр сард гаргасан, УСНББОУС 42, *Нийгмийн Халамжийн Тэтгэмж*-ээр 22-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь УСНББОУС 42-ыг мөрдсөн тухайн тайлант үеэс эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдөнө.

...

Үлгэрчилсэн жишээ

Энэхүү жишээ нь УСНББОУС 2-ыг дагалдах боловч түүний салигүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.

Мөнгөн гүйлгээний тайлан (Санхүүгийн байгууллагаас бусад, байгууллагад зориулав)

УСНББОУС 42-НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТЭТГЭМЖ

Шууд аргаар бэлтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан (27(а) параграф)

Улсын секторын байгууллага - 20X2 оны 12-р сарын 31-нээр дуусгавар болсон жилийн Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

	(мянгачилсан дүнгээр)	20X2	20X1
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ			
Мөнгөн орлого			
...			
Мөнгөн төлбөр			
Ажиллагчдын зардал		(X)	(X)
Тэтгэвэр, тэтгэмжийн хөтөлбөр		(X)	(X)
Бэлтгэн нийлүүлэгчдийн төлбөр		(X)	(X)
<u>Нийгмийн халамжийн тэтгэмж</u>		<u>(X)</u>	<u>(X)</u>
Төлсөн хүү		(X)	(X)
Бусад төлбөр		(X)	(X)
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ		<u>X</u>	<u>X</u>
...			

Мөнгөн гүйлгээний тайлангийн тодруулга

(в) *Үндсэн үйл ажиллагааны Цэвэр мөнгөн гүйлгээг Ашиг/(алдагдал)-тай тохируулах*

	(мянгачилсан дүнгээр)	20X2	20X1
Ашиг/(алдагдал)		X	X
Мөнгөн бус өөрчлөлтүүд			
Элэгдэл		X	X
...			
Зээлийн өсөлт		X	X
<u>Нийгмийн халамжийн тэтгэмжийн өр төлбөрийн өсөлт</u>		<u>X</u>	<u>X</u>
Ажиллагчдын зардалтай холбоотой нөөцийн өсөлт		X	X
...		(X)	(X)
Авлагын өсөлт		(X)	(X)
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ		<u>X</u>	<u>X</u>

УСНББОУС 42-НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТЭТГЭМЖ

Шууд аргаар бэлтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан (27(б) параграф)

Улсын секторын байгууллага - 20X2 оны 12-р сарын 31-нээр дуусгавар болсон жилийн Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

(мянгачилсан дүнгээр)	20X2	20X1
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Ашиг/(алдагдал)	X	X
Мөнгөн бус өөрчлөлтүүд		
Элэгдэл	X	X
Хорогдуулга	X	X
Найдваргүй авлагын нөөцийн өсөлт	X	X
Өглөгийн өсөлт	X	X
Зээлийн өсөлт	X	X
<u>Нийгмийн халамжийн тэтгэмжийн өр төлбөрийн өсөлт</u>	<u>X</u>	<u>X</u>
Ажиллагчдын зардалтай холбоотой нөөцийн өсөлт	X	X
Үндсэн хөрөнгийн борлуулалтын (олз)/гарз	(X)	(X)
Хөрөнгө оруулалтын борлуулалтын (олз)/гарз	(X)	(X)
Бусад эргэлтийн хөрөнгийн өсөлт	(X)	(X)
Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний өсөлт	(X)	(X)
Авлагын өсөлт	(X)	(X)
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	<u>X</u>	<u>X</u>

УСНББОУС 19, Нөөц, Болзошгүй Өр Төлбөр ба Болзошгүй Хөрөнгө-д оруулсан нэмэлт өөрчлөлт

1, 12, 19, 77-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулж, 111К параграфыг шинээр нэмсэн ба 7-11, 99, 104-р параграфыг хассан. Шинэ текстийн доогуур, харин хасагдсан текстийн дундуур зурсан.

...

Цар хүрээ

1. Нягтлан бодох бүртгэлийн аккруэл сууриар санхүүгийн тайлангаа бэлтгэж, толилуулдаг байгууллага нь доор дурдсанаас бусад нөөц, болзошгүй өр төлбөр ба болзошгүй хөрөнгийн тайлагналд энэхүү Стандартыг мөрдөнө:

- (a) ~~Нийлүүлсэн бараа, үйлчилгээнийхээ үнэ цэнэтэй ойролцоогоор тэнцүү төлбөрийг тэдгээр үр өгөөж хүртэгчдээ хариу болгон шууд хүлээн авдаггүй байгууллагын үзүүлсэн нийгмийн халамжаас үүсэх нооц ба болзошгүй өр төлбөр УСНББОУС 42-ын цар хүрээнд хамаарах нийгмийн халамжийн тэтгэмж;~~

...

Нийгмийн халамж

7. Энэ Стандартын зорилгын хувьд “нийгмийн халамж” гэдэг нь засгийн газрын нийгмийн бөдлөгийн зорилтуудыг хэрэгжүүлэх явцад нийлүүлсэн бараа, үйлчилгээ болон бусад үр өгөөжийг хэлнэ. Ийм халамжинд дараах зүйлс хамаарч болно:

- (a) Тухайн нийгэмд эрүүл мэнд, боловсрол, орон байр, тээврийн болон бусад нийгмийн үйлчилгээ үзүүлэх. Ихэнх тохиолдолд энэ нь тэдгээр үйлчилгээний үнэ цэнэтэй адилтгах дүн төлөхийг уг үйлчилгээ хүлээн авагчдаас шаарддаггүй; ба
- (б) Гэр бүл, ондор настан, тахир дутуу иргэд, ажилгүйчүүд, ахмад дайчид болон бусад иргэдэд олгосон тэтгэмжийн төлбөр. Өөрөөр хэлбэл, бүх түвшний засаг захиргааны байгууллага нь тухайн нийгмийн иргэд болон төдөрхөй бүлэг хүмүүст санхүүгийн туслалцаа үзүүлж, тэднийг өөрсдийн тухайлсан хэрэгцээ шаардлагаа хангах буюу өрлөгөө нэмэгдүүлэхийн тулд үйлчилгээ авах боломжийг олгодог.

8. Ихэнх тохиолдолд, нийгмийн халамж үзүүлэх үүрэг нь тухайн нийгэмд төдөрхөй бараа, үйлчилгээ нийлүүлэхийн тулд урт хугацааны туршид тасралтгүй байдлаар зарим төдөрхөй үйл ажиллагааг эрхлэн явуулах засгийн газрын баталгааны үр дагавар болон үүсдэг. Нийгмийн бөдлөгийн үүргийг биелүүлэхэд чиглэгдсэн бараа, үйлчилгээний хэрэгцээ шаардлага, шинэ төрөл, ханган нийлүүлэлт нь хүн ам зүйн болон нийгмийн янз бүрийн нөхцөл байдлуудаас ямагт хамаардаг бөгөөд урьдчилан төдөрхөйлөхөд товогтэй байдаг. Олон Улсын Валютын Сангаас гаргасан Засгийн Газрын Санхүүгийн Статистикийн үзэл баримтлалын дагуу эдгээр халамж тэтгэмж нь нийгмийн хамгаалал, боловсрол, эрүүл мэнд гэсэн ангилалуудад ерөнхийдөө хамаардаг бөгөөд тэдгээрийн хувьд үүсэх аливаа өр төлбөрийн дүнг төдөрхөйлөхын тулд ихэвчлэн актуар үнэлгээ хийх шаардлагатай байдаг.

9. Энэ Стандартын цар хүрээнд хамаарахгүй нийгмийн халамжаас үүсэх нооц буюу болзошгүй өр төлбөрийн хувьд, тэрхүү тэтгэмжийг олгож буй улсын секторын байгууллага нь нийлүүлсэн бараа, үйлчилгээнийхээ үнэ цэнэтэй ойролцоогоор тэнцүү төлбөрийг тэдгээр үр өгөөж хүртэгчдээ хариу болгон шууд хүлээн авдаггүй. Тухайн үр өгөөжийн хувьд төлбөр ногдуулдаг боловч төлбөр ба хүлээн авсан үр өгөөж нь шууд холбоогүй байх тэдгээр нөхцөл байдлууд нь Стандартын цар хүрээнд хамаарахгүй ийм нөхцөлд хамаарах юм. Эдгээр нооц болон болзошгүй өр төлбөрийг энэ Стандартын цар хүрээнд оруулахгүй хасаж байгаа нь (a) үүрэг хүлээлгэх үйл явдлыг юу бүрдүүлдэг талаархи төдөрхөйлөлт, (б) тухайн өр төлбөрийн хэмжилт нь санал болгосон Стандартыг танилцуулан санал авахаас өмнө цаашид харгалзан үзэх шаардлагатай гэсэн Хөрөнги үзэл баримтлалыг тусган илэрхийлнэ. Жишээлбэл; хувь хүн нь халамж тэтгэмж

УСНББОУС 42-НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТЭТГЭМЖ

авах зохих шалгуурыг хангах буюу үүнээс өмнөх тодорхой нэг үе шатанд уг үүрэг хүлээлгэх үйл явдал гарч тохиолдсон эсэх талаар янз бүрийн үзэл бодолтой байдаг гэдгийг Хороо хүлээн зөвшөөрдөг. Үүнтэй адилаар, аливаа үүргийн дүн нь тухайн тайлант үед үүсээн эрхийн тооцооллол эсвэл актуар суурьнаар тодорхойлсон, ирээдүйн хүлээгдэж буй бүх тэтгэмжийн оноогийн үнэ цэнийг тусгасан эсэх талаар оор оор үзэл бодолтой байдаг.

10. Байгууллага нь ийм үүргийн хувьд нооц хүлээн зөвшөөрөх сөнгөлт хийсэн тохиолдолд тухайн байгууллага нь тэрхүү нооцийг хүлээн зөвшөөрсөн суурь болон хэрэглээн хэмжилтийн суурийг тодруулна. Байгууллага нь тэдгээр нооцийн хувьд энэ Стандартаар шаардсан бусад тодруулгыг багасгасна. Бусад УСНББОУС аар тусгайлан авч үзээгүй асуудлуудын зохицуулалтын талаархи заавар удирдамжийг УСНББОУС 1-д тусгасан. УСНББОУС 1 нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын сөнгөлт ба тодруулгатай холбоотой шаардлагуудыг мөн тусгасан байдаг.

11. Зарим тохиолдолд, нийгмийн халамж нь өр төлбөр үүсэхэд хүргэж болох бөгөөд тэрхүү өр төлбөрийн хувьд:

(а) Дүн нь тодорхойгүй бинш буюу бага зэрэг тодорхойгүй байна; ба

(б) Үүргийн дүн нь тодорхойгүй бинш байна.

Иймээс эдгээр нь энэ Стандарт дахь нооцийн тодорхойлолтыг хангах магадлал багатай юм. Нийгмийн халамжийн хувьд ийм өр төлбөр өршин байх тохиолдолд өр төлбөр гэж хүлээн зөвшөөрөх шалгуурыг хангасан үед тэдгээрийг хүлээн зөвшөөрнө (19-р параграфыг багасгасна үү). Жишээлбэл, гэрээ буюу хууль тогтоомжийн заалтын дагуу төлбөрийг төлөхөөр зөвшөөрсөн баталсан өндөр настан болон тахир дутуу иргэдийн тэтгэврийн хувьд өдөөгийн тэтгэмж авагчдад төлөх тухайн тайлант үеийн эцэс дэх хуримтлуулан дүн.

Энэ Стандартын цар хүрээнд хамаарахгүй бусад зүйлс

12. Алдагдалтай гэрээ байхаас бусад тохиолдолд энэ Стандартыг бүрэн биелэгдээгүй гэрээнд мөрдөхгүй. Нийлүүлсэн бараа, үйлчилгээнийхээ үнэ цэнэтэй ойролцоогоор тэнцүү төлбөрийг байгууллага нь тэдгээр үр өгөөж хүртэгчдээ хариу болгон шууд хүлээн авахгүй гэсэн хүлээлттэйгээр байгуулсан ба нийгмийн халамж үзүүлэх гэрээ нь энэ Стандартын цар хүрээнд хамаарахгүй.

...

Тодорхойлолт

...

Нөөц ба бусад өр төлбөр

19. Нөөцийг барагдуулахад шаардлагатай ирээдүйн зарлагын цаг хугацаа буюу дүн тодорхой бус байдаг учраас түүнийг худалдааны өглөг, хуримтлагдсан өглөг гэх мэт бусад өр төлбөрөөс ялган зааглаж болно. Харин эсрэгээр:

(а) Худалдааны өглөг нь хүлээн авсан буюу нийлүүлэгдсэн бараа, үйлчилгээний төлбөрийг төлөх өр төлбөр бөгөөд бэлтгэн нийлүүлэгч нь нэхэмжилсэн буюу түүнтэй албан ёсоор тохиролцсон байдаг (тусгайлан заасан дүнгийн талаархи албан ёсны гэрээ хийсэн тохиолдолд нийгмийн халамжийн хувьд хийгдэх төлбөрүүд үүнд хамаарна); ба

...

Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилтийн дүрмүүдийг мөрдөх

...

УСНББОУС 42-НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТЭТГЭМЖ

Алдагдалтай гэрээ

...

77. Энэ Стандартын 76-р параграфыг зөвхөн алдагдалтай гэрээний хувьд мөрдөнө. ~~Нийлүүлэн бараа, үйлчилгээнийхээ үнэ цэнэтэй ойролцоогоор тэнцүү төлбөрийг байгууллага нь тэдгээр үр өгөөж хүртэгчдээ хариу болгон шууд хүлээн авахгүй гэсэн хүлээлтгүйгээр байгуулсан, нийгмийн халамж үзүүлэх гэрээ нь энэ Стандартын цар хүрээнд хамаарахгүй.~~

...

Тодруулга

...

~~99. Байгууллага нь нийлүүлэн бараа, үйлчилгээнийхээ үнэ цэнэтэй ойролцоогоор тэнцүү төлбөрийг тэдгээр үр өгөөж хүртэгчдээ хариу болгон шууд хүлээн авдаггүй нийгмийн халамжийн хувьд өөрийн санхүүгийн тайландаа нооцийг хүлээн зөвшөөрөх сонголт хийсэн тохиолдолд тухайн байгууллага нь тэдгээр нооцийн хувьд 97 ба 98-р параграфтаар шаардсан тодруулгын хийнэ.~~

...

104. ~~Нийлүүлэн бараа, үйлчилгээнийхээ үнэ цэнэтэй ойролцоогоор тэнцүү төлбөрийг тэдгээр үр өгөөж хүртэгчдээ хариу болгон шууд хүлээн авдаггүй байгууллагын үзүүлэн нийгмийн халамжаас үүссэн болзошгүй өр төлбөрийн хувьд 100-р параграфт заасан тодруулгын шаардлагуудыг мөрдөхгүй (нийгмийн халамжийг энэ Стандартад хамруулахгүй талаархи хэлэлцүүлгийг 1(а) ба 7-11-р параграфтаас үзнэ үү).~~

...

Хүчин төгөлдөр болох хугацаа

...

111К. 2019 оны 01 дүгээр сард гаргасан, УСНББОУС 42, Нийгмийн Халамжийн Тэтгэмж-ээр 1, 12, 19, 77-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулж, 111К параграфыг шинээр нэмсэн ба 7-11, 99, 104-р параграфыг хассан. Байгууллага нь УСНББОУС 42-ыг мөрдсөн тухайн тайлант үеэс эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдөнө.

...

Дүгнэлтийн Үндэслэл

Энэхүү Дүгнэлтийн Үндэслэл нь УСНББОУС 19-ийг дагалдах боловч түүний салшгүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.

...

УСНББОУС 42, Нийгмийн Халамжийн Тэтгэмж-ийн үр дүнд УСНББОУС 19-д хийсэн хянан засварлалт

ДҮЗ. Анх гаргах үед энэ Стандарт нь “нийлүүлэн бараа, үйлчилгээний үнэ цэнэтэй ойролцоогоор тэнцүү төлбөрийг тухайн тэтгэмж авагчдаас хариу болгон шууд хүлээн авдаггүй үг байгууллагын үзүүлсэн нийгмийн халамжийн тэтгэмж”-ээс үүсэх нөөц ба болзошгүй өр төлбөрийг өөрийн цар хүрээнд оруулаагүй байсан. Энэ нь дараах зүйлсийн аль алины талаархи тухайн цаг үеийн үзэл баримтлалыг тусгасан байв: (а) үүрэг хүлээлгэх үйл явдлыг юу

УСНББОУС 42-НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТЭТГЭМЖ

бүрдүүлдэг талаархи тодорхойлолт, (б) цаашид харгалзан үзэх шаардлагатай өр төлбөрийн хэмжилт.

ДҮ4. Гэвч энэ Стандарт нь нийгмийн халамжийн тэтгэмжтэй холбоотойгоор нөөц хүлээн зөвшөөрөхийг хориглодоггүй бөгөөд байгууллага нь ийм үүргийн хувьд нөөц хүлээн зөвшөөрөх сонголт хийсэн тохиолдолд тодруулга хийхийг шаардсан байдаг.

ДҮ5. УСНББОУС 42-ыг хэвлэн гаргасны дараа, нийгмийн халамжийн бүх тэтгэмжийг (үг Стандартад тодорхойлсон) түүний дагуу тайлагнах болно. Иймээс УСНББОУС 42-ын цар хүрээнд хамаарах нийгмийн халамжийн бүх тэтгэмжийг энэхүү Стандартын цар хүрээнээс хасахын тулд хянан засварласан.

...

НББОУС 37-ТОЙ ХАРЬЦУУЛАЛТ

УСНББОУС 19-ийг НББОУС 37 (1998)-гоос үндсэндээ бэлтгэсэн. УСНББОУС 19 ба НББОУС 37-гийн хоорондын гол зөрүү нь дараах байдалтай байна:

- Улсын секторын байгууллагуудын нягтлан бодох бүртгэлд эдгээр стандартуудын мөрдөгдөх боломжтой байдлыг тодруулахын тулд УСНББОУС 19 нь НББОУС 37-д зааснаас гадна, нэмэлт тайлбарыг агуулсан байдаг. УСНББОУС 42, *Нийгмийн Халамжийн Тэтгэмж*-ийн цар хүрээнд хамаарах нийгмийн халамжийн тэтгэмжүүдэд УСНББОУС 19-ийг мөрдөхгүй гэдгийг түүнд тодруулж өгсөн. Нийлүүлсэн бараа, үйлчилгээнийхээ үнэ цэнэтэй ойролцоогоор тэнцүү төлбөрийг тэдгээр үр өгөөж хүртэгчдээ хариу болгон шууд хүлээн авдаггүй байгууллагын үзүүлсэн нийгмийн халамжаас үүсэх нөөц ба бэлэвчгүй өр төлбөрт УСНББОУС 19-ийг мөрдөхгүй гэдгийг түүний цар хүрээ хэсэгт заасан. Гэвч байгууллага нь нийгмийн халамжийн хувьд нөөцийг хүлээн зөвшөөрөх сонголт хийсэн бол УСНББОУС 19 нь энэ талаар зарим тодруулга хийхийг шаардана.

УСНББОУС 23, *Арилжааны Бус Ажил Гүйлгээний Орлого (Татвар ба Шилжүүлэг)*-д оруулсан нэмэлт өөрчлөлт

2-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулж, 124Ж параграфыг шинээр нэмсэн. Шинэ текстийн доогуур, харин хасагдсан текстийн дундуур зурсан.

...

Цар хүрээ

2. **Нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурийн дагуу санхүүгийн тайлангаа бэлтгэж, толилуулдаг байгууллага нь арилжааны бус ажил гүйлгээнээс үүссэн орлогыг тайлагнахдаа энэхүү Стандартыг мөрдөнө. Энэ Стандартыг дараах зүйлсэд мөрдөхгүй:**

(a) **Арилжааны бус ажил гүйлгээ болох улсын секторын нэгдэлд; ба**

(б) **УСНББОУС 42, *Нийгмийн Халамжийн Тэтгэмж*-ийн 26-31-р параграфын (даатгалын хандлагын) дагуу тайлагнадаг нийгмийн халамжийн тэтгэмжийн хөтөлбөр дэх нийгмийн даатгалын шимтгэл.**

...

Хүчин төгөлдөр болох хугацаа

...

124Ж. 2019 оны 01 дүгээр сард гаргасан, УСНББОУС 42, Нийгмийн Халамжийн Тэтгэмж-ээр 2-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь УСНББОУС 42-ыг мөрдсөн тухайн тайлант үеэс энэхүү нэмэлт өөрчлөлтийг мөрдөнө.

...

Дүгнэлтийн Үндэслэл

Энэхүү Дүгнэлтийн Үндэслэл нь УСНББОУС 23-ыг дагалдах боловч түүний салиггүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.

...

Нийгмийн хамгааллын хөтөлбөрт оруулах албан журмын шимтгэл

ДҮ26. Энэ Стандарт нь арилжааны бус ажил гүйлгээ болох нийгмийн хамгааллын хөтөлбөрт төлөх албан журмын шимтгэлийг өөрийн цар хүрээнээс хасаагүй. Улс орон бүрд нийгмийн хамгааллын хөтөлбөрөө санхүүжүүлэх янз бүрийн олон арга хэмжээнүүд байдаг. УСНББОУС 23-ыг боловсруулах үедээ УСНББОУСЗ нь нийгмийн хамгааллын хөтөлбөрт албан журмаар төлөх шимтгэл нь арилжааны эсвэл арилжааны бус ажил гүйлгээ болох эсэх нь тухайн хөтөлбөрийн тодорхой арга хэмжээнүүдээс хамаардаг гэж үзсэн бөгөөд уг нийгмийн хамгааллын хөтөлбөрт төлсөн шимтгэлийг энэ Стандартад заасан зарчмуудын дагуу, эсвэл ийм хөтөлбөрийг зохицуулдаг олон улсын буюу үндэсний бусад стандартуудад заасан зарчмуудын дагуу хүлээн зөвшөөрөх эсэхийг тодорхойлохдоо мэргэжлийн шүүн тунгаалт хийдэг.

ДҮ26А. УСНББОУСЗ нь УСНББОУС 42, Нийгмийн Халамжийн Тэтгэмж-ийг боловсруулах үедээ энэ асуудлыг дахин авч хэлэлцсэн. Ийм нийгмийн даатгалын шимтгэл нь арилжааны бус ажил гүйлгээ бөгөөд энэ Стандартын дагуу тайлагнах хэрэгтэй гэж УСНББОУСЗ дүгнэсэн. Байгууллага нь даатгалын хандлагыг ашигласнаар нийгмийн халамжийн тэтгэмжийн хөтөлбөрийг тайлагнах сонголт хийсэн бол үүний гажих нэг тохиолдол үүсдэг. Даатгалын хандлага нь мөнгөн орлогын болон мөнгөн зарлагын гүйлгээний аль алиныг харгалздаг, иймээс даатгалын хандлагаар тайлагнадаг нийгмийн халамжийн тэтгэмжийн хөтөлбөрийг энэ Стандартын дагуу орлого гэж тайлагнахгүй.

УСНББОУС 24, Санхүүгийн Тайлан дахь Төсвийн Мэдээллийн Толилуулга-д оруулсан нэмэлт өөрчлөлт

48-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулж, 54Д параграфыг шинээр нэмсэн. Шинэ текстийн доогуур зурсан.

...

Зэрэгцүүлэгдэх сууриар тусгасан гүйцэтгэлийн дүн ба санхүүгийн тайлан дахь гүйцэтгэлийн дүнгийн хоорондох тохируулга

...

48. Зэрэгцүүлэгдэх суурьтай нийцүүлэн тодорхойлсон гүйцэтгэлийн дүн ба санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрсөн гүйцэтгэлийн дүнгийн хоорондох зөрүүг дараах байдлаар зохих ёсоор ангилж болно:

- (a) Суурийн зөрүү, энэ нь уг батлагдсан төсвийг нягтлан бодох бүртгэлийн сууриас өөр сууриар бэлтгэсэн үед үүсдэг. Жишээлбэл; төсвийг мөнгөн сууриар эсвэл тохируулсан мөнгөн сууриар бэлтгэдэг, харин санхүүгийн тайланг аккрузал сууриар бэлтгэдэг байх;

УСНББОУС 42-НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТЭТГЭМЖ

- (б) Цаг хугацааны зөрүү, энэ нь тухайн санхүүгийн тайланд тусгасан тайлант хугацаанаас уг төсвийн тайлант хугацаа өөр байх үед үүсдэг; ба
- (в) Байгууллагын зөрүү, энэ нь санхүүгийн тайланг бэлтгэж буй тухайн байгууллагын нэг хэсэг болох байгууллагууд эсвэл хөтөлбөрүүдийг төсөвт тусгахгүй байх тохиолдолд үүсдэг.

Мөн санхүүгийн тайлангийн болон төсвийн толилуулгын хувьд хэрэглэсэн хэлбэр загвар ангиллын бүтцийн хувьд зөрүүтэй байж болох юм. Тухайлбал; УСНББОУС 42, Нийгмийн Халамжийн Тэтгэмж-д тодорхойлсон, нийгмийн халамжийн тэтгэмж нь мөнгөн шилжүүлгээр хязгаарлагддаг. Нийгмийн халамжийн талаархи ЗГСС-ийн ангилал нь илүү өргөн хүрээтэй бөгөөд засгийн газруудын үзүүлдэг зарим бие даасан үйлчилгээг агуулсан байдаг.

...

Хүчин төгөлдөр болох хугацаа

...

54Д. 2019 оны 01 дүгээр сард гаргасан, УСНББОУС 42-оор 48-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь УСНББОУС 42-ыг мөрдсөн тухайн тайлант үеэс энэхүү нэмэлт өөрчлөлтийг мөрдөнө.

...

Дүгнэлтийн Үндэслэл

Энэхүү Дүгнэлтийн Үндэслэл нь УСНББОУС 24-ийг дагалдах боловч түүний салиггүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.

...

УСНББОУС 42, Нийгмийн Халамжийн Тэтгэмж-ийн үр дүнд УСНББОУС 24-д хийсэн хянан засварлалт

ДҮ25. УСНББОУС 42, Нийгмийн Халамжийн Тэтгэмж-ийг боловсруулах үедээ УСНББОУСЗ нь өөрийн нийгмийн халамжийн тэтгэмжийн тодорхойлолтонд ЗГСС-ийн дагуу нийгмийн халамж гэж ангилагдах бүх ажил гүйлгээг багтаан тусгахгүй гэдгийг онцлон тэмдэглэсэн. Улсын секторын зарим байгууллагууд нь ЗГСС-ийн суурийг ашиглан төсвийг бэлтгэж болох тул санхүүгийн тайлан болон төсвийн толилуулгад зориулан мөрдсөн ангиллын схем ялгаатай байж болох жишээ болгон нийгмийн халамжийн тэтгэмжийг тусган оруулах нь тайлан бэлтгэгч нарт ач тустай гэж УСНББОУСЗ үзсэн.

Үлгэрчилсэн жишээ

Энэхүү Үлгэрчилсэн жишээ нь УСНББОУС 24-ийг дагалдах боловч түүний салиггүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.

Төсөв ба гүйцэтгэлийн дүнгүүдийн зэрэгцүүлэлтийн тайлан

“ХХ” засгийн газрын 20XX оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон жил

МӨНГӨН СУУРИАР БЭЛТГЭСЭН ТӨСӨВ

(Чиг үүргээр харуулсан төлбөрийн ангилал)

Тэмдэглэл: Төсөв ба нягтлан бодох бүртгэлийн суурь нь өөр байна. Энэхүү Төсөв ба Гүйцэтгэлийн Дүнгүүдийн Зэрэгцүүлэлтийн Тайланг уг төсвийн сууриар бэлтгэсэн.

УСНББОУС 42-НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТЭТГЭМЖ

	Төсөвлөсөн дүнгүүд		Зэрэгцүүлэгдэх сууриар илэрхийлсэн гүйцэтгэлийн дүн	Тодотгосон төсөв ба гүйцэтгэлийн хоорондох зөрүү*
	Анхны	Тодотгосон		

(Тооцооны нэгжээр)

ОРЛОГО

...

ТӨЛБӨР

Эрүүл мэнд	(X)	(X)	(X)	(X)
Боловсрол	(X)	(X)	(X)	(X)
Нийгмийн хэв журам/аюулгүй байдал	(X)	(X)	(X)	(X)
<u>Нийгмийн халамж</u>	<u>(X)</u>	<u>(X)</u>	<u>(X)</u>	<u>(X)</u>
<u>Бусад нийгмийн хамгаалал</u>	<u>(X)</u>	<u>(X)</u>	<u>(X)</u>	<u>(X)</u>
Батлан хамгаалах	(X)	(X)	(X)	(X)
Орон сууц, нийтийн аж ахуй	(X)	(X)	(X)	(X)
Амралт, соёл, шашин	(X)	(X)	(X)	(X)
Эдийн засгийн асуудал	(X)	(X)	(X)	(X)
Бусад	(X)	(X)	(X)	(X)
Нийт төлбөр	(X)	(X)	(X)	(X)

...

* "... зөрүү" гэсэн баганыг заавал шаарддаггүй. Гэхдээ анхны эсвэл тодотгосон гэдгийг зохих ёсоор ойлгомжтой тодорхойлсон төсөв ба гүйцэтгэлийн хоорондох зэрэгцүүлэлтийг тусган оруулж болох юм.

УСНББОУС 42-НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТЭТГЭМЖ

Дэмжих тэмдэглэл тодруулга: Мөнгөн сууриар илэрхийлсэн хоёр жилийн төсөв - “Б” засгийн газрын 20XX оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон жил

	Хоёр төсвийн жилийн анхны төсөв	1* дэх жилийн зорилтот төсөв	1 дэх жилийн засварласан төсөв	1* дэх жилийн зэрэгцүүлэгдэх сууриар илэрхийлсэн гүйцэтгэл	2 дахь жилд ашиглаж болох үлдэгдэл	2 дахь жилийн зорилтот төсөв	2 дахь жилийн засварласан төсөв	2 дахь жилийн зэрэгцүүлэгдэх сууриар илэрхийлсэн гүйцэтгэл	Уг төсвийн жилийн гүйцэтгэл ба төсвийн хоорондох зөрүү*
(Тооцооны нэгжээр)									
ОРЛОГО									
...									
ТӨЛБӨР									
Эрүүл мэнд	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)
Боловсрол	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)
Нийгмийн хэв журам ба аюулгүй байдал	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)
Нийгмийн халамж	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)
Бусад нийгмийн хамгаалал	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)
Батлан хамгаалах	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)
Орон сууц, нийтийн аж ахуй	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)
Амралт, соёл, шашин	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)
Эдийн засгийн асуудлууд	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)
Бусад	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)
Нийт төлбөр	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)
ЦЭВЭР ОРЛОГО (ТӨЛБӨР)	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)

* Энэ баганыг заавал шаарддаггүй. Гэхдээ анхны эсвэл тодотгосон гэдгийг зохих ёсоор ойлгомжтой тодорхойлсон төсөв ба гүйцэтгэлийн хоорондох зэрэгцүүлэлтийг тусган оруулж болох юм.

УСНББОУС 28, Санхүүгийн Хэрэглүүр: Толилуулга-д оруулсан нэмэлт өөрчлөлт

60Ж параграфыг шинээр нэмж, МЗУ23-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулсан. Шинэ текстийн доогуур, харин хасагдсан текстийн дундуур зурсан.

...

Хүчин төгөлдөр болох хугацаа

...

60Ж. 2019 оны 01 дүгээр сард гаргасан, УСНББОУС 42-оор МЗУ23-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь УСНББОУС 42-ыг мөрдсөн тухайн тайлант үеэс энэхүү нэмэлт өөрчлөлтийг мөрдөнө.

Мөрдөх заавар удирдамж

...

Тодорхойлолт (9-12-р параграф)

Санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөр

...

МЗУ23. Хууль ёсны үүргийг дараах гэх мэт олон арга замаар тайлагнаж болно:

- Орлогын татвар төлөх үүргийг уг орлогын татварыг зохицуулдаг олон улсын буюу үндэсний нягтлан бодох бүртгэлийн холбогдох стандартын дагуу тайлагнана;
- Нийгмийн халамж үзүүлэх үүргийг УСНББОУС 3, Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлого, Нягтлан Бодох Бүртгэлийн Тооцооллын Өөрчлөлт ба Алдаа ба УСНББОУС 19-ийн УСНББОУС 42, Нийгмийн Халамжийн Тэтгэмж-ийн дагуу тайлагнана.
- Бусад хууль ёсны үүргийг УСНББОУС 19-ийн дагуу тайлагнана.

УСНББОУС 33, Аккруэл Суурьт Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Анх Удаа Мөрдөх-д оруулсан нэмэлт өөрчлөлт

36-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулж, 134А, 134Б, 154Ж параграфыг шинээр нэмсэн. Шинэ текстийн доогуур, харин хасагдсан текстийн дундуур зурсан.

...

Шилжилтийн үед үнэн зөв толилуулга ба аккруэл суурьт УСНББОУС-тай нийцэлтэнд нөлөөлөх чөлөөлөх нөхцлүүд

...

Хөрөнгө ба/буюу өр төлбөрийн хүлээн зөвшөөрөлт, хэмжилтийн хувьд чөлөөлөгдөх гурван жилийн шилжилтийн хугацаа

Хөрөнгө ба/буюу өр төлбөрийн хүлээн зөвшөөрөлт, хэмжилт

36. Анх удаа мөрдөж буй байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу хөрөнгө, өр төлбөрийг хүлээн зөвшөөрдөггүй тохиолдолд УСНББОУС-ыг мөрдсөн өдрөөс

УСНББОУС 42-НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТЭТГЭМЖ

хойши гурван жилийн доторх тодорхой нэг өдрөөс эхлэх тайлант үеүдийн хувьд дараах хөрөнгө, өр төлбөрийг хүлээн зөвшөөрөх буюу хэмжих шаардлагагүй юм:

- (а) Бараа материал (УСНББОУС 12, *Бараа материал*-ыг үзнэ үү);
- (б) Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө (УСНББОУС 16, *Хөрөнгө Оруулалтын Зориулалттай Үл Хөдлөх Хөрөнгө*-ийг үзнэ үү);
- (в) Үндсэн хөрөнгө (УСНББОУС 17, *Үндсэн Хөрөнгө*-ийг үзнэ үү);
- (г) Тогтоосон тэтгэмжийн хөтөлбөр ба ажилтны урт хугацааны бусад тэтгэмж (УСНББОУС 39, *Ажилтны Тэтгэмж*-ийг үзнэ үү);
- (д) Биологийн хөрөнгө ба хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн (УСНББОУС 27, *Хөдөө Аж Ахуй*-г үзнэ үү);
- (е) Биет бус хөрөнгө (УСНББОУС 31, *Биет Бус Хөрөнгө*-ийг үзнэ үү);
- (ж) Санхүүгийн өр төлбөрийн загвар эсвэл эзэмшигчид эрх олгох загварын дагуух үйлчилгээний концессын хөрөнгө ба холбогдох өр төлбөр (УСНББОУС 32, *Үйлчилгээний Концессын Хэлцэл: Эрх бүхий этгээд*-ийг үзнэ үү);
- (и) Санхүүгийн хэрэглүүр (УСНББОУС 41, Санхүүгийн Хэрэглүүр ~~УСНББОУС 29, Санхүүгийн Хэрэглүүр: Хүлээн Зөвшөөрөлт ба Хэмжээ~~-ийг үзнэ үү);
- (к) Нийгмийн халамжийн тэтгэмж (УСНББОУС 42, Нийгмийн Халамжийн Тэтгэмж-ийг үзнэ үү).

...

Мөрдөх хугацаанд үнэн зөв толилуулга ба аккруэл суурьт УСНББОУС-тай нийцэлтэнд нөлөөлөхгүй чөлөөлөх нөхцлүүд

...

УСНББОУС 42, Нийгмийн Халамжийн Тэтгэмж

134А. УСНББОУС-уудыг анх мөрдсөн өдөр, эсвэл анх удаа мөрдөж буй байгууллага нь гурван жилийн шилжилтийн чөлөөлөх нөхцлүүдийн давуу талыг ашигладаг тохиолдолд ийм чөлөөлөлт олгосон нөхцлүүдийн хугацаа дууссан өдөр, эсвэл холбогдох өр төлбөрийг хүлээн зөвшөөрсөн ба/буюу хэмжсэн өдөр (аль түрүүнд болох өдөр) уг анх удаа мөрдөж буй байгууллага нь нийгмийн халамжийн тэтгэмжийн хөтөлбөрийн хувьд түүний анхны өр төлбөрийг тэрхүү өдөр УСНББОУС 42-ын дагуу тодорхойлно.

134Б. Дээрх 134А параграфын дагуу тодорхойлсон, анхны өр төлбөр нь анх удаа мөрдөж буй байгууллагын нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу тухайн зэрэгцүүлэгдэх тайлант үеийн эцэст хүлээн зөвшөөрсөн ба/буюу хэмжсэн өр төлбөрөөс их эсвэл бага байвал уг анх удаа мөрдөж буй байгууллага нь тэрхүү нэмэгдэлт/бүүралтыг холбогдох зүйлсийг хүлээн зөвшөөрсөн ба/буюу хэмжсэн тайлант үеийн хүримтлагдсан ашиг, алдагдлын эхний үлдэгдэлд хүлээн зөвшөөрнө.

...

Хүчин төгөлдөр болох хугацаа

...

154Ж. 2019 оны 01 дүгээр сард гаргасан, УСНББОУС 42, Нийгмийн Халамжийн Тэтгэмж-ээр 36-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулж, 134А, 134Б параграфыг шинээр нэмсэн. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг 2019 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамарсан жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2019 оны 01

УСНББОУС 42-НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТЭТГЭМЖ

дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийх бөгөөд УСНББОУС 41-ийг мөн үг өмнөх тайлант хугацаанд дагаж мөрднө.

...

Дүгнэлтийн Үндэслэл

Энэхүү Дүгнэлтийн Үндэслэл нь УСНББОУС 33-ыг дагалдах боловч түүний салиггүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.

...

Үнэн зөв толилуулга ба аккруэл суурьт УСНББОУС-тай нийцэлтэнд нөлөөлдөг чөлөөлөх нөхцлүүд

...

УСНББОУС 42, Нийгмийн Халамжийн Тэтгэмж

ДҮ60А. УСНББОУСЗ нь УСНББОУС 42, Нийгмийн Халамжийн Тэтгэмж-ийг 2019 оны 01 дүгээр сард гаргасан. Нийгмийн халамжийн тэтгэмжтэй холбоотой өр төлбөрийн хүлээн зөвшөөрөлт ба/буюу хэмжилт нь улсын секторын зарим байгууллагуудын хувьд хүндрэлтэй байж болох юм гэж УСНББОУСЗ мэдэгдсэн. Иймээс анх удаа мөрдөж буй байгууллагын хувьд нийгмийн халамжийн тэтгэмжтэй холбоотой өр төлбөрийн хүлээн зөвшөөрөлт ба/буюу хэмжилтийн гурван жилийн чөлөөлөх хугацааг олгох хэрэгтэй гэж УСНББОУСЗ үзсэн.

...

Хэрэгжүүлэх заавар удирдамж

Энэхүү хэрэгжүүлэх заавар удирдамж нь УСНББОУС 33-ыг дагалдах боловч түүний салиггүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.

...

Толилуулга ба тодруулга

...

УСНББОУС 33, Аккруэл Суурьт УСНББОУС-ыг Анх Удаа Мөрдөх-д заасан, шилжилтийн үеийн чөлөөлөх нөхцлүүд ба заалтуудын товчоо

ХЗУ91. Аккруэл суурьт бусад УСНББОУС-д тусгасан, шилжилтийн үеийн чөлөөлөх нөхцлүүд ба заалтуудыг дараах схемд товчоолон харуулав.

...

УСНББОУС 42-НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТЭТГЭМЖ

УСНББОУС	Олгосон шилжилтийн үеийн чөлөөлөх нөхцлүүд							
	Үгүй	Тийм						
	Төсөөлөн тооцсон өртөг	Хүлээн зөвшөөрөлтөөс 3 жилийн хугацаанд чөлөөлөх	Хэмжилтээс 3 жилийн хугацаанд чөлөөлөх	Хүлээн зөвшөөрөлт ба/буюу хэмжилтээс 3 жилийн хугацаанд чөлөөлөх	Тодруулгаас 3 жилийн хугацаанд чөлөөлөх	Ажил гүйлгээ, үлдэгдэл, орлого, зардлыг устгаж цэвэрлэх	Бусад	
<u>УСНББОУС 42,</u> <u>Нийгмийн Халамжийн</u> <u>Тэтгэмж</u>		√ Нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу хүлээн зөвшөөрөөгүй нийгмийн халамжийн тэтгэмжийн өр төлбөр	√ Нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу хүлээн зөвшөөрсөн нийгмийн халамжийн тэтгэмжийн өр төлбөр					

Дүгнэлтийн Үндэслэл

Энэхүү Дүгнэлтийн Үндэслэл нь УСНББОУС 42-ыг дагалдах боловч түүний салиггүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.

Зорилго (1-2-р параграф)

ДҮ1. Нийгмийн халамжийн тэтгэмжийг зохицуулдаг Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС) байхгүй тохиолдолд улсын секторын байгууллагууд нь нийгмийн халамжийн тэтгэмжийг хүлээн зөвшөөрөх, хэмжих, толилуулах өөрийн нягтлан бодох бүртгэлийн бодлогыг боловсруулах шаардлагатай байсан. Үүний улмаас нийгмийн халамжийн тэтгэмжтэй холбоотой ажил гүйлгээ болон үүргийг нийтлэг зорилготой санхүүгийн тайлан (санхүүгийн тайлан)-д тууштай буюу зохистой тайлагнаагүй байж болох юм. Иймээс хэрэглэгчид нь байгууллагын үзүүлж буй нийгмийн халамжийн тэтгэмжийг тогтоох ба тэдгээрийн санхүүгийн үр нөлөөг үнэлэхэд шаардлагатай мэдээллийг олж авах боломжгүй байж болно. УСНББОУС 42 нь улсын секторын байгууллагууд нийгмийн халамжийн тэтгэмжийг тайлагнах тууштай болон зэрэгцүүлэгдэх байдлыг дэмжин урамшуулна гэж УСНББОУС3 үздэг.

Цар хүрээ ба тодорхойлолт (3-5-р параграф)

Түүх

ДҮ2. Одоо байгаа УСНББОУС-ууд нь нийгмийн халамжийн тэтгэмжийг тодорхойлоогүй байсан гэдгийг УСНББОУС3 нь УСНББОУС 42-ыг боловсруулах үедээ тэмдэглэсэн. Харин өргөн хүрээтэй тайлбар тодорхойлолтыг УСНББОУС 19, *Нөөц, Болзошгүй Өр Төлбөр ба Болзошгүй Хөрөнгө*-д тусгасан

ДҮ3. УСНББОУС 19-д “нийгмийн халамж гэдэг нь засгийн газрын нийгмийн бодлогын зорилтуудыг хэрэгжүүлэх явцад нийлүүлсэн бараа, үйлчилгээ болон бусад үр өгөөжийг хэлнэ. Ийм халамжинд дараах зүйлс хамаарч болно:

- (а) Тухайн нийгэмд эрүүл мэнд, боловсрол, орон байр, тээврийн болон бусад нийгмийн үйлчилгээ үзүүлэх. Ихэнх тохиолдолд энэ нь тэдгээр үйлчилгээний үнэ цэнэтэй адилтгах дүн төлөхийг уг үйлчилгээ хүлээн авагчдаас шаарддаггүй; ба
- (б) Гэр бүл, өндөр настан, тахир дутуу иргэд, ажилгүйчүүд, ахмад дайчид болон бусад иргэдэд олгосон тэтгэмжийн төлбөр. Өөрөөр хэлбэл, бүх түвшний засаг захиргааны байгууллага нь тухайн нийгмийн иргэд болон тодорхой бүлэг хүмүүст санхүүгийн туслалцаа үзүүлж, тэднийг өөрсдийн тухайлсан хэрэгцээ шаардлагаа хангах буюу орлогоо нэмэгдүүлэхийн тулд үйлчилгээ авах боломжийг олгодог” гэж заасан.

ДҮ4. УСНББОУС3 нь энэ талбарт өмнө хийсэн ажлуудыг мөн харгалзан үзсэн. Өргөн хүрээтэй янз бүрийн нийгмийн халамжийн тэтгэмжийг хэрхэн тайлагнах талаархи санал сэтгэгдлийг 2004 оны Саналын Урилга (СУ), *Засгийн Газрын Нийгмийн Бодлогуудын Тайлагнал*–аар цуглуулан авсан. “Засгийн газрын үйл ажиллагааны бусад ангиллуудын (жишээлбэл; Батлан хамгаалах, Нийгмийн хэв журам ба аюулгүй байдал, Нийтийн аж ахуйн үйлчилгээний) дагуу нийгмийн халамжийг бас үзүүлж болно” гэж СУ-д тэмдэглэсэн.” Эдгээрийг “хамтын үйлчилгээ” эсвэл “хамтын бараа, үйлчилгээ” гэж ихэвчлэн нэрлэдэг.

ДҮ5. СУ-д хариу ирүүлсэн хүмүүс нь нийгмийн халамжийн талаар УСНББОУС боловсруулахыг дэмжсэн. Гэвч УСНББОУС3 нь нийгмийн даатгалын шимтгэлийн мөнгөн шилжүүлгийн хөтөлбөрийн хувьд одоогийн үүрэг яг хэзээ үүсэх эсэх талаар зөвшилцөлд хүрч чадаагүй. Иймээс 2008 онд УСНББОУС3 нь Саналын Төсөл (СТ) 34, *Нийгмийн Халамжийн Тэтгэмж: Хувь Хүмүүс буюу Айл Өрхөд Олгох Мөнгөн Шилжүүлгийн Тодруулга* ба Зөвлөлдөх Баримт Бичиг (ЗББ), *Нийгмийн Халамжийн Тэтгэмж: Хүлээн Зөвшөөрөлт ба Хэмжилтийн Асуудлууд*–ыг гаргасан. Мөн энэ үед УСНББОУС3 нь Төслийн Хураангуй, *Төсвийн Урт Хугацааны Тогтвортой Байдал*-ыг гаргасан.

УСНББОУС 42-НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТЭТГЭМЖ

- ДҮ6. Тэдгээр хариулт ирүүлсэн хүмүүс нь санхүүгийн тайланд санал болгож буй уг тодруулгаар нийгмийн халамжийн тэтгэмжийн талаархи хангалттай мэдээллийг тусган илэрхийлж чадахгүй гэж үзсэн. Иймээс УСНББОУСЗ нь СТ 34-ийг цааш үргэлжлүүлэхгүй байхыг зөвшөөрсөн.
- ДҮ7. ЗББ, *Нийгмийн Халамжийн Тэтгэмж: Хүлээн Зөвшөөрөлт ба Хэмжилтийн Асуудлууд* нь 2004 оны СУ-д тусгасан, нийгмийн халамжийн тэтгэмжийн тодорхойлолтоос арай явцуу хүрэн тодорхойлолтыг санал болгосон. ЗББ-т нийгмийн халамжийн тэтгэмжийн доорх тодорхойлолтыг тусгасан:
- “Нийт хүн амыг эсвэл хүн амын тодорхой сегментийг нийгмийн зарим эрсдлүүдээс хамгаалахын тулд хувь хүн буюу айл өрхөд арилжааны бус ажил гүйлгээгээр байгууллагын олгож буй
- (а) Мөнгөн шилжүүлэг; ба
- (б) Хамтын болон хувийн бараа, үйлчилгээ
- гэж УСНББОУСЗ нь нийгмийн халамжийн тэтгэмжийг тодорхойлсон байдаг”.
- ДҮ8. Нийгмийн халамжийн тэтгэмж нь нийгмийн эрсдлүүдтэй холбоотой гэсэн санааг энэхүү тодорхойлолт анх удаагаа УСНББОУСЗ-ийн ном бүтээлд тусган оруулсан. Энэхүү тодорхойлолтын дагуу бүх мөнгөн шилжүүлэг эсвэл бүх хамтын болон хувийн бараа, үйлчилгээ нь нийгмийн халамжийн тэтгэмж болно гэсэн үг биш юм. Зөвхөн нийт хүн амыг эсвэл хүн амын тодорхой сегментийг нийгмийн зарим эрсдлүүдээс хамгаалахын тулд олгож буй тэдгээр мөнгөн шилжүүлэг эсвэл хамтын болон хувийн бараа, үйлчилгээ нь нийгмийн халамжийн тэтгэмжийн тодорхойлолтыг хангана. Гэвч тус ЗББ-т нийгмийн эрсдлийг тодорхойлоогүй.
- ДҮ9. Хэдийгээр явцуу цар хүрээтэй ба нийгмийн эрсдэлтэй холбоотой боловч ЗББ-ийн цар хүрээнд хамаарах нийгмийн халамжийн тэтгэмжийн хувьд одоогийн үүрэг хэзээ үүсэх талаар УСНББОУСЗ нь зөвшилцөлд хүрээгүй. *Улсын Секторын Байгууллагуудын Нийтлэг Зорилготой Санхүүгийн Тайлагналын Онолын Үзэл Баримтлал (Онолын үзэл баримтлал)*-ыг боловсруулах өөрийн ажил болон нийгмийн халамжийн тэтгэмжийн тайлагналын хооронд харилцан уялдаа байгааг УСНББОУСЗ хүлээн зөвшөөрсөн. *Онолын үзэл баримтлал*-ын элементүүд болон хүлээн зөвшөөрөлтийн үе шатаар өр төлбөрийг тодорхойлдог. Энэхүү тодорхойлолт ба дэмжих шинжилгээ нь нийгмийн халамжийн тэтгэмжийн тайлагналд нөлөө үзүүлэх юм. Иймээс *Онолын үзэл баримтлал*-ыг иж бүрэн болгон дуусгах хүртэл УСНББОУСЗ нь энэ сэдвийн талаархи цаашдын ажлыг хойшлуулахаар шийдвэрлэсэн.
- ДҮ10. Энэхүү завсрын хугацаанд уг төслийн хураангуйд үндэслэн УСНББОУСЗ нь улсын секторын санхүүгийн урт хугацааны тогтвортой байдлын талаархи төслийг 2008 онд эхлүүлсэн. Санал Болгосон Практик Удирдамж (СБПУ) 1, *Байгууллагын Санхүүгийн Урт Хугацааны Тогтвортой Байдлын Тайлагнал*-ыг 2013 онд гаргасан.
- ДҮ11. СБПУ 1 нь байгууллагын санхүүгийн урт хугацааны тогтвортой байдлын, үүн дотроо уг байгууллагын үзүүлдэг нийгмийн халамжийн тэтгэмжийн талаархи хэрэглэгчдийн мэдээллийн хэрэгцээг хангаж чадах, нийтлэг зорилготой санхүүгийн тайлан илтгэлийг бэлтгэх заавар удирдамжаар хангадаг.
- ДҮ12. Нийгмийн халамжийн тэтгэмжийн хүрээнд СБПУ 1-ийн дагуу бэлтгэсэн, нийтлэг зорилготой санхүүгийн тайлан илтгэл нь ирээдүйд барагдуулахаар хүлээгдэж буй өглөг, үүн дотроо нийгмийн халамжийн тэтгэмжийн хөтөлбөрийн зохих шалгуурыг хангаагүй хувь хүмүүст төлөх өглөг, эсвэл нийгмийн халамжийн тэтгэмжийг ирээдүйд авах эрх олгох тийм шимтгэлийг хөтөлбөрт одоогоор төлөөгүй байгаа хувь хүмүүст төлөх өглөгийн талаархи мэдээллээр хангана. Ийм өглөг нь одоогийн үүргийн тодорхойлолтыг хангах ба ингэснээр санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрөх хэрэгтэй эсэхийг СБПУ 1-д авч үзээгүй.

УСНББОУС 42-НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТЭТГЭМЖ

- ДҮ13. СБПУ 1-ийн дагуу бэлтгэсэн, нийтлэг зорилготой санхүүгийн тайлан илтгэл нь нийгмийн халамжийн тэтгэмжийг санхүүжүүлэхэд ашиглах ба ирээдүйд хэрэгжүүлэхээр хүлээгдэж буй нөөцийн талаархи мэдээллийг бас агуулсан байдаг. Олон улс орны хувьд ийм тайлан илтгэл нь татварын ирээдүйн орлогыг тусгадаг. Байгууллага нь эдгээр нөөцийг одоогоор хяналтандаа оруулаагүй байгаа учраас санхүүгийн тайландаа хүлээн зөвшөөрөхгүй.
- ДҮ14. Нийгмийн халамжийн тэтгэмжийн талаархи өөрийн ажлыг УСНББОУСЗ нь 2014 онд дахин эхлүүлсэн. Өмнөх төслүүдэд тусгасан, нийгмийн халамжийн тэтгэмжийн өргөн цар хүрээ нь УСНББОУСЗ зөвшилцөлд хүрч чадаагүйн нэг гол хүчин зүйл гэдгийг УСНББОУСЗ цохон тэмдэглэсэн. Иймээс УСНББОУСЗ нь нийгмийн халамжийн тэтгэмжийн илүү нарийвчилсан тодорхойлолт батлан гаргахаар шийдвэрлэсэн. Мөн энэ үед УСНББОУСЗ нь арилжааны бус зардлын талаархи төслийн ажил эхлүүлэхийг зөвшөөрсөн; нийгмийн халамжийн тэтгэмжийн илүү нарийвчилсан тодорхойлолт гаргах нь хоёр төслийн аль алины төслийн удирдлагын хэрэгцээ шаардлагыг хамгийн сайнаар ханган биелүүлнэ гэж УСНББОУСЗ үзсэн.

Засгийн Газрын Санхүүгийн Статистик (ЗГСС)-ийн үүрэг

- ДҮ15. Тайлагналын статистикийн сууриас ялгаатай байдлыг тохиромжтой бол багасгах нь ач холбогдолтой гэж УСНББОУСЗ үздэг. Иймээс УСНББОУСЗ нь ЗГСС-т харгалзан тусгадаг нийгмийн халамжийн тэтгэмжийн арга хандлагыг авч үзсэн.
- ДҮ16. Нийгмийн халамжийн тэтгэмж, бусад мөнгөн бус шилжүүлэг, хамтын үйлчилгээ нь өр төлбөр ба зардлын хүлээн зөвшөөрөлт, хэмжилтийн хувьд ижил төсөөтэй асуудлуудыг үүсгэнэ гэж УСНББОУСЗ нь ЗББ, *Нийгмийн Халамжийн Тэтгэмжийн Хүлээн Зөвшөөрөлт ба Хэмжилт* (2015 онд гаргасан)-ийг боловсруулах үедээ дүгнэсэн. Гэхдээ нийгмийн тодорхой асуудлуудыг харгалзсан ажил гүйлгээний (өөрөөр хэлбэл, нийгмийн халамжийн тэтгэмжийн) хүлээн зөвшөөрөлт ба хэмжилтэнд янз бүрийн хүчин зүйлс нөлөөлнө, харин тэдгээр бусад ажил гүйлгээний хувьд ийм хүчин зүйлс нөлөөлөхгүй гэж УСНББОУСЗ үзсэн. Тухайлбал; нийгмийн халамжийн тэтгэмжийн өглөгийн хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт нь зохих шалгуурыг хангасан хувь хүмүүстэй холбоотой байж болох юм.
- ДҮ17. ЗГСС-т тодорхойлсон, эдийн засгийн үр дагавар нь ирээдүйн УСНББОУС-ын эдийн засгийн үр дагавартай ижил төсөөтэй байх магадлалтай гэдгийг УСНББОУСЗ нь ЗГСС-т тусгасан нийгмийн халамжийн тэтгэмжийн арга хандлагыг авч үзсэний дараа цохон тэмдэглэсэн. УСНББОУСЗ нь нийгмийн халамжийн тэтгэмжийн талаархи өөрийн тодорхойлолтыг ЗГСС-ийн тодорхойлолттой аль болох боломжит хэмжээгээр нийцүүлэн уялдуулахаар шийдвэрлэсэн. Энэ нь ЗББ, *Нийгмийн Халамжийн Тэтгэмжийн Хүлээн Зөвшөөрөлт ба Хэмжилт*-д тусгасан арга хандлага юм.
- ДҮ18. ЗГСС-тай нийцүүлэн уялдуулалт нь мөн чанарын хувьд ижил төсөөгүй ажил гүйлгээ болон үйл явдлыг ялган зааглахын тулд илүү ойлгомжтой тодорхойлолт гаргах санаа зорилготой байсан. Ингэснээр УСНББОУСЗ-ийн бодлогын баримт бичиг, *УСНББОУС-уудыг Боловсруулах явцад ЗГСС-ийн Тайлагналын Зааврыг Харгалзах Үйл Явц*-ын дагуу энэхүү хоёр үзэл баримтлалын хоорондох нийцлийг мөн хамгийн их болгодог.

Зөвлөлдөх Баримт Бичиг, “Нийгмийн Халамжийн Тэтгэмжийн Хүлээн Зөвшөөрөлт ба Хэмжилт”-д өгсөн хариултауд

- ДҮ19. Хариулт ирүүлсэн ихэнх хүмүүс нь 2015 оны ЗББ-т заасан төслийн цар хүрээ, түүнчлэн уг төслийн цар хүрээ, нийгмийн халамжийн тэтгэмжийн болон нийгмийн эрсдлийн тодорхойлолтуудыг ЗГСС-тай нийцүүлэх УСНББОУСЗ-ийн санаа зорилгыг дэмжсэн. ЗГСС-тай нийцүүлэн уялдуулалт нь УСНББОУС-ыг тайлбарлах ба түүний мөрдөлтийн тууштай байдлыг хангахад туслалцаа үзүүлнэ гэж тэдгээр хариулт ирүүлсэн хүмүүс үзэж байсан.
- ДҮ20. Цөөнх боловч нэлээд олон хүмүүс асуудал дэвшүүлсэн. Гол асуудлууд нь дараах байдалтай байсан:

УСНББОУС 42-НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТЭТГЭМЖ

- (а) Нийгмийн эрсдлийн тодорхойлолт. Хариулт ирүүлсэн олон хүмүүс нь нийгмийн эрсдлийн тодорхойлолтыг практикт хэрэглэхэд хүндрэлтэй, иймээс нийгмийн халамжийн тэтгэмж ба засгийн газрын арилжааны бус бусад зарим зардлыг өөр хооронд нь ялгахад төвөгтэй байдаг гэж үзсэн.
- (б) Нийгмийн халамжийн тэтгэмж ба арилжааны бус зардлын хоорондох хил зааг. Мөнгөн бус нийгмийн халамжийн тэтгэмж ба мөнгөн бус бусад шилжүүлэг нь нэг ижил асуудлууд үүсгэдэг гэж хариулт ирүүлсэн зарим хүмүүс үзэж байсан. Хариулт ирүүлсэн тэдгээр хүмүүс нь 2015 оны ЗББ-ээр нийгмийн халамжийн тэтгэмж ба арилжааны бус бусад зардлын хооронд зохиомол хил зааг тогтоосон гэж дүгнэсэн.

ДҮ21. УСНББОУСЗ нь СТ 63, *Нийгмийн Халамжийн Тэтгэмж*-ийг боловсруулах үедээ эдгээр асуудлуудыг дараах байдлаар авч үзсэн:

- (а) Нийгмийн эрсдлийн тодорхойлолтыг эдийн засаг/статистикийн үзэл баримтлалтай биш, харин нягтлан бодох бүртгэлийн үзэл баримтлалтай нийцүүлэхийн тулд өөрчлөн гаргасан. Тодорхойлолтын үг хэллэгийг СТ 63-т өөрчлөн найруулсан боловч ингэж өөрчлөх УСНББОУСЗ-ийн санаа зорилго нь нийгмийн эрсдэл гэж үзэх тийм эрсдлийг өөрчлөн засварлах биш, харин тайлан бэлтгэгчдэд уг тодорхойлолтын утгыг илүү ойлгомжтой болгож өгөх явдал юм. Нийгмийн халамжийн тэтгэмжийн тодорхойлолтын ойлгомжтой байдлыг дээшлүүлэхийн тулд уг тодорхойлолтод бас нэмэлт өөрчлөлт оруулсан.
- (б) СТ 63 нь нийгмийн эрсдэл ба бусад эрсдлүүдийг өөр хооронд нь ялгаж өгсөн. Газар хөдлөлт буюу үерийн эрсдэл гэх мэт газарзүйн болон уур амьсгалын шинж чанартай холбоотой эрсдэл нь бусад эрсдлийн жишээ юм. Ийм эрсдэл үүсэхэд хүргэх гамшиг буюу үйл явдлууд нь хувь хүмүүс ба/буюу айл өрхийн шинж чанартай холбоогүй байдаг. Хувь хүмүүс ба/буюу айл өрхийн шинж чанартай холбоотой байдал нь нийгмийн эрсдлийн ялгарах шинж юм. Нийгмийн эрсдэлд засгийн газрын үзүүлэх хариу үйлдэл нь бусад эрсдэлд түүний үзүүлэх хариу үйлдлээс ихэвчлэн өөр байдаг гэдгийг УСНББОУСЗ мөн тэмдэглэсэн. Нийгмийн эрсдлүүдийг харгалзан шийдвэрлэхийн тулд үүсгэн бий болгосон ба хууль тогтоомжоор батлан хэрэгжүүлдэг хөтөлбөрийн тусламжтайгаар засгийн газрууд нь эдгээр эрсдлийн гарч тохиолдолтыг ихэвчлэн төлөвлөдөг. Харин эсрэгээр, газарзүйн эрсдэл гэх мэт бусад эрсдлүүдэд засгийн газрын үзүүлэх хариу нь ихэвчлэн сөрөг хариу үйлдэл хэлбэртэй байх бөгөөд үер, газар хөдлөлт гэх үйл явдал гарч тохиолдсоны дараа хэрэгжүүлж болох юм. Бусад эрсдлүүдэд үзүүлэх сөрөг хариу үйлдлийн шинж нь энэ Стандарт биш, харин арилжааны бус зардлын төсөлтэй илүү сайн нийцнэ гэж УСНББОУСЗ үзсэн. Энэхүү хандлага нь ЗГСС-т тусгасан хандлагатай нийцнэ гэдгийг УСНББОУСЗ бас тэмдэглэсэн.
- (в) Тодорхой хувь хүн, айл өрхөд олгох тэтгэмж болон нийтлэг олгож болох тэтгэмжийг СТ 63-д ялган авч үзсэн. Ийм ялгаатай байдал нь нийгмийн халамжийн тэтгэмж ба арилжааны бус бусад зардлын хооронд зохиомол бус, харин зарчимд илүүтэй тулгуурласан хил зааг бүрдүүлэх санаа зорилготой юм. Нийгмийн эрсдэлтэй холбоотой өр төлбөр ба зардлыг тухайн нийгмийн халамжийн тэтгэмжийг авах хувь хүний шалгуурыг лавлагаа болгосноор хэмжиж болно. Арилжааны бус бусад зардлын хувьд ийм шалгуурыг хэрэглэдэггүй. Нийгмийн халамжийн тэтгэмж ба арилжааны бус бусад зардал нь тасралтгүй үргэлжлэх хэлбэртэй бөгөөд аливаа хил зааг нь ямар нэг хэмжээгээр зохиомол байна гэдгийг УСНББОУСЗ нь энэхүү хил заагийг боловсруулах үедээ хүлээн зөвшөөрсөн. Гэвч нийгмийн халамжийн тэтгэмжийн төслийг удирдан зохицуулах боломжтой байхын тулд хил зааг шаардлагатай гэдгийг УСНББОУСЗ-ийн өмнөх туршлагаар түүнд итгэн үнэмшүүлж өгсөн.

ДҮ22. Нийтлэг үзүүлж болох үйлчилгээнээс бусад тохиолдолд эдгээр шийдвэр нь СТ 63-ын цар хүрээ, нийгмийн халамжийн тэтгэмжийн болон нийгмийн эрсдлийн тодорхойлолтуудыг ЗГСС-ийн цар хүрээ, тодорхойлолтуудтай нийцүүлэн уялдуулах үр дүнтэй байна. Эрүүл мэндийн ерөнхий тусламж үйлчилгээ гэх мэт нийтлэг үзүүлж болох үйлчилгээг ЗГСС-ийн дагуу нийгмийн халамжийн тэтгэмж гэж үздэг боловч СТ 63-ын цар хүрээнд хамаардаггүй. Ингэж нийцүүлэн

УСНББОУС 42-НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТЭТГЭМЖ

уялдуулах үр дүн нь ЗГСС-тай нийцүүлэхийг дэмждэг, хариулт ирүүлэгч олонхийн саналыг ханган биелүүлэхээс гадна нийгмийн халамжийн тэтгэмж ба үйл ажиллагааны бус бусад зардлын хооронд хил зааг байх ёстой гэж үздэг, хариулт ирүүлэгч цөөнхийн асуудлыг харгалзан тусгана гэж УСНББОУСЗ дүгнэсэн.

СТ 63, “Нийгмийн халамжийн тэтгэмж”-д ирүүлсэн хариултауд

- ДҮ23. 2015 оны ЗББ-т санал болгосончлон, СТ 63 нь хамтын үйлчилгээ болон нийтлэг үзүүлж болох үйлчилгээг нийгмийн халамжийн тэтгэмжийн цар хүрээнээс тусгайлан хассан. СТ 63-т хариулт ирүүлсэн ихэнх хүмүүс нь уг санал болгосон цар хүрээг дэмжсэн. Иймээс уг санал болгосон цар хүрээг дэмжсэн, хариулт ирүүлсэн хүмүүс нь нийгмийн халамжийн тэтгэмж ба нийтлэг үзүүлж болох үйлчилгээний хоорондох хил заагийг илт ойлгомжтой тодорхойлох нь чухал ач холбогдолтой гэсэн саналыг илэрхийлсэн. Нийгмийн халамжийн тэтгэмжийн болон нийтлэг үзүүлж болох үйлчилгээний нягтлан бодох бүртгэлийн арга хандлага нь ажил гүйлгээний янз бүрийн шинж төрөлтэй холбоотойгоор ямар нэг зөрүүтэй байж болох боловч нэг ижил онолын суурь үндэслэлтэй байвал зохино гэдгийг тэд бас санал болгосон.
- ДҮ24. СТ 63-д санал болгосон цар хүрээ болон тодорхойлолтыг дэмждэггүй, хариулт ирүүлсэн цөөнх хүмүүс нь ижил төсөөтэй асуудалд санаа зовж байсан. Хариулт ирүүлсэн тэдгээр хүмүүс нь будлиан болон хил заагийн боломжит асуудлууд буюу нягтлан бодох бүртгэлийн янз бүрийн арга хандлагаас зайлсхийхийн тулд уг цар хүрээ ба тодорхойлолтуудыг цаашид тодруулах шаардлагатай гэж үзсэн. Ялангуяа, нийгмийн халамжийн тэтгэмж ба нийтлэг үзүүлж болох үйлчилгээний хоорондох хил зааг тодорхой, ойлгомжтой биш тул нийтлэг үзүүлж болох үйлчилгээг уг санал болгосон Стандартын цар хүрээнээс хассанаар түүнийг мөрдөхөд төвөгтэй болно гэж тэд үзэж байсан.
- ДҮ25. Эдгээр санаа зовж буй асуудлуудын улмаас УСНББОУСЗ нь уг цар хүрээ ба тодорхойлолтуудыг ойлгомжтой болгохоор шийдвэрлэсэн. Хариулт ирүүлсэн хүмүүс нь СТ 63-д дурдсан, цар хүрээ ба тодорхойлолтуудын талаар янз бүрийн ойлголттой байна гэдгийг УСНББОУСЗ цохон тэмдэглэсэн. Хариулт ирүүлсэн зарим хүмүүс нь нийгмийн халамжийн тэтгэмж бол мөнгөн шилжүүлгээр хязгаарлагдана гэж үзэх хандлагатай байдаг, харин өөр зарим хүмүүс нь нийгмийн халамжийн тэтгэмжид зарим үйлчилгээ үзүүлэлт хамаарна гэж үздэг.
- ДҮ26. СТ 63 нь нийгмийн халамжийн тэтгэмжийн тодорхойлолтын (болон нийгмийн халамжийн тэтгэмж нь мөнгөн шилжүүлгээр хязгаарлагдах эсэх) талаар, улмаар энэхүү санал болгосон Стандартын цар хүрээний хувьд хангалттай ойлгомжтой байгаагүй гэж УСНББОУСЗ дүгнэсэн. Нийгмийн халамжийн тэтгэмжийн тодорхойлолтыг хангадаг бүх ажил гүйлгээ нь мөнгөн шилжүүлэг байна, харин нийгмийн халамжийн тэтгэмжийн тодорхойлолтыг хангахгүй олон ажил гүйлгээ нь үйлчилгээ үзүүлэлтийг агуулдаг гэдгийг УСНББОУСЗ нь СТ 63-д дурдсан, Үлгэрчилсэн жишээнд бас тэмдэглэсэн.
- ДҮ27. Нийгмийн халамжийн тэтгэмжийг мөнгөн шилжүүлэг гэж тодорхойлох нь нийгмийн халамжийн тэтгэмж ба нийтлэг үзүүлж болох үйлчилгээний хоорондох хил заагийн талаархи ихэнх будлиан, төөрөгдлийг арилгана гэж УСНББОУСЗ тэмдэглэсэн.
- ДҮ28. Мөн тэдгээрийн ажил гүйлгээг авч үзээд УСНББОУСЗ нь мөнгөн шилжүүлэг ба үйлчилгээ үзүүлэлт хоорондоо онолын ялгаатай гэж дүгнэсэн. Үйлчилгээ үзүүлэлт нь арилжааны ажил гүйлгээг агуулдаг (жишээлбэл; үйлчилгээ үзүүлэхийн тулд ажилтныг ажиллуулахад зардал гаргадаг, эсвэл бусад байгууллагаас бараа, үйлчилгээг худалдан авахад өртөг зардал гаргадаг). Харин мөнгөн шилжүүлэг нь ямар нэг нэмэлт ажил гүйлгээг агуулдаггүй.
- ДҮ29. Эдгээр шалтгааны улмаас УСНББОУСЗ нь хувь хүмүүс, айл өрхөд олгож буй мөнгөн шилжүүлгийн эдийн засгийн мөн чанар нь хувь хүмүүс, айл өрхөд үзүүлж байгаа үйлчилгээний эдийн засгийн мөн чанараас ялгаатай гэж дүгнэсэн. Иймээс УСНББОУСЗ нь нийгмийн халамжийн талаархи энэхүү Стандартын цар хүрээг мөнгөн шилжүүлгээр хязгаарлах хэрэгтэй гэдгийг хүлээн зөвшөөрсөн.

УСНББОУС 42-НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТЭТГЭМЖ

- ДҮ30. Энэ шийдвэрийн дараа, УСНББОУСЗ нь мөнгөн шилжүүлгийн мөн чанарыг харгалзан үзсэн. Мөнгөн шилжүүлгийн хэлбэр нь чухал биш, түүнд урьдчилан төлсөн дебит карт гэх мэт мөнгөтэй адилтгах зүйлс хамаарч болно гэдгийг УСНББОУСЗ зөвшөөрсөн. Мөнгөтэй адилтгах зүйлс хэлбэртэй байгаа ба энэ утгаараа мөнгөн шилжүүлэг нь тухайн мөнгөний ашиглан зарцуулалтанд хязгаарлалт тогтоодоггүй буюу багахан хязгаарлалттай байна гэдгийг УСНББОУСЗ мөн хүлээн зөвшөөрсөн. Урьдчилан төлсөн дебит карт ашигладаг зарим улс орнууд нь тухайн картны хувьд зарим хязгаарлалт тогтоодог, тухайлбал; ийм картаар согтууруулах ундаа болон тамхи худалдан авах гүйлгээ хийхийг хориглодог гэдгийг УСНББОУСЗ онцлон тэмдэглэсэн. Энэ төрлийн зарим хязгаарлалт нь мөнгийг хэрхэн ашиглан зарцуулахыг засгийн газраас зааварчлан чиглүүлэхтэй адилгүй юм гэдгийг УСНББОУСЗ хүлээн зөвшөөрсөн. Иймээс ашиглан зарцуулалтын хувьд зарим хязгаарлалт бүхий урьдчилан төлсөн дебит карт олголт нь нийгмийн халамжийн тэтгэмжийн тодорхойлолтын зорилгын хувьд мөнгөн шилжүүлэг мөн гэж УСНББОУСЗ үзсэн.
- ДҮ31. СТ 63-д хариулт ирүүлсэн зарим хүмүүс нь нийгмийн эрсдэл ба бусад эрсдлийг ялган зааглах учир шалтгааныг ойлгоогүй байсан. Хариулт ирүүлсэн тэдгээр хүмүүс нь нийгмийн халамжийн тэтгэмжийн тодорхойлолтон дахь нийгмийн эрсдэл гэсэн үг хэллэгийг хасаж, гамшгийг бууруулах гэх мэт бусад тэтгэмжийг тусган оруулахын тулд энэ Стандартын цар хүрээг өргөжүүлэхийг санал болгосон.
- ДҮ32. ЗББ, *Нийгмийн Халамжийн Тэтгэмжийн Хүлээн Зөвшөөрөлт ба Хэмжилт* болон СТ 63-ын аль алинд хариулт ирүүлсэн хүмүүс нь ЗГСС-тай нийцэн уялдсан байдлыг хадгалж, нийгмийн эрсдэл үг хэллэгийг ерөнхийдөө дэмжиж байсан гэдгийг УСНББОУСЗ тэмдэглэсэн. Нийгмийн эрсдэлд засгийн газрын үзүүлэх хариу нь бусад эрсдэлд түүний үзүүлэх хариу үйлдлээс ямагт өөр байдаг гэсэн байр суурийг УСНББОУСЗ мөн хэвээр хадгалж үлдсэн (дээрх ДҮ21(б) параграфыг үзнэ үү).
- ДҮ33. Эдгээр шалтгааны улмаас УСНББОУСЗ нь нийгмийн халамжийн тэтгэмжийн тодорхойлолтон дахь нийгмийн эрсдэл гэсэн үг хэллэгийг хэвээр үлдээхээр шийдвэрлэсэн.

Нийгмийн халамжийн тэтгэмжийн тайлагналын хандлагууд

- ДҮ34. УСНББОУСЗ нь нийгмийн халамжийн тэтгэмжийн тайлагналын гурван хандлагыг ЗББ, *Нийгмийн Халамжийн Тэтгэмжийн Хүлээн Зөвшөөрөлт ба Хэмжилт*-д авч хэлэлцсэн. Эдгээр нь үүрэг хүлээлгэх үйл явдлын хандлага (одоо үүнийг ерөнхий хандлага гэж нэрлэдэг болсон), нийгмийн гэрээний хандлага, даатгалын хандлага юм.
- ДҮ35. Нийгмийн гэрээний хандлага нь засгийн газар тухайн нийгмийн халамжийн тэтгэмжийг олгох хагас гэрээний шинжтэй үүрэгтэй гэж үздэг бөгөөд гүйцэтгэлийн гэрээний нягтлан бодох бүртгэлийг баримтална.
- ДҮ36. ЗББ-ийг боловсруулах үедээ УСНББОУСЗ ийм нийгмийн гэрээний хандлага нь *Онолын Үзэл Баримтлал*-тай нийцэхгүй гэсэн анхдагч саналтай болсон. ЗББ-г хариулт ирүүлсэн хүмүүс нь энэхүү анхдагч саналыг дэмжсэн. Нийгмийн гэрээний хандлага нь хүлээн зөвшөөрөөгүй өр төлбөрийн тодорхойлолтыг хангах тийм зүйлсийг бий болгох үр дүнтэй гэж тэдгээр хариулт ирүүлсэн хүмүүс үзэж байсан. Иймээс нийгмийн гэрээний хандлага нь тайлагналын болон шийдвэр гаргалтын зорилгын хувьд ач холбогдолтой мэдээллээр хангахгүй гэж тэдгээр хариулт ирүүлсэн хүмүүс дүгнэсэн.
- ДҮ37. Энэхүү анхдагч санал дэмжигдсэн гэдгийг УСНББОУСЗ нь тэмдэглээд уг нийгмийн гэрээний хандлагыг цаашид үргэлжлүүлэн боловсруулахгүй байхыг зөвшөөрсөн.
- ДҮ38. Нийгмийн халамжийн тэтгэмжтэй холбоотойгоор үүсэх эдийн засгийн янз бүрийн нөхцөл байдлуудыг тусгахын тулд (бүх эсвэл зарим нийгмийн даатгалын шимтгэлийн хөтөлбөрийн хувьд) ерөнхий хандлага ба даатгалын хандлагыг хослуулах шаардлагатай байж болох юм гэсэн анхдагч саналыг УСНББОУСЗ нь ЗББ-ийг боловсруулах үедээ илэрхийлсэн.

УСНББОУС 42-НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТЭТГЭМЖ

ДҮ39. ЗББ-т хариулт ирүүлсэн хүмүүс нь энэхүү анхдагч саналыг дэмжсэн. Иймээс УСНББОУС3 нь ерөнхий хандлага ба даатгалын хандлагын аль алиныг УСНББОУС 42-т боловсруулан оруулахыг зөвшөөрсөн.

Арилжааны бус зардлын талаархи төсөл

ДҮ40. ДҮ14-д дурдсанчлан, УСНББОУС3 нь нийгмийн халамжийн тэтгэмжийн илүү нарийвчилсан тодорхойлолтыг батлан гаргасан ба энэ нь нийгмийн халамжийн тэтгэмжийн төсөл ба арилжааны бус зардлын төслийн аль алины хувьд төслийн удирдлагын хэрэгцээ шаардлагыг хамгийн сайнаар ханган биелүүлнэ гэж үзсэн.

ДҮ41. 2017 оны 8-р сард УСНББОУС3 нь ЗББ, *Орлого ба Арилжааны бус Зардлын Тайлагнал*-ыг гаргасан. Энэхүү ЗББ-т УСНББОУС3 нь зарим төрлийн арилжааны бус зардлын ажил гүйлгээний хүлээн зөвшөөрөлт ба хэмжилтийн хувьд гүйцэтгэлийн үүргийн хандлага тохиромжтой гэсэн анхдагч саналыг илэрхийлсэн. Иймээс УСНББОУС3 нь нийгмийн халамжийн тэтгэмжийн хувьд уг хандлагыг мөрдөж болох эсэхийг харгалзан үзсэн.

ДҮ42. Нийгмийн эрсдэл үүссэн тухайлбал, хувь хүн нь ажилгүй болсон эсвэл тэтгэврийн насанд хүрсэн тохиолдолд нийгмийн халамжийн тэтгэмж олгодог гэдгийг УСНББОУС3 дурдсан. Нийгмийн эрсдэл нь тухайн хувь хүний үүргийн гүйцэтгэлд хамааралгүй, иймээс нийгмийн халамжийн тэтгэмжийн хүлээн зөвшөөрөлт ба хэмжилтэнд гүйцэтгэлийн үүргийн хандлага тохиромжгүй гэж УСНББОУС3 дүгнэсэн. Үүнтэй адилтгах шалтгаанаар УСНББОУС3 нь нийтлэг үзүүлж болох үйлчилгээ болон хамтын үйлчилгээнд хамаарах арилжааны бус зардлын хувьд гүйцэтгэлийн үүргийн хандлага хэрэглэхийг санал болгоогүй.

Ерөнхий хандлага (6-25-р параграф)

Хүлээн зөвшөөрөлт

ДҮ43. ЗББ, *Нийгмийн Халамжийн Тэтгэмжийн Хүлээн Зөвшөөрөлт ба Хэмжилт*-ийг боловсруулах үедээ УСНББОУС3 нь санхүүгийн тайланд нийгмийн халамжийн тэтгэмжийн өглөг хүлээн зөвшөөрөхөд хүргэж болох таван өөр цэгийг тодорхойлсон. Үүнд:

- (а) Оролцооны гол үйл явдлууд гарч тохиолдсон;
- (б) Босго шалгуур хангагдсан;
- (в) Дараагийн тэтгэмжийг авах зохих шалгуур хангагдсан;
- (г) Нэхэмжлэхийг зөвшөөрөн баталсан; ба
- (д) Нэхэмжлэх нь хуулийн дагуу хүчин төгөлдөр биелэгдэхээр болсон.

ДҮ44. Үүрэг хүлээлгэх эдгээр боломжит үйл явдлуудын хувьд хариулт ирүүлэгч хүмүүсийн саналыг энэхүү ЗББ-ээр авахыг эрмэлзсэн. Түүнчлэн, нийгмийн халамжийн тэтгэмжийн шинж төрөл эсвэл нийгмийн халамжийн тэтгэмжийг үүсгэх эрх зүйн хүрээнээс хамааран тухайн үүрэг хүлээлгэх үйл явдал нь өөр өөр цэгт үүсэж болно гэдгийг ирээдүйн УСНББОУС-аар авч үзэх хэрэгтэй эсэх талаар саналаа өгөхийг тэдгээр хариулт ирүүлэгч хүмүүсээс ЗББ-ээр бас хүссэн.

ДҮ45. Нийгмийн халамжийн тэтгэмжийн шинж төрөл эсвэл нийгмийн халамжийн тэтгэмжийг үүсгэх эрх зүйн хүрээнээс хамааран тухайн үүрэг хүлээлгэх үйл явдал нь өөр өөр цэгт үүсэж болно гэсэн санааг ихээхэн дэмжсэн гэдгийг УСНББОУС3 нь уг ЗББ-т ирүүлсэн хариултуудыг нягталж үзээд цохон тэмдэглэсэн. Үүрэг хүлээлгэх аль үйл явдлыг СТ 63-т тусган оруулах эсэхийг тодорхойлохдоо энэ санааг харгалзах хэрэгтэй гэдгийг УСНББОУС3 хүлээн зөвшөөрсөн.

ДҮ46. Гэвч үүрэг хүлээлгэх үйл явдал гарч тохиолдож болох өөр өөр цэгүүдийн мужийн хувьд санал нэгтэй зөвшилцөлд хүрээгүй гэдгийг УСНББОУС3 бас тэмдэглэсэн. Иймээс УСНББОУС3 нь *Онолын Үзэл Баримтлал*-ыг лавлагаа болгосноор үүрэг хүлээлгэх янз бүрийн үйл явдлуудыг шинжлэхэд анхаарлаа хандуулсан бөгөөд тэдгээр нь үүрэг хүлээлгэх тодорхой нэг үйл явдлын

УСНББОУС 42-НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТЭТГЭМЖ

талаархи нотолгоогоор хангасан буюу шийдэл шаардах өөр бусад асуудлуудыг үүсгэсэн тохиолдолд хариулт ирүүлэгч хүмүүсийн саналыг тэмдэглэж авсан.

- ДҮ47. Хариултуудыг зөвхөн нягталж шалгасны дараа л ЗГСС-тай нийгмийн халамжийн тэтгэмжийн хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт уялдаж буй эсэхийг харгалзан үзэж болно гэж УСНББОУСЗ нь ЗББ-ийг боловсруулах үедээ анх мэдэгдэж байсан. Гэвч дараа нь, УСНББОУСЗ ерөнхий хандлагын хувьд хүлээн зөвшөөрөлтийн цэгүүдийн мужтай байх нь тохиромжтой гэж мэдэгдсэн.
- ДҮ48. Хэрэв ийм мужтай байвал нийгмийн халамжийн тэтгэмжийн хүлээн зөвшөөрөлт ба хэмжилтийг ерөнхий хандлагын дагуу ЗГСС-тай уялдуулахаас шууд бусаар татгалзсан хэрэг болох юм. Яагаад гэвэл, ЗГСС-ийн дагуу нийгмийн халамжийн тэтгэмжийн төлбөрийг төлөх болсон зөвхөн тэр үед (өөрөөр хэлбэл, нэхэмжлэл нь хуулийн дагуу хүчин төгөлдөр биелэгдэх, үүрэг хүлээлгэх үйл явдал байх зөвхөн тийм тохиолдолд) зардлыг бүртгэдэг.
- ДҮ49. Мөн *Онолын Үзэл Баримтлал*-тай нийцсэн байдал нь ЗГСС-ийн арга хандлагатай нийцэхээс илүү чухал ач холбогдолтой гэж УСНББОУСЗ дүгнэсэн. Иймээс УСНББОУСЗ-ийн хэлэлцүүлгээс бий болсон аливаа уялдаа нийцүүлэлт нь санамсаргүй тохиолдлын шинжтэй байж болно.

Тасралтгүй ханган биелүүлэх зохих шалгуурын (үүн дотроо, дахин хүчин төгөлдөр болголтын) шаардлага нь хүлээн зөвшөөрөлтөнд нөлөөлөх

- ДҮ50. Наад зах нь, зарим нийгмийн халамжийн тэтгэмжийн хувьд, тасралтгүй ханган биелүүлэх зохих шалгуурын (үүн дотроо, дахин хүчин төгөлдөр болголтын) шаардлага нь хүлээн зөвшөөрөлтөнд, түүнчлэн хэмжилтэнд нөлөөлнө гэдгийг УСНББОУСЗ хүлээн зөвшөөрсөн. Нийгмийн халамжийн тэтгэмжийг “нэг удаа” эсвэл богино хугацаанд олгох санаа зорилготой үед ийм тохиолдол үүсэж болно. Иймээс УСНББОУСЗ нь тасралтгүй ханган биелүүлэх зохих шалгуурын шаардлагыг харгалзсанаар өр төлбөрийг хэзээ хүлээн зөвшөөрвөл зохистой эсэхийг харгалзан үзсэн.
- ДҮ51. Тасралтгүй ханган биелүүлэх зохих шалгуурын шаардлагыг харгалзсан ба 2015 оны ЗББ-т тодорхойлсон, үүрэг хүлээлгэх боломжит эхний үйл явдал нь дараагийн тэтгэмжийг хүлээн авах уг зохих шалгуурын ханган биелүүлэлт юм. ЗББ-т хариулт ирүүлсэн хүмүүс нь энэхүү үүрэг хүлээлгэх үйл явдлыг тусган оруулахад мэдэгдэхүйц дэмжлэг үзүүлсэн. Зарим нийгмийн халамжийн тэтгэмжийн хувьд боломжит тэтгэмж авагч нь тухайн зохих шалгуурыг хангаснаар уг байгууллагад хуулиар үүрэг хүлээлгэхэд хангалттай байдаг гэдгийг тэдгээр хариулт ирүүлсэн хүмүүс цохон тэмдэглэсэн. Ийм биш байлаа ч гэсэн энэхүү боломжит үүрэг хүлээлгэх үйл явдал нь хуулиар хүлээгээгүй боловч заавал биелүүлэх үүрэг үүсэхэд хүргэнэ гэж тэдгээр хариулт ирүүлсэн хүмүүс үзэж байв. УСНББОУСЗ нь эдгээр санал бодлыг хүлээн зөвшөөрсөн.
- ДҮ52. Хариулт ирүүлсэн цөөн хүмүүс нь энэхүү боломжит үүрэг хүлээлгэх үйл явдлыг дэмжээгүй бөгөөд нэхэмжлэхийг зөвшөөрөн батлагдах хүртэл байгууллага нь төлбөр төлөхөөс өөрийн хүслээр зайлсхийх бүрэн боломжтой гэсэн санааг тэд илэрхийлсэн. Ямар ч засгийн газар нь өөрийн залгамжлагчид үүрэг хүлээлгэж чадахгүй бөгөөд эрх барьж буй засгийн газрын хүсэл санаачлагаар аливаа нийгмийн халамжийн тэтгэмжийн үүргийг өөрчилж болно гэж тэдгээр хүмүүс үзэж байв.
- ДҮ53. УСНББОУСЗ нь энэхүү байр суурийг дэмжээгүй. Онцгой бүрэн эрхийн асуудлыг авч үзсэн *Онолын Үзэл Баримтлал*-ын 5.22-р параграфыг УСНББОУСЗ дурдсан:

“Онцгой бүрэн эрх нь энэхүү Үзэл баримтлал дахь өр төлбөрийн тодорхойлолтыг тухайн үүрэг хангахгүй гэж дүгнэх үндэслэл болохгүй. Үүрэг нь цаашид заавал биелүүлэх шинжгүй ба өр төлбөрийн тодорхойлолтыг хангахгүй болсон эсэхийг харгалзан үзэхийн тулд тайлант үеийн эцэс бүрд уг хуулийн төлөв байдлыг үнэлэх хэрэгтэй.”

УСНББОУС 42-НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТЭТГЭМЖ

- ДҮ54. Нийгмийн халамжийн дараагийн тэтгэмжийг авах зохих шалгуурыг биелүүлж буй тэтгэмж авагч нь өр төлбөрийн тодорхойлолтыг хангах одоогийн үүрэг үүсэхэд хүргэнэ гэж УСНББОУСЗ дүгнэсэн. Иймээс ‘нийгмийн халамжийн дараагийн тэтгэмжийг авах зохих шалгуурын биелүүлэлт’-ийг СТ 63-т үүрэг хүлээлгэх үйл явдал гэж тусган оруулахыг УСНББОУСЗ зөвшөөрсөн.
- ДҮ55. Нэхэмжлэхийг зөвшөөрөн батлалт ба нэхэмжлэхийн хуулийн дагуу хүчин төгөлдөр биелэгдэх байдал нь үүрэг хүлээлгэх үйл явдал эсэхийг УСНББОУСЗ дараа нь авч үзсэн. Хариулт ирүүлсэн хүмүүс нь эдгээрийг үүрэг хүлээлгэх үйл явдал байдлаар ашиглахыг ерөнхийдөө дэмжээгүй гэдгийг УСНББОУСЗ цохон тэмдэглэсэн. Ялангуяа, нэхэмжлэх нь хуулийн дагуу хүчин төгөлдөр биелэгдэх, үүрэг хүлээлгэх үйл явдал гэж үзэхийг тэдгээр хариулт ирүүлсэн дийлэнх олонхи хүмүүс эсэргүүцсэн бөгөөд ингэснээр хууль ёсны үүрэг оршин байх зөвхөн тийм тохиолдлуудаар өр төлбөрийн хүлээн зөвшөөрөлтийг хязгаарлахад хүргэнэ гэж үзсэн. Хуулиар хүлээгээгүй боловч заавал биелүүлэх үүргээс өр төлбөр үүсэхийг хүлээн зөвшөөрдөг *Онолын Үзэл Баримтлал*-тай энэ нь зөрчилдөнө гэж тэдгээр хүмүүс үзэж байв.
- ДҮ56. Зохих шалгуур хангагдмагц байгууллага нь түүнээс зайлсхийх бодит боломжгүй буюу боломж багатай, тийм одоогийн үүрэг ихэвчлэн үүсдэг гэдгийг тэдгээр хариулт ирүүлсэн хүмүүс мөн дурдсан. Иймээс нэхэмжлэхийг зөвшөөрөн батлах эсвэл нэхэмжлэх нь хуулийн дагуу хүчин төгөлдөр биелэгдэхээр болохоос өмнө өр төлбөр үүсдэг.
- ДҮ57. УСНББОУСЗ нь хариулт ирүүлэгчдийн байр суурьтай санал нэг байсан бөгөөд тасралтгүй ханган биелүүлэх зохих шалгуурын шаардлага бүхий нийгмийн халамжийн тэтгэмжийн хувьд зөвхөн ‘нийгмийн халамжийн дараагийн тэтгэмжийг авах зохих шалгуурын биелүүлэлт’-ийг СТ 63-д тусган оруулахаар шийдвэрлэсэн.
- ДҮ58. Ийм дүгнэлт гаргахдаа, УСНББОУСЗ нь нэхэмжлэхийг зөвшөөрөн батлах эсвэл нэхэмжлэх хуулийн дагуу хүчин төгөлдөр биелэгдэхээр болох хүртэл зохих шалгуур нь хангагдахгүй тийм нийгмийн халамжийн тэтгэмж байж болно гэж мэдэгдсэн. Эдгээр үүрэг хүлээлгэх үйл явдлууд нь ‘нийгмийн халамжийн дараагийн тэтгэмжийг авах зохих шалгуурын биелүүлэлт’ гэсэн үүрэг хүлээлгэх үйл явдлын зохих дэд бүрэлдэхүүн хэсгүүд гэж УСНББОУСЗ үзсэн. Иймээс эдгээр үүрэг хүлээлгэх үйл явдлуудыг тусад нь авч үзэх шаардлагагүй юм.
- Тасралтгүй ханган биелүүлэх зохих шалгуурын (үүн дотроо, дахин хүчин төгөлдөр болголтын) шаардлага нь зөвхөн хэмжилтэнд нөлөөлөх
- ДҮ59. ДҮ50-р параграфт дурдсанчлан, хамгийн наад зах нь, зарим нийгмийн халамжийн тэтгэмжийн хувьд, тасралтгүй ханган биелүүлэх зохих шалгуурын (үүн дотроо, дахин хүчин төгөлдөр болголтын) шаардлага нь хүлээн зөвшөөрөлтөнд, түүнчлэн хэмжилтэнд нөлөөлнө гэдгийг УСНББОУСЗ хүлээн зөвшөөрсөн.
- ДҮ60. Өөр зарим нийгмийн халамжийн тэтгэмжийн хувьд, тасралтгүй ханган биелүүлэх зохих шалгуурын (үүн дотроо, дахин хүчин төгөлдөр болголтын) шаардлага нь хүлээн зөвшөөрөлтөнд биш, зөвхөн хэмжилтэнд нөлөөлөх эсэхийг УСНББОУСЗ нь СТ 63-ыг боловсруулах үедээ харгалзан үзсэн.
- ДҮ61. Өр төлбөр оршин байхын тулд тухайн өр төлбөрийг үүсэхэд хүргэх өнгөрсөн үйл явдал байх ёстой гэж УСНББОУСЗ үзсэн. Нийгмийн халамжийн тэтгэмжид хамаарах өнгөрсөн үйл явдлын шинж төрлийг УСНББОУСЗ харгалзан үзсэн бөгөөд ийм тэтгэмжийн хувьд өнгөрсөн үйл явдал нь бүх зохих шалгуурын ханган биелүүлэлт байна, үүнд тухайн тэтгэмж авагч амьд мэнд байх эсэх нь хамаарч болох юм гэж дүгнэсэн. Иймээс үүссэн аливаа өр төлбөр нь зөвхөн дараагийн нийгмийн халамжийн тэтгэмжид хамаарна. Ирээдүйн нийгмийн халамжийн тэтгэмжийн хувьд бүх зохих шалгуур зөвхөн хангагдсан тохиолдолд нэмэлт өр төлбөр үүсдэг.
- ДҮ62. Ийм дүгнэлтэнд хүрэхийн тулд УСНББОУСЗ нь дэмжих олон үндэслэлүүдийг мөн харгалзан үзсэн:

УСНББОУС 42-НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТЭТГЭМЖ

- (а) Тасралтгүй ханган биелүүлэх зохих шалгуурын (үүн дотроо, дахин хүчин төгөлдөр болголтын) шаардлага нь хүлээн зөвшөөрөлтөнд биш, харин хэмжилтэнд зөвхөн нөлөөлнө гэж үзэх нь зарим нийгмийн халамжийн тэтгэмжийн (үндсэндээ өндөр насны тэтгэврийн) хөтөлбөрийн урт хугацааны тэтгэмжийн хувьд байгууллагууд нь зөвхөн одоогийн үүрэг тайлагнахад хүргэж болох юм. Өөр зарим нийгмийн халамжийн тэтгэмжийн хөтөлбөрийн хувьд, байгууллагууд нь харьцангуй богино хугацааны нийгмийн халамжийн тэтгэмж хүлээн зөвшөөрсөн хэдий ч тэдгээр зарим хөтөлбөрийн хувьд тэтгэмж авагч нарт эцэстээ урт хугацаанд тэтгэмж олгож болох юм (жишээлбэл; орлогод үндэслэсэн халамжийн тэтгэмж).
- (б) Амьд мэнд байх нь хууль буюу бодлогоор тогтоон хэрэгжүүлдэг зарим нийгмийн халамжийн тэтгэмжийн арга хэмжээний хувьд зохих, шууд шалгуур үзүүлэлт болдог бөгөөд энэ тохиолдолд нийцлийн хяналт үнэлгээ ба хэрэгжүүлэлтийн идэвхитэй ажиллагааг тогтмол явуулдаг. Улсын секторын олон байгууллагууд нь тухайн тэтгэмж авагч амьд мэнд эсэхийг үечлэн шалган баталгаажуулах идэвхитэй арга хэмжээг авдаг бөгөөд энэхүү зохих шалгуурын нийцлийг байнга хянан үнэлж, хүчин төгөлдөр хэрэгжүүлдэг. Тухайлбал; тэтгэмж авагч амьд мэнд гэсэн жил тутмын баталгаажуулалтыг шаарддаг байж болох юм. Мөн эмнэлэг, оршуулгын үйлчилгээний байгууллага гэх мэт бусад этгээд нь нас баралтын талаар илтгэн тайлагнаж байх шаардлага тогтоож болно. Түүнчлэн, улсын секторын олон байгууллагууд нь нас барсан тэтгэмж авагчид буруу төлсөн нийгмийн халамжийн тэтгэмжийг буцаан авдаг буюу тэтгэмж авагчийн нас баралтыг зориуд, хуурамчаар тайлагнаагүй тохиолдолд эрүүгийн хэрэг үүсгэдэг. Зарим нийгмийн халамжийн тэтгэмжийн арга хэмжээний хувьд амьд мэнд байх нь шууд бус, зохих шалгуур үзүүлэлт болдог. Нас барсан тэтгэмж авагчид нийгмийн халамжийн тэтгэмжийг буруу төлсөн тохиолдолд буцаан авах адилтгах арга хэмжээг авч хэрэгжүүлдэг.
- (в) Бүх зохих шаардлагуудыг биелүүлэх нь тэрхүү биелэгдсэн зохих шаардлагуудтай холбоотой бөгөөд тасралтгүй ханган биелүүлэх зохих шалгуур бүхий нийгмийн халамжийн тэтгэмжийн хөтөлбөртэй нийцсэн тийм нийгмийн халамжийн тэтгэмж олгох үүрэг үүсгэнэ. Бие даасан нийгмийн халамжийн тэтгэмжийн хөтөлбөрийн хувьд зохих шаардлагууд болон холбогдох нийгмийн халамжийн тэтгэмжүүдийг ихэвчлэн тодорхой тогтоосон байдаг. Тухайлбал; өмнөх сарын эцсийн байдлаар зохих шалгуурыг биелүүлсэн тохиолдолд нийгмийн халамжийн тэтгэмжийг сар бүр төлдөг байж болох юм. Тасралтгүй ханган биелүүлэх зохих (амьд мэнд байхаас бусад) шалгууртай хөтөлбөр түүнчлэн амьд мэнд байх нь тасралтгүй ханган биелүүлэх цорын ганц зохих шалгуур бүхий хөтөлбөрийн аль алины хувьд ийм мэдэгдэл нь үнэн байна.
- (г) Тасралтгүй ханган биелүүлэх зохих шалгуурын (үүн дотроо, дахин хүчин төгөлдөр болголтын) шаардлага нь нийтлэг үзүүлж болох үйлчилгээ болон хамтын үйлчилгээний хувьд ЗББ, *Орлого ба Арилжааны бус Зардлын Тайлагнал*-д УСНББОУСЗ-ийн санал болгосон хандлагатай нийцнэ.

ДҮ63. УСНББОУСЗ нь дараах байдлаар заасан, *Онолын Үзэл Баримтлал*-ын 5.21-р параграфыг мөн харгалзан үзсэн (тод хар болгон нэмж тэмдэглэсэн):

“**Арилжааны ажил гүйлгээтэй** холбоотой зарим үүрэг нь тухайн тайлангийн өдрөөр гуравдагч тал хууль ёсоор шууд хэрэгжүүлэх боломжгүй байх боловч тэрхүү гуравдагч тал нь барагдуулалтаас өмнө цаашид ямар нэг нөхцлийг ханган биелүүлэхгүй буюу аливаа нэмэлт үйлдэл гүйцэтгэхгүйгээр цаг хугацаа урсан өнгөрөх явцад хууль ёсны хүчин төгөлдөр болдог. Цаг хугацааны урсан өнгөрөлтөөс хамааран нөхцөлт бусаар хууль ёсны хүчин төгөлдөр болох нэхэмжлэл нь өр төлбөрийн тодорхойлолтын хувьд хүчин төгөлдөр үүрэг юм.”

ДҮ64. Хэдийгээр нийгмийн халамжийн тэтгэмж нь арилжааны ажил гүйлгээ биш боловч зохих босго шалгуур хангагдсан тохиолдолд тэтгэвэрт гарсны дараах тэтгэмж гэх мэт нийгмийн халамжийн тэтгэмжийн хөтөлбөрийн хувьд өр төлбөр хүлээн зөвшөөрөх хэрэгтэй эсэхийг УСНББОУСЗ нь харгалзан үзсэн. Энэ нь тухайн тэтгэмж авагч цаашид ямар нэг нөхцлийг ханган биелүүлэхгүй

УСНББОУС 42-НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТЭТГЭМЖ

буюу аливаа нэмэлт үйлдэл гүйцэтгэхгүйгээр цаг хугацаа урсан өнгөрөх явцад үүсэх хуулийн үүргийн үр дүн хэлбэртэй болох юм.

- ДҮ65. Ингэх нь зохистой биш гэж УСНББОУСЗ дүгнэсэн. Дурдан заасанчлан, *Онолын Үзэл Баримтлал*-ын 5.21-р параграф нь арилжааны ажил гүйлгээний хүрэн дэх зөвхөн хуулийн үүрэгт хамааралтай. Тодруулбал, арилжааны ажил гүйлгээнд оролцогч гаднын тал нь тухайн арилжааны ажил гүйлгээний бүх нөхцлүүдийг ханган биелүүлсэн бөгөөд үүрэг нь нөхцөлт бусаар хууль ёсны хүчин төгөлдөр болох тохиолдолд уг параграф мөрдөгдөнө. Харин улсын секторын байгууллага нь тухайн тайлант үеийн эцэс хүртэл өөрийн нөхцлүүдийг биелүүлэхгүй тул энэхүү параграф хамаарахгүй.
- ДҮ66. Иймээс үүрэг хүлээлгэх, тохиромжтой цорын ганц үйл явдал бол нийгмийн халамжийн тэтгэмжийн дараагийн төлбөрийн хувьд бүх зохих шалгуурын ханган биелүүлэлт гэж УСНББОУСЗ үзсэн. Даатгалын хандлагатай хосолсон энэхүү хандлага нь нийгмийн халамжийн тэтгэмжийн шинж төрөл, түүнчлэн нийгмийн халамжийн тэтгэмж үүсэх эрх зүйн хүрээг харгалзан тусгана гэж УСНББОУСЗ дүгнэсэн.
- ДҮ67. Дараагийн төлбөрийн бүх зохих шалгуур (үүн дотроо, амьд мэнд байх) хангагдахаас өмнө өр төлбөрийг хүлээн зөвшөөрөхөд практик хүндрэлтэй эсэхийг УСНББОУСЗ мөн харгалзан үзсэн. ‘Зохих босго шалгуур хангагдсан’ гэх мэт хандлагууд нь хуулиар хүлээгээгүй боловч заавал биелүүлэх үүрэг үүсэхэд хүргэнэ гэж үздэг болохыг УСНББОУСЗ тэмдэглэсэн. Ийм тохиолдолд байгууллага нь үүргээ барагдуулахаас өөр бодитой сонголтгүй буюу сонголт багатай болоход хүргэх хүчин төгөлдөр хүлээлтэй байдаг. Босго шалгуур оруулах суурь үндэслэл нь цаашид ханган биелүүлэх зохих шалгуур (амьд мэнд байхаас өөр бусад) байхгүй гэсэн хүчин төгөлдөр хүлээлт үүсэх явдал юм. Бүх тохиолдолд энэхүү нөхцөл биелэгдэнэ гэдэгт УСНББОУСЗ итгэлгүй байсан бөгөөд дараах нөхцлүүд үүсэж болно гэж үзсэн:
- (а) Цаашид ханган биелүүлэх зохих шалгуур байхгүй ч гэсэн байгууллага нь үүргээ барагдуулахаас өөр бодитой сонголтгүй буюу сонголт багатай болоход хүргэх тийм хүчин төгөлдөр хүлээлт үүсээгүй; эсвэл
 - (б) Цаашид ханган биелүүлэх зохих шалгуур байлаа ч гэсэн байгууллага нь үүргээ барагдуулахаас өөр бодитой сонголтгүй буюу сонголт багатай болоход хүргэх тийм хүчин төгөлдөр хүлээлт үүссэн.
- ДҮ68. Бүх зохих шалгуурыг ханган биелүүлэхээс өмнө үүссэн, ‘оролцооны гол үйл явдлууд гарч тохиолдох’ гэх мэт бусад үүрэг хүлээлгэх үйл явдлуудын хувьд мөн адилтгах хүндрэл үүснэ гэж УСНББОУСЗ үзсэн.
- ДҮ69. Эдгээр үүрэг хүлээлгэх үйл явдлуудын дагуу байгууллага нь үүргээ барагдуулахаас өөр бодитой сонголтгүй буюу сонголт багатай болоход хүргэх тийм хүчин төгөлдөр хүлээлт үүссэн гэдгийг тодорхойлохдоо, зөвхөн тохиолдол нэг бүрээр тодорхойлж болох эсэхийг УСНББОУСЗ нь харгалзан үзсэн. Энэ нь СТ 63-т үндэслэсэн аливаа УСНББОУС-ын тууштай бус мөрдөлтөнд хүргэнэ гэж УСНББОУСЗ дүгнэсэн бөгөөд уг ‘зохих босго шалгуурын үүрэг хүлээлгэх үйл явдал’-ыг СТ 63-т тусган оруулахгүй байх цаашдын шалтгаан болно гэж үзсэн.
- ДҮ70. УСНББОУСЗ нь ‘нийгмийн халамжийн тэтгэмжийн дараагийн төлбөрийн зохих шалгуур хангагдсан’ гэсэн хүлээн зөвшөөрөлтийн ганцхан цэгийг СТ 63-т тусган оруулах хэрэгтэй ба амьд мэнд байх эсэхийг нягтлан бодох бүртгэлийн арга хандлагад тусгавал зохино гэж дүгнэсэн. Амьд мэнд байх эсэх нь хүлээн зөвшөөрөлтөнд нөлөөлдөг зохих шалгуур үзүүлэлт (шууд эсвэл дам илэрхийлсэн эсэхээс үл хамааран) байж болох юм .

Саналын Төсөл 63-ыг боловсруулах хандлага

- ДҮ71. ‘Нийгмийн халамжийн тэтгэмжийн дараагийн төлбөрийн зохих шалгуур хангагдсан’ гэсэн хүлээн зөвшөөрөлтийн ганцхан цэгийг СТ 63-т тусган оруулах хэрэгтэй гэдэг дүгнэлтэнд хүрэх үедээ, УСНББОУСЗ нь хүлээн зөвшөөрөлтийн бусад цэгүүдийг СТ 63-т бас оруулвал зохино гэсэн байр суурь баримтлаж байсан зарим гишүүдтэй зөвшилцөлд хүрээгүй.

УСНББОУС 42-НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТЭТГЭМЖ

- ДҮ72. Тэдгээр гишүүд нь нийгмийн халамжийн бүх тэтгэмжийн хувьд мөрдөх хүлээн зөвшөөрөлтийн ганцхан цэгийг тогтоох нь тохиромжгүй гэсэн саналтай байв. Яагаад гэвэл, ийм хандлага нь:
- (а) Янз бүрийн нийгмийн халамжийн тэтгэмжүүдийн эдийн засгийн мөн чанарыг тусган харуулахгүй;
 - (б) *Онолын Үзэл Баримтлал*-тай нийцэхгүй; ба
 - (в) “Амьд мэнд байх”-ыг хэмжилтийн шалгуур биш, харин хүлээн зөвшөөрөлтийн шалгуур гэж үздэг.
- ДҮ73. Иймээс тэдгээр гишүүд нь нийгмийн халамжийн тэтгэмжийн хөтөлбөр нэг бүрийн эдийн засгийн мөн чанараас тухайн үүрэг хүлээлгэх үйл явдал хамаардаг байвал зохино гэсэн Хувилбар Байр Суурийг санал болгосон. Тэдгээр гишүүдийн Хувилбар Байр Суурийн талаархи онолын үндэслэлийг доорх ДҮ74-ДҮ93-р параграфт дурдсан.

Хувилбар Байр Суурийн Онолын Үндэслэл

- ДҮ74. Тэдгээр гишүүдийн үзэл бодлоор бол, зарим нийгмийн халамжийн тэтгэмжийн хувьд дараагийн тэтгэмжийн төлбөрийг авах зохих шалгуур хангагдсан үед өр төлбөрийг хүлээн зөвшөөрөх нь тохиромжтой байдаг. Өөр зарим нийгмийн халамжийн тэтгэмжийн хувьд өр төлбөрийг арай эрт хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Жишээлбэл; хувь хүн нь тэтгэврийн насанд хүрсэн үед үлдсэн бүх тэтгэмжийн хувьд өр төлбөрийг хүлээн зөвшөөрч болно, эсвэл хувь хүн нь шимтгэл төлөхийн хэрээр өр төлбөрийг цаг хугацааны явцад хуримтлуулан бүртгэж болох юм. Тайлан бэлтгэгч нар нь өөрсдийн нийгмийн халамжийн тэтгэмжийн бие даасан хөтөлбөрүүдийн хувьд үүрэг хүлээлгэх аль үйл явдал хамгийн тохиромжтой эсэхийг тэдгээрийн эдийн засгийн мөн чанарт үндэслэн тодорхойлвол зохино.

СТ 63-т заасан, хандлага нь янз бүрийн нийгмийн халамжийн тэтгэмжийн эдийн засгийн мөн чанарыг тусган илэрхийлэхгүй, иймээс санхүүгийн тайлангийн хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагыг хангах мэдээлэл бий болгох үр дүнгүй

- ДҮ75. Зөвлөлдөх Баримт Бичиг, *Нийгмийн Халамжийн Тэтгэмжийн Хүлээн Зөвшөөрөлт ба Хэмжилт*-д хариулт ирүүлсэн, УСНББОУС3-ийн дэмжигчид нь нийгмийн халамжийн тэтгэмжийн шинж төрөл эсвэл нийгмийн халамжийн тэтгэмжийг үүсгэх эрх зүйн хүрээнээс хамааран тухайн үүрэг хүлээлгэх үйл явдал өөр өөр цэгт үүсэж болно гэсэн санааг ихээхэн дэмжсэн гэдгийг уг Хувилбар Байр Суурийг санал болгосон гишүүд онцлон тэмдэглэсэн. Иймээс эдгээр гишүүд нь нийгмийн халамжийн тэтгэмжийн дараагийн төлбөрийг хүлээн авах (гэвч амьд мэнд байх эсэхийг тусган оруулаагүй) зохих шалгуур зөвхөн хангагдсан үед нийгмийн халамжийн тэтгэмжийн хувьд өр төлбөрийг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй гэдгийг зарим тохиолдолд үгүйсгээгүй боловч өөр зарим тохиолдолд үүнийг үгүйсгэн эсэргүүцсэн.
- ДҮ76. Нийгмийн халамжийн тэтгэмжийн хөтөлбөрүүд нь янз бүр байх учраас нийт олонлогийн хувьд бүхэлдээ өөр өөр хүлээлт үүсгэж болно гэж тэд үзэж байсан. Тухайлбал; ирээдүйн тэтгэмж авагчдын зүгээс санхүүжүүлэхээр төлөвлөн зохиомжилсон (өөрөөр хэлбэл, “шаардлагатай хэмжээгээр төлөх” зарчмаар санхүүжүүлдэг), нийгмийн халамжийн тэтгэмжийн хөтөлбөр нь жишээлбэл, өнгөрсөн хугацаанд хувь хүмүүсийн төлсөн шимтгэлд үндэслэн одоогийн болон ирээдүйн боломжит тэтгэмж авагчдад эрх олгох хүлээлтийг тухайн тайлангийн өдрөөр үүсгэж болох юм. Өөр өөр байдлаар төлөвлөн зохиомжилсон нийгмийн халамжийн тэтгэмжийн хөтөлбөр нь адил тэнцүү хүлээлт үүсгэхээргүй байж болно.
- ДҮ77. Эдгээр хүлээлтийн харьцангуй хүчин төгөлдөр байдал нь ялгаатай байж болно гэдгийг тэдгээр гишүүд хүлээн зөвшөөрсөн. Тухайлбал; хүлээлтүүд нь уг хөтөлбөрийн тэтгэмж авагчид болон оролцогчдоод мэдэгдсэн, тэтгэмж хүлээн авах хууль ёсны эрхэд, өмнөх урт хугацааны жишээ тохиолдолд, эсвэл ач холбогдол багатай бусад нөхцөл байдалд үндэслэсэн байж болно. Иймээс байгууллага нь нийгмийн халамжийн тэтгэмжийн хувьд өр төлбөрийг хүлээн зөвшөөрөх үедээ нөөцийн зарлагаас зайлсхийх бодит хувилбар боломжтой эсэхийг тодорхойлохдоо, аливаа тухайн тохиолдол дахь хүлээлтүүдийн шинж төрлийг харгалзах ёстой гэж тэд үзэж байсан.

УСНББОУС 42-НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТЭТГЭМЖ

- ДҮ78. Иймээс эдийн засгийн ялгаатай мөн чанарыг үл харгалзан, нийгмийн халамжийн бүх тэтгэмжүүдийг нэг ижил арга маягаар авч үзэх нь тухайн нийгмийн халамжийн тэтгэмжийг үнэлэхэд шаардлагатай мэдээллээр хэрэглэгчдийг хангахгүй гэж тэдгээр гишүүд дүгнэсэн.
- ДҮ79. Санхүүгийн тайлангийн хэрэглэгчид нь өөрсдийн янз бүрийн шийдвэрийг гаргахад, үүн дотроо тохиромжтой бол нийгмийн халамжийн тэтгэмжүүдийн үе хоорондын нөлөөллийг үнэлэх үед тухайн нийгмийн халамжийн тэтгэмжийн эдийн засгийн мөн чанарын талаархи хамааралтай ба үнэн зөв илэрхийлэх мэдээлэл уг хэрэглэгчдэд шаардлагатай гэж тэдгээр гишүүд үзэж байсан.
- ДҮ80. Жишээлбэл; үе хоорондын сууриар санхүүжүүлэхээр төлөвлөн зохиомжилсон, улсын тэтгэврийн хөтөлбөрийн хувьд одоогийн тэтгэмж авагчид болон оролцогчдын аль алинд тухайн тайлангийн өдрөөр төлөх уг байгууллагын одоогийн үүргийн дүн (амьд мэнд байхыг эрх олгох шалгуур байдлаар оруулаагүй) нь одоогийн ба ирээдүйн оролцогчдоос авах ирээдүйн даатгалын шимтгэлээр санхүүжүүлэх шаардлагатай тэтгэврийн төлбөрийн тэрхүү өдрөөрх хэрэгцээт хэмжээний талаархи ач холбогдолтой мэдээллээр хангадаг.
- ДҮ81. Дараагийн төлбөрөөс цаашир өр төлбөрийг тухайн тайлангийн өдрөөр хүлээн зөвшөөрөхгүй байх нь тухайлбал, улсын тэтгэврийн бодлогын өөрчлөлтийг (жишээ нь; тэтгэвэрт гарах насыг нэмэгдүүлэх) дараагийн тайлант үеийн эцэс дэх өр төлбөрийн дүнд тусган оруулах боломж олгохгүй юм. Энэ нь мөн тухайн байгууллагын холбогдох эрх олголтын мэдэгдлийн хувьд одоогийн тэтгэмж авагчид ба оролцогчдод, түүнчлэн ирээдүйн шимтгэл төлөгчдөд хуурамч мессеж өгөхөд хүргэнэ.
- ДҮ82. Түүнчлэн, дараагийн төлбөрөөс цаашир өр төлбөрийг тухайн тайлангийн өдрөөр хүлээн зөвшөөрөхгүй байх нь уг шимтгэлийн хөтөлбөрийн эдийн засгийн мөн чанарыг тусган илэрхийлэхгүй юм. Шимтгэлийг тухайн нэг оролцогч төлсөн үед түүнийг орлого гэж харуулна, гэвч энэхүү төлбөрөөр эрх үүсэж буй тэтгэмжийн тодорхой хэсгийг яг тэрхүү хугацааны агшинд өглөг гэж харуулдаггүй, харин харьцангуй өмнөх оролцогч болох тэтгэмж авагчид дараа нь төлбөрийг зөвхөн төлөх үед (магадгүй, хэдэн жилийн дараа) үүнийг тусгадаг.
- СТ 63-д заасан, хандлага нь УСНББОУС3-ийн *Онолын Үзэл Баримтлал*-тай нийцээгүй
- ДҮ83. Хувилбар Байр Суурийг санал болгосон гишүүдийн үзэл бодлоор бол, СТ 63 дахь хандлага нь хамааралтай байх, үнэн зөв илэрхийлэх, ойлгомжтой байх, зэрэгцүүлэгдэх боломжтой байх гэсэн чанарын шинжүүдийг хангахгүй юм.
- ДҮ84. Нийгмийн халамжийн тэтгэмжийн эдийн засгийн мөн чанарыг тусгах нь зэрэгцүүлэгдэх боломжтой байх гэсэн чанарын шинжийг ханган биелүүлэхэд зайлшгүй шаардлагатай гэж тэдгээр гишүүд үзсэн. “Зэрэгцүүлэгдэх боломжтой байдал нь хоёр цогц үзэгдлийн хоорондох ижил төсөөтэй болон ялгаатай талуудыг тодорхойлох боломжийг хэрэглэгчдэд олгодог чанарын шинж” гэж *Онолын Үзэл Баримтлал*-д тодорхойлсон. Иймээс эдгээр гишүүд нь ДҮ69-р параграфт тайлбарласан, тууштай бус мөрдөлтийн талаархи тайлбар шалтгааныг хүлээн зөвшөөрөөгүй. Харин эсрэгээр, тэд дараах байдлаар тайлбарласан: хэрэв нийгмийн халамжийн тэтгэмжийн эдийн засгийн мөн чанар нь хөтөлбөр болон улс орон бүрд өөр байвал тэрхүү ялгаатай байдлыг уг нийгмийн халамжийн тэтгэмжийн ‘санхүүгийн тайлан’ дахь тайлагналд тусган оруулах хэрэгтэй. Энэ нь нягтлан бодох бүртгэлийн ялгаатай үр дагавар бүхий эдийн засгийн янз бүрийн үзэгдлийн хувьд нягтлан бодох бүртгэлийн зарчмуудын тууштай мөрдөлт юм.
- ДҮ85. Иймээс зарим нийгмийн халамжийн тэтгэмжийн хувьд, зохих шалгуурыг хангах шаардлагатай дараагийн цэг хүртэл тухайн тэтгэмжийн дүнгээс илүү хэмжээгээр өр төлбөрийг хүлээн зөвшөөрөх нь тохиромжтой гэж тэдгээр гишүүд үзэж байсан. Тодруулга (санхүүгийн тайлангийн дагалдах тэмдэглэл дэх) нь тайлагналыг (санхүүгийн тайлан дахь) орлохгүй гэж УСНББОУС3-ийн *Онолын Үзэл Баримтлал*-ын 8.15-р параграфт заасан гэдгийг тэд дурдсан.
- ДҮ86. УСНББОУС3-ийн *Онолын Үзэл Баримтлал*-д дараах байдлаар заасан гэдгийг тэд онцлон тэмдэглэсэн (тод хар болгон нэмж тэмдэглэсэн):

УСНББОУС 42-НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТЭТГЭМЖ

- 5.14 Өр төлбөр гэдэг нь: Өнгөрсөн үйл явдлын үр дүнд нөөцийг гадагш зарцуулах уг байгууллагын одоогийн үүрэг юм.
- 5.15 Улсын секторын байгууллагууд нь олон тооны үүрэгтэй байдаг. Одоогийн үүрэг нь **хуулиар хүлээсэн заавал биелүүлэх үүрэг** (хуулиар хүлээсэн үүрэг) эсвэл **хуулиар хүлээгээгүй заавал биелүүлэх үүрэг** юм. Хуулиар хүлээгээгүй заавал биелүүлэх үүргийн хувьд байгууллага нь зайлсхийх боломжгүй буюу боломж байлаа гэхэд маш бага байдаг. Заавал биелүүлэх шинжтэй, түүнчлэн нөөцийг гадагш зарцуулахаас зайлсхийх боломжгүй буюу боломж байлаа гэхэд маш бага байхаас бусад тохиолдолд үүрэг нь одоогийн үүрэг болохгүй юм.
- 5.20 ...Зарим төрлийн арилжааны бус ажил гүйлгээний хувьд үүрэг нь хуульд зааснаар хүчин төгөлдөр хэрэгжих эсэхийг тодорхойлохын тулд шүүн тунгаалт хийх шаардлагатай байдаг. Үүрэг нь хуульд заасны дагуу хүчин төгөлдөр хэрэгжинэ гэж тодорхойлсон тохиолдолд тухайн байгууллага нь уг үүргээс зайлсхийх бодит боломжгүй бөгөөд өр төлбөр оршин буй талаар эргэлзээгүй болно.
- 5.25 Үүргийн дагуу өр төлбөр үүсэхэд хүргэх хугацааны агшин нь тухайн үүргийн шинж төрлөөс хамаардаг. Байгууллага нь нөөцийн гадагш зарцуулалтаас зайлсхийх бодит боломжгүй буюу боломж багатай тийм үүрэг гэж бусад талууд зохих ёсоор дүгнэж болох эсэх шүүн тунгаалтанд нөлөөлөх магадлалтай хүчин зүйлсэд дараах зүйлс хамаарна:
- Үүрэг үүсэхэд хүргэж болох өнгөрсөн үйл явдал буюу үйл явдлуудын шинж төрөл...
 - Илт тодорхой болохоос өмнө тухайн үүргийг засварлах буюу өөрчлөх уг байгууллагын чадвар боломж...
 - Тодорхой үүргийг барагдуулах санхүүжилтийн бэлэн боломжит байдал ба одоогийн үүргийн үүсэл хооронд харилцан уялдаа холбоо байж болох юм...
- 5.26 Хэдийгээр улсын секторын байгууллага нь нөөцийг гадагш зарцуулах хуулиар хүлээсэн үүрэггүй боловч ингэж татгалзсаны эдийн засгийн болон улс төрийн үр дагавар нь нөөцийн гадагш зарцуулалтаас тухайн байгууллагыг зайлсхийх бодит боломжгүй буюу боломж багатай болгох тийм нөхцлийг “эдийн засгийн дарамт шахалт”, “улс төрийн шаардлага” буюу бусад нөхцөл байдлаар үүсгэж болох юм. Эдийн засгийн дарамт шахалт, улс төрийн шаардлага буюу бусад нөхцөл байдал нь хуулиар хүлээгээгүй заавал биелүүлэх үүргээс өр төлбөр үүсэхэд хүргэж болно.

ДҮ87. УСНББОУСЗ-ийн *Онолын Үзэл Баримтлал*-д заасанчлан, зарим тохиолдолд өр төлбөр нь дараагийн тэтгэмжийн хувьд зохих шалгуур хангагдахаас өмнө гарч тохиолдсон, оролцооны гол үйл явдлаас үүсэж болно гэж тэд мэдэгдсэн. Тухайлбал; нийгмийн халамжийн зарим шимтгэлийн хөтөлбөр эсвэл хуулиар хүлээсэн заавал биелүүлэх одоогийн үүргийн хувьд ийм тохиолдол үүсэж болно.

“Амьд мэнд байх” гэсэн шалгуур үзүүлэлт нь хүлээн зөвшөөрөлтийн шалгуур биш, харин хэмжилтийн шалгуур

ДҮ88. Төлбөрийн мөчлөг бүрийн өмнө, зохих шалгуурыг хангах тэр цэг дээр амьд мэнд байх нь бүх нийгмийн халамжийн тэтгэмжийн хувьд уг байгууллагын одоогийн үүргийг хүлээн зөвшөөрөхөд нөлөө үзүүлдэг шууд бус зохих шалгуур мөн гэж тэдгээр гишүүд үзэхгүй байсан.

ДҮ89. Тайлангийн өдрөөр зохих шалгуурыг хангаж буй тодорхой нэг хувь хүн нь нийгмийн халамжийн тэтгэмжийн дараагийн төлбөрийг төлөх болсон тэрхүү хугацааны агшинд амьд мэнд байх эсэх нь тодорхойгүй боловч хэмжиж болохуйц тооны, тэтгэмж авагч хувь хүмүүс ирээдүйд амьд мэнд байна гэж үзэх нь ул үндэслэлтэй, иймээс нийгмийн халамжийн тэтгэмжийн уг дараагийн хэсэгчилсэн төлбөрөөс хойш үзүүлэх нийгмийн халамжийн

УСНББОУС 42-НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТЭТГЭМЖ

тэтгэмжийн хувьд тухайн тайлангийн өдөр байгууллага нь заавал биелүүлэх одоогийн үүрэгтэй байна гэж тэд онцлон тэмдэглэсэн.

- ДҮ90. Улсын секторын ажилтнуудад олгодог, УСНББОУС 39-д заасан ажил эрхлэлтийн дараах тэтгэмж болох тэтгэврийн өглөг гэх мэт эдийн засгийн бусад үйл явдалд “амьд мэнд байх” эсэхийг авч үзэх арга хандлагатай харьцуулахад нийгмийн халамжийн тэтгэмжийн хувьд “амьд мэнд байх” эсэхийг өөрөөр авч үзэх тусгай шаардлага бий гэдэгт тэдгээр хүмүүс итгээгүй. Нийгмийн халамжийн тэтгэмжийн өр төлбөрийн хэмжилтэнд хэрэв шаардлагатай бол харилцан лавлагааг, жишээлбэл нас баралтын статистик мэдээг мөн оруулж болно.
- ДҮ91. Амьд мэнд байх эсэхийг хүлээн зөвшөөрөлтийн шалгуур байдлаар оруулах нь бүх нийгмийн халамжийн тэтгэмжийн хувьд зөвхөн дараагийн тэтгэмжийн хэмжээгээр одоогийн үүрэг хүлээн зөвшөөрөхөд хүргэх бөгөөд ингэснээр нийгмийн халамжийн тэтгэмжтэй холбоотой тухайн байгууллагын одоогийн үүргийн хүлээн зөвшөөрөлтийг гажуудуулна гэж тэдгээр гишүүд үзсэн. Жишээлбэл; ихэнх тохиолдолд зөвхөн дараагийн тэтгэмжийн хэмжээгээр өр төлбөрийг хүлээн зөвшөөрөх учраас тэтгэврийн хөтөлбөрийн хувьд гажуудал үүснэ. Ийм хандлага нь тухайн тэтгэмж авагч хүн амын урт наслалтын бодит хүлээлтийг харгалзан тусгадаггүй, иймээс нийгмийн халамжийн тэтгэмжийн хөтөлбөрийн талаархи холбогдох мэдээллээр хангаж чадахгүй юм.
- ДҮ92. Иймээс тэдний үзэл бодлоор бол, амьд мэнд байх нь нийгмийн халамжийн тэтгэмжийн өр төлбөрийн хэмжилтэнд харгалзах шалгуур үзүүлэлт юм. Энэ утгаараа, тэд амьд мэнд байх эсэхийг хэмжилтийн шалгуур үзүүлэлт болгон оруулахын тулд хэмжилтийн талаархи СТ 63-ын материалыг цаашид авч үзэх шаардлагатай байж болно гэдгийг бас тэмдэглэсэн.
- ДҮ93. *Онолын Үзэл Баримтлал* дахь өр төлбөрийн тодорхойлолт нь чанарын шинжүүдийг ханган биелүүлэх ба нийтлэг зорилготой санхүүгийн тайлан илтгэлд тусгасан мэдээллийн хязгаарлалтуудыг харгалзсан тийм арга замаар зүйлсийг хэмжихийг шаарддаг. Тооцооллын угийн тодорхойгүй байдал нь нягтлан бодох бүртгэлийн тооцоололд мөн хамаарна гэдгийг уг Хувилбар Байр Суурийг санал болгосон гишүүд нь хүлээн зөвшөөрсөн; зохих нийгмийн халамжийн тэтгэмжийн ирээдүйн төлбөрүүдийн хувьд тухайн тайлангийн өдрөөр оршин буй өр төлбөрийг хүлээн зөвшөөрөх тохиолдолд энэхүү шаардлага ихэвчлэн ханган биелэгддэг. Ирээдүйн өдөр төлөх магадлалтай бодит гүйцэтгэлийн дүн болон төлбөрийг барагдуулах уг байгууллагын чадварын талаархи тодорхойгүй байдлыг тухайн өр төлбөрийн хэмжилтэнд тусгадаг. Нас барахаас өмнө тухайн тэтгэмжийн насанд хичнээн тэтгэмж авагч хүрэх эсэх талаархи тодорхойгүй байдлыг нас баралтын статистик гэх мэт мэдээг лавлагаа болгосноор харгалзан үздэг.

Оролцогч талуудын СТ 63 дахь санал хэлэлцүүлгийн шалтгаан тайлбар

- ДҮ94. Санал нэгтэй зөвшилцөлд хүрээгүй тул УСНББОУСЗ нь янз бүрийн шалтгаан тайлбарыг харгалзах боломжийг сонирхогч талуудад олгох тийм байдлаар СТ 63-ыг боловсруулахыг зөвшөөрсөн. Наад зах нь, зарим нийгмийн халамжийн тэтгэмжийн хувьд тохиромжтой гэдгийг бүх гишүүд зөвшөөрсөн тул ‘нийгмийн халамжийн тэтгэмжийн дараагийн төлбөрийн зохих шалгуур хангагдсан’ гэсэн хүлээн зөвшөөрөлтийн цэгийг СТ 63-т тусган оруулсан. Хүлээн зөвшөөрөлтийн бусад цэгүүдийг нийгмийн халамжийн тэтгэмжийн хувьд тохиромжтой биш гэж зарим гишүүд үзсэн учраас тэдгээрийг СТ 63-т оруулаагүй. СТ 63-ыг ийм байдлаар боловсруулахыг зөвшөөрснөөр, тэдгээр хүлээн зөвшөөрөлтийн бусад цэгүүдийг тусган оруулахыг дэмжиж буй гишүүд нь өөрсдийн шалтгаан үндэслэлээ Хувилбар Байр Суурьт тусган тайлбарласан гэдгийг УСНББОУСЗ тэмдэглэсэн. Сонирхогч талуудад тэдгээр шалтгаан үндэслэлийг ил болгож, танилцуулсан гэдэг нь олон нийтийн эрх ашгийн зүгээс авч үзвэл чухал ач холбогдолтой гэж УСНББОУСЗ дүгнэсэн.
- ДҮ95. СТ 63-ыг ийм байдлаар боловсруулахыг зөвшөөрснөөр, УСНББОУСЗ нь хэрэглэгчдийн нийгмийн халамжийн тэтгэмжийн талаархи мэдээллийн бүх хэрэгцээг санхүүгийн тайлангаар хангаж чадахгүй гэж өмнө илэрхийлсэн өөрийн байр суурийг баталгаажуулсан. Эдгээр нийгмийн халамжийн тэтгэмжийн хөтөлбөрүүдийн санхүүгийн урт хугацааны тогтвортой

УСНББОУС 42-НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТЭТГЭМЖ

байдлын талаархи нэмэлт мэдээлэл шаардлагатай юм. СБПУ 1-д оруулсан заавар удирдамж нь шаардлагатай мэдээллээр хэрэглэгчдийг хангана гэж УСНББОУСЗ үзсэн. Иймээс байгууллагууд нь өөрийн санхүүгийн урт хугацааны тогтвортой байдлын талаархи мэдээллээр хангах тийм нийтлэг зорилготой санхүүгийн тайлан илтгэл бэлтгэхийг УСНББОУСЗ нь дэмжиж зөвшөөрсөн. Байгууллага нь даатгалын хандлага мөрддөг байсан ч гэсэн ийм мэдээлэл нь мөн адил ач тустай гэдгийг УСНББОУСЗ нь энэ явцад бас цохон тэмдэглэсэн.

СТ 63, *Нийгмийн Халамжийн Тэтгэмж*-д ирүүлсэн хариултууд

- ДҮ96. СТ 63-т ирүүлсэн хариултууд нь уг СТ 63-ыг боловсруулах УСНББОУСЗ-ийн нарийвчилсан хэлэлцүүлгийн явцад гарч ирсэн янз бүрийн байр суурийг тусгасан байсан. Хариулт ирүүлсэн олон хүмүүс нь СТ 63-т тусгасан саналуудыг дэмжсэн боловч мөн ойролцоо тооны хүмүүс нь Хувилбар Байр Суурьт дурдсан хандлагыг дэмжсэн байсан (дээрх ДҮ71-ДҮ93-р параграфыг үзнэ).
- ДҮ97. СТ 63, Хувилбар Байр Суурь эсвэл энэхүү хоёр хандлагын аль нэгний багахан өөрчлөлт бүхий хувилбарт дурдсан саналуудыг дэмжихийн тулд тэдгээр хариулт ирүүлэгч хүмүүсийн гаргасан шалтгаан үндэслэл нь өөрийн санал болгосон хандлагад хүрэх явцад УСНББОУСЗ-ийн авч хэлэлцсэн асуудлуудыг ерөнхийдөө тусгасан байсан.
- ДҮ98. Хариулт ирүүлсэн хүмүүс нь шинэ асуудлуудыг гарган дурдсан бөгөөд эдгээр нь Хувилбар Байр Суурийн дагуу толилуулах мэдээллийг буруугаар ойлгож болохоор байна гэсэн санаа зовнилыг ерөнхийдөө илэрхийлсэн. Өр төлбөрийг арай эрт хүлээн зөвшөөрснөөр Хувилбар Байр Суурь нь нийгмийн халамжийн тэтгэмжийн хугацааны мужийг богиносгох, улмаар арай том дүнтэй өр төлбөр болон холбогдох арай том дүнтэй зардлын хүлээн зөвшөөрөлтөөс зориудаар зайлсхийх зохисгүй сэдэл санаачлагыг төрүүлж болох юм гэдэгт санаа зовж буйгаа хариулт ирүүлсэн нэг хүн илэрхийлсэн. Үүнтэй адилаар, Хувилбар Байр Суурийн дагуу хүлээн зөвшөөрөх арай том дүнтэй өр төлбөр нь будлиантай болно гэж хариулт ирүүлсэн өөр нэг хүн үзэж байсан; тэдний үзэл бодлоор бол ирээдүйн тэтгэмж ба ирээдүйн даатгалын шимтгэлийг тусгасан, хэтийн чиглэлтэй хандлага нь улсын тэтгэвэр гэх мэт нийгмийн халамжийн тэтгэмжийн тогтвортой байдлын талаар үнэлгээ хийхийг шаардах юм.
- ДҮ99. Эдгээр асуудлууд нь хэрэглэгчдийн мэдээллийн хэрэгцээ ба чанарын шинжүүдийн талаархи УСНББОУСЗ-ийн өмнөх хэлэлцүүлгүүдийг тусгасан гэж Зөвлөл дүгнэсэн.
- ДҮ100. Нийгмийн халамжийн тэтгэмжийн томоохон өр төлбөрийн барагдуулалтыг санхүүжүүлэх ирээдүйн татвар ногдуулалт буюу даатгалын шимтгэлийн орлогын хувьд хөрөнгө бас хүлээн зөвшөөрөхгүйгээр ийм өр төлбөрийг хүлээн зөвшөөрөх нь ач холбогдолтой мэдээллээр хангах эсэх талаар зөвшилцөлд хүрээгүй байгаа гэдгийг УСНББОУСЗ тэмдэглэсэн. Энэхүү өр төлбөрийн хүлээн зөвшөөрөлт эсвэл үл хүлээн зөвшөөрөлт нь хамааралтай байх, үнэн зөв илэрхийлэх, ойлгомжтой байх, зэрэгцүүлэгдэх боломжтой байх гэсэн чанарын шинжүүдийг хамгийн сайнаар хангах эсэх талаар өөр өөр байр суурьтай байсан.
- ДҮ101. Гэвч уг зөвлөлдөх үйл явцаар ямар нэг чухал ач холбогдолтой шинэ үзэл баримтлалын асуудлыг үүсгэн гаргаагүй тул УСНББОУСЗ нь нийгмийн халамжийн тэтгэмжийн үзэл баримтлалын хандлага боловсруулах талаар нэмэлт ажил гүйцэтгэснээр үр дүнд хүрнэ гэж үзээгүй. Эдгээр хоёр талт шалтгаан тайлбарын хувьд хүмүүсийн баримталж буй хүчтэй байр суурийг энэ шатанд хийгдэх аливаа нэмэлт ажлаар өөрчлөх магадлал багатай гэдгийг нийгмийн халамжийн тэтгэмжийн талаар УСНББОУСЗ-ийн гүйцэтгэсэн ажлын урт түүх харуулж байна.
- ДҮ102. Иймээс УСНББОУСЗ нь СТ 63-д тусгасан саналуудад үндэслэн УСНББОУС-ыг боловсруулахыг зөвшөөрсөн.
- ДҮ103. Ханган бэлтгэсэн мэдээллийг ашиглах хэрэглэгчийн туршлагын хамтаар УСНББОУС-ыг нийгмийн халамжийн тэтгэмжид мөрдөх тухайн тайлан бэлтгэгчийн туршлага нь оршин буй тэдгээр өөр өөр байр суурийг илүү сайнаар зохицуулан шийдвэрлэх арга замыг санал болгож болох юм гэж УСНББОУСЗ нь дээрх дүгнэлтийг гаргах үедээ цохон тэмдэглэсэн. Иймээс

УСНББОУС 42-НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТЭТГЭМЖ

УСНББОУС 42-ын хэрэгжүүлэлтийн дараах нягтлах шалгалтыг ирээдүйн тодорхой нэг хугацаанд хийх нь зохистой байх магадлалтай гэж УСНББОУСЗ дүгнэсэн.

- ДҮ104. СТ 63-т эсвэл Хувилбар Байр Суурьт тусгасан саналыг дэмждэг эсэхээс үл хамааран, хариулт ирүүлсэн олон хүмүүс нь ‘амьд мэнд байх’ гэдгийг уг Саналын Төсөлд хэт онцлон үзсэн гэж дурдсаныг УСНББОУСЗ нь СТ 63-ын саналуудад үндэслэсэн УСНББОУС-ыг боловсруулах үедээ мэдэгдсэн. Амьд мэнд эсэхэд түшиглэх нь тохиромжгүй тийм нөхцөл байдлууд байдаг гэж тэдгээр хүмүүс үздэг. ‘Амьд мэнд байх’ шалгуурыг СТ 63 ба УСНББОУС 39-д ялгаатай авч үздэг талаар санаа зовж буйгаа хариулт ирүүлсэн зарим хүмүүс бас илэрхийлсэн. Гэвч хариулт ирүүлсэн маш цөөн хүмүүс нь амьд мэнд эсэхэд түшиглэх зайлшгүй шаардлагатай гэж үзэж байсан.
- ДҮ105. УСНББОУСЗ нь эдгээр саналуудыг харгалзан үзсэн ба амьд мэнд эсэхэд өгөх ач холбогдлыг багасгахын тулд шаардлагуудыг засвар өөрчлөхийг зөвшөөрсөн. Амьд мэнд байх эсэх нь олон тохиолдолд зохих шалгуур болно, иймээс амьд мэнд байх нь өр төлбөрийн хүлээн зөвшөөрөлтөнд нөлөөлнө гэж УСНББОУСЗ үзсэн. Гэхдээ ямагт ийм байхгүй бөгөөд УСНББОУС нь үүнийг харгалзан тусгах хэрэгтэй гэж УСНББОУСЗ мэдэгдсэн.
- ДҮ106. Ийм өөрчлөлт хийхдээ, УСНББОУСЗ нь нийгмийн халамжийн тэтгэмжийн төлбөр тус бүрийн хувьд зохих шалгуурын ханган биелүүлэлт бол өнгөрсөн тусдаа үйл явдал гэсэн нэмэлт заавар удирдамжийг тусган оруулсан. Дараагийн төлбөрөөс цааших тэтгэмжийн хувьд зохих шалгуурын ханган биелүүлэлт нь ирээдүйн үйл явдал тул одоогийн үүрэг үүсэхэд хүргэхгүй юм.
- ДҮ107. Хувилбар Байр Суурийн хувьд мэдэгдэхүйц дэмжлэг байгааг УСНББОУСЗ нь мэдэгдээд УСНББОУС 42-т нягтлан бодох бүртгэлийн энэхүү хоёр арга хандлагын аль алиныг тусган оруулах нь тохиромжтой эсэхийг авч үзсэн. Энэ нь СТ 63-т санал болгосноос өөр, өнгөрсөн үйл явдал нь тохиромжтой гэж тодорхойлсон тохиолдолд тухайн нийгмийн халамжийн тэтгэмжийн хөтөлбөрийн хувьд Хувилбар Байр Суурь ашиглах боломжийг тайлан бэлтгэгч нарт олгох юм. Энэ нь тууштай байх гэсэн чанарын шинжийг хангахгүй гэж УСНББОУСЗ дүгнэсэн бөгөөд иймээс Хувилбар Байр Суурьт заасан, нягтлан бодох бүртгэлийн арга хандлагыг УСНББОУС 42-т оруулахгүй байхаар шийдвэрлэсэн.

“Нөөц” нэр томъёог ашиглах

- ДҮ108. СТ 63-ыг боловсруулахдаа, УСНББОУСЗ нь “өнгөрсөн үйл явдлын үр дүнд нөөцийг гадагш зарцуулах одоогийн үүрэг”-тэй байгууллагыг илэрхийлэх тийм хүлээн зөвшөөрөлтийн шаардлагуудыг тусган оруулсан. Нийгмийн халамжийн тэтгэмжийн тодорхойлолтонд зөвхөн мөнгөн шилжүүлгийг оруулна гэдгийг тодруулан баталгаажуулсан шийдвэрийн дараа, УСНББОУСЗ нь уг хүлээн зөвшөөрөлтийн шаардлага дахь “нөөц” нэр томъёог “мөнгөн шилжүүлэг” нэр томъёогоор орлуулан ашиглах эсэхийг авч хэлэлцсэн. *Онолын Үзэл Баримтлал* дахь өр төлбөрийн тодорхойлолтонд “нөөц” гэдэг хэллэг ашигласан болохыг УСНББОУСЗ цохон тэмдэглэсэн, иймээс уг хүлээн зөвшөөрөлтийн шаардлагад “нөөц” нэр томъёог хэвээр үлдээхийг УСНББОУСЗ зөвшөөрсөн.

Хэмжилт

- ДҮ109. 2015 оны ЗББ-ийг боловсруулахдаа, УСНББОУСЗ нь “үүрэг хүлээлгэх үйл явдал хандлага [ерөнхий хандлага]-ын дагуу нийгмийн халамжийн тэтгэмжийн хувьд өр төлбөрийг түүний гүйцэтгэлийн өртгийг ашиглан хэмжих хэрэгтэй. Гүйцэтгэлийн өртөг нь уг шаардлагатай тэтгэмжийн тооцоолсон үнэ цэнийг тусгасан байна” гэсэн анхдагч саналыг гаргасан. Гүйцэтгэлийн өртгийг *Онолын Үзэл Баримтлал*-д “өртөг зардал хамгийн бага байхаар гүйцэтгэнэ гэж төсөөлөхөд уг өр төлбөрөөр илэрхийлэгдэж буй үүргийн гүйцэтгэлийг хангахын тулд байгууллагын зарцуулах өртөг зардал” гэж тодорхойлсон.
- ДҮ110. УСНББОУСЗ нь дараах шалтгааны улмаас ийм санал гаргахад хүрсэн:

УСНББОУС 42-НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТЭТГЭМЖ

- (а) Нийгмийн халамжийн тэтгэмжийн олон өр төлбөр нь арилжааны бус ажил гүйлгээнээс үүсдэг. Түүхэн өртгийг ашиглах үндэслэлгүй байж болох юм. Зарим нийгмийн халамжийн тэтгэмжийн хувьд дүн нь хувьсан өөрчлөгдөж болох өр төлбөрт түүхэн өртгийг хэрэглэхэд бас төвөгтэй байж болно.
- (б) Нийгмийн халамжийн тэтгэмжийн хувьд зах зээлийн үнэ цэнэ оршин байх магадлал маш бага юм.
- (в) Нийгмийн халамжийн тэтгэмжийн хувьд, чөлөөлөгдөх өртөг нь “өр төлбөрийн шилжүүлэлтийг зөвшөөрөхийн тулд гуравдагч талын нэхэмжлэх” дүн юм. Нийгмийн халамжийн тэтгэмжийн хувьд, өр төлбөрийг шилжүүлэх практик боломж маш бага байдаг.
- (г) Үүрэг хариуцсаны үнэ нь “одоо байгаа өр төлбөрийг хариуцсаны хариуд байгууллагын ул үндэслэлтэйгээр хүлээн зөвшөөрөхөд бэлэн байгаа дүн” юм. Энэ нь ерөнхий хандлагын дагуу нийгмийн халамжийн тэтгэмжийн хэмжилтэнд хамааралгүй байдаг. Энэхүү хандлагын дагуу өр төлбөр нь тухайн улсын секторын байгууллагын өөрийн ажиллагааны үр дүн байдлаар үүсдэг гэж үздэг.

ДҮ111. СТ 63-г хариулт ирүүлсэн хүмүүсийн адилаар ЗББ-г хариулт ирүүлсэн хүмүүс нь энэхүү байр суурийг дэмжсэн. Иймээс нийгмийн халамжийн тэтгэмжийн хувьд өр төлбөрийг УСНББОУСЗ нь гүйцэтгэлийн өртөг (өөрөөр хэлбэл, төлөх нийгмийн халамжийн тэтгэмжийн төлбөрөөр, харин дараагийн жилд төлөх тохиолдолд дискаунтчилсан дүнг) ашигласнаар хэмжихийг зөвшөөрсөн. Ийм шийдвэр гаргахдаа, УСНББОУСЗ нь өртөг бол зөвхөн хийгдэх мөнгөн шилжүүлгийг илэрхийлнэ үүнд, захиргааны зардал, банкны шимтгэл гэх мэт бусад зүйлс хамаарахгүй гэдгийг хүлээн зөвшөөрсөн.

Орлого

ДҮ112. УСНББОУС 42-ыг боловсруулж байх тэр үед УСНББОУСЗ нь өөрийн орлогын бүх стандартын шаардлагуудыг нягталж судлах төслийг хэрэгжүүлж байсан. Бүх орлогыг нэг тууштай сууриар тайлагнадаг гэдгийг ханган магадлахын тулд УСНББОУСЗ нь нийгмийн даатгалын шимтгэл (нийгмийн халамжийн тэтгэмжийн хөтөлбөрийн хувьд орлого) болон адилтгах албан журмын шимтгэл, хураамжийг уг төсөлд маш сайн харгалзан тусгахаар шийдвэрлэсэн. Гэвч нийгмийн даатгалын шимтгэл нь арилжааны бус ажил гүйлгээ гэж УСНББОУСЗ дүгнэсэн тул нийгмийн даатгалын шимтгэлийг УСНББОУС 23, *Арилжааны Бус Ажил Гүйлгээний Орлого (Татвар ба Шилжүүлэг)*-ын дагуу тайлагнана гэдгийг тодорхой болгох үүднээс УСНББОУСЗ нь тус Стандартад нэмэлт өөрчлөлт оруулахыг зөвшөөрсөн. Байгууллага нь нийгмийн халамжийн тэтгэмжийн хөтөлбөрийг даатгалын хандлага ашиглан тайлагнах сонголт хийвэл үүнээс гажих ганц тохиолдол болох юм. Даатгалын хандлага нь мөнгөн орлогын гүйлгээ ба мөнгөн зарлагын гүйлгээний аль алиныг харгалзан тусгадаг, иймээс даатгалын хандлагын дагуу тайлагнадаг нийгмийн халамжийн тэтгэмжийн хөтөлбөрт оруулсан нийгмийн даатгалын шимтгэлийг УСНББОУС 23-ын дагуу орлого гэж тайлагнахгүй.

Тодруулга

ДҮ113. СТ 63-ыг боловсруулах үедээ УСНББОУСЗ нь дараах мэдээллийг байгууллагууд тодруулах хэрэгтэй гэдгийг хүлээн зөвшөөрсөн. Үүнд: өөрийн нийгмийн халамжийн тэтгэмжийн хөтөлбөрийн шинж чанарыг тайлбарлах; түүний нийгмийн халамжийн тэтгэмжийн хөтөлбөрөөс үүссэн бөгөөд санхүүгийн тайланд тусгасан дүнгүүдийг тодорхойлж, тайлбарлах; нийгмийн халамжийн тэтгэмжийн хөтөлбөрөөс үүсэж болох ирээдүйн мөнгөн гүйлгээг тооцож, тайлбарлах.

ДҮ114. Тус бүрдээ материаллаг бус нийгмийн халамжийн тэтгэмжийн хөтөлбөрүүдийн хувьд тодруулгыг нэгтгэн нийлүүлэх талаархи заавар удирдамжаар хангах хэрэгтэй эсэхийг УСНББОУСЗ нь авч үзсэн. УСНББОУС 1, *Санхүүгийн Тайлангийн Толлуулга* нь материаллаг байдал, нэгтгэн нийлүүлэлтийн талаархи заавар удирдамжийг агуулсан гэж УСНББОУСЗ дурдсан ба нэмэлт заавар удирдамж шаардлагагүй гэж дүгнэсэн.

УСНББОУС 42-НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТЭТГЭМЖ

ДҮ115. Нийгмийн халамжийн тэтгэмжийн хөтөлбөрийн шинж чанаруудын тайлбарын нэг хэсэг болгон байгууллага нь тухайн нийгмийн халамжийн тэтгэмжийн хөтөлбөрөө хэрхэн санхүүжилдэг болохыг тайлбарлах хэрэгтэй гэж УСНББОУСЗ дүгнэсэн. Хөтөлбөрийг (бүрэн эсвэл хэсэгчлэн) нийгмийн даатгалын шимтгэлээр санхүүжүүлдэг тохиолдолд байгууллага нь тэрхүү нийгмийн даатгалын шимтгэлийн талаархи мэдээллийг тусгасан байршлын хувьд харилцан лавлагаа үүсгэх шаардлагатай юм. Хэдийгээр нийгмийн даатгалын шимтгэлийг УСНББОУС 42-т тусган дурдаагүй (дээрх ДҮ112-р параграфт тайлбарласан) боловч хэрэглэгчид нь нийгмийн халамжийн тэтгэмжийн хөтөлбөрийн хувьд үнэлгээ хийхэд уг нийгмийн даатгалын шимтгэлийн талаархи мэдээлэл тэдэнд шаардлагатай эсэхийг УСНББОУСЗ нь харгалзан үзсэн. Гэвч зарим улс оронд янз бүрийн нийгмийн халамжийн тэтгэмжид зориулсан нийгмийн даатгалын шимтгэлийг нэг байгууллага нь цуглуулдаг ба өөр нэг байгууллага нь нийгмийн халамжийн тэтгэмжийг олгодог байж болно гэж УСНББОУСЗ мэдэгдсэн. Ийм тохиолдолд нийгмийн халамжийн тэтгэмжийг олгодог байгууллага нь тухайн нийгмийн даатгалын шимтгэлийг цуглуулдаг нөгөө байгууллагын санхүүгийн тайлангийн хувьд харилцан лавлагаа тусган оруулах юм.

ДҮ116. Нийгмийн халамжийн тэтгэмжийн хөтөлбөр нь ирээдүйн үүргийг хэрхэн үүсгэж болохыг тайлбарлан тодорхойлохыг байгууллагаас шаардах эсэхийг УСНББОУСЗ нь харгалзан үзсэн. УСНББОУСЗ нь ийм тодруулга шаардахгүй байхаар шийдвэрлэсэн. Гэвч дараагийн таван тайлант үеийн хувьд төсөвлөсөн мөнгөн зарлагын талаархи тухайн байгууллагын хамгийн сайн тооцооллыг бэлтгэх нь санхүүгийн тайлангийн хэрэглэгчдийг ач холбогдолтой мэдээллээр хангана гэдгийг УСНББОУСЗ нь СТ 63-ыг боловсруулах үедээ хүлээн зөвшөөрсөн. Ийм мэдээлэл нь тухайн байгууллагын хөрвөх чадвар ба төлбөрийн чадварыг үнэлэхэд хэрэглэгчдэд тустай гэж УСНББОУСЗ үзсэн.

СТ 63, *Нийгмийн Халамжийн Тэтгэмж*-д ирүүлсэн хариултауд

ДҮ117. СТ 63-т хариулт ирүүлсэн хүмүүс нь байгууллагын нийгмийн халамжийн тэтгэмжийн хөтөлбөрийн шинж чанарын талаархи уг санал болгосон тодруулгыг ерөнхийдөө дэмжсэн бөгөөд УСНББОУСЗ нь тэдгээр тодруулгыг УСНББОУС 42-т хэвээр үлдээхийг зөвшөөрсөн.

ДҮ118. Хариулт ирүүлсэн ихэнх хүмүүс нь санхүүгийн тайлан дахь дүнгүүдийн уг санал болгосон тодруулгыг бас дэмжсэн. Гэвч хариулт ирүүлсэн зарим хүмүүс нь санхүүгийн тайланд дүнгүүдийг толилуулах шаардлагатай дэлгэрэнгүй байдлын түвшинд эргэлзсэн. Нийгмийн халамжийн тэтгэмжийн хувьд хүлээн зөвшөөрөх өр төлбөрийн богино хугацаат шинж чанарыг харгалзвал, уг санал болгосон тохируулгын тайлан (өр төлбөрийн эхний үлдэгдэл ба эцсийн үлдэгдлийн) нь тухайн санхүүгийн тайлангийн аль нэг хэсгээс олох боломжгүй тийм ямар нэг мэдээллээр хангана гэж тэдгээр хариулт ирүүлсэн хүмүүс үзэхгүй байв. Тохируулгын тайлан толилуулах уг шаардлагыг ямар нэг мэдээлэл алдахгүйгээр хасаж болно гэж тэд дүгнэсэн. Өр төлбөрийн тохируулгын тайлан шаардлагагүй гэж үзсэн эдгээр хариулт ирүүлсэн хүмүүсийн байр суурьтай УСНББОУСЗ нь санал нэг байсан. Гэвч УСНББОУСЗ нь хэрэглэгчдэд нийгмийн халамжийн тэтгэмжийн материаллаг хөтөлбөр нэг бүрийн зарлагын талаархи мэдээлэл шаардлагагүй гэж үзсэн бөгөөд тухайн мэдээллийг тохируулгын тайлан хэлбэрээр биш, харин тодруулга байдлаар шаардахыг зөвшөөрсөн.

ДҮ119. Ирээдүйн мөнгөн зарлагын уг санал болгосон тодруулгын хувьд тэдгээр хариулт ирүүлсэн хүмүүс нь санал нэгтэй байр суурьт хүрээгүй. Энэхүү санал болгосон тодруулгыг дэмжсэн эсэхээс үл хамааран, тэдгээр хариулт ирүүлсэн хүмүүс нь олон асуудлыг дэвшүүлэн гаргасан:

- (a) Өөр бусад (татварын орлого гэх мэт) ажил гүйлгээний хувьд ирээдүйн мөнгөн гүйлгээ шаардлагагүй.
- (b) Санхүүгийн тайлан нь байгууллагын одоогийн төлөв байдлын талаар тайлагнадаг, харин ирээдүйн мөнгөн зарлагын гүйлгээ нь байгууллагын төсвийн прогноз мэдээллийн нэг хэсэг бөгөөд одоогийн нөхцөл байдлын талаархи мэдээлэл биш юм.
- (b) Зарлагын гүйлгээний төсөвлөлтийг орлогын гүйлгээний төсөвлөлтийн хамтаар хамгийн сайн харгалзан тусгадаг бөгөөд зөвхөн нэг нийгмийн халамжийн тэтгэмжийн хөтөлбөрт

УСНББОУС 42-НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТЭТГЭМЖ

чиглэх биш, харин цогцоор авч үзэхэд хамгийн их ач холбогдолтой байдаг. Нийгмийн халамжийн тэтгэмжийн олон хөтөлбөрүүдийг татварын ерөнхий нэг орлогоор санхүүжүүлдэг тул ихэнх тохиолдолд нэг нийгмийн халамжийн тэтгэмжийн хөтөлбөрийн хувьд мөнгөн орлогын гүйлгээг төсөвлөх боломжгүй байдаг.

- (г) Ирээдүйн мөнгөн зарлагын гүйлгээг тодруулах нь ерөнхий хандлагатай үл нийцэх өр төлбөр буюу үүргийг уг ирээдүйн мөнгөн зарлагын гүйлгээ тусган илэрхийлнэ гэсэн утгатай байж болох юм.

ДҮ120. Хариулт ирүүлсэн хүмүүсийн дэвшүүлэн гаргасан асуудлуудыг, ялангуяа тухайн тодруулга нь байгууллагын одоогийн төлөв байдлын тайлагналаас хэтийн хугацаанд хамаарч байна гэсэн санааг УСНББОУСЗ хүлээн зөвшөөрсөн. Иймээс УСНББОУСЗ нь ирээдүйн мөнгөн зарлагын гүйлгээний тодруулга хийх шаардлагыг хасахаар шийдвэрлэсэн.

ДҮ121. Гэвч нөхцөл байдал нь нийгмийн халамжийн тэтгэмжийн хөтөлбөрт хэрхэн нөлөөлж болохыг хэрэглэгч нар үнэлэхэд туслалцаа үзүүлэх зарим мэдээлэл тэдэнд шаардлагатай болно гэж УСНББОУСЗ үзсэн. Иймээс нийгмийн халамжийн тэтгэмжийн хөтөлбөрт нөлөөлөх хүн ам зүйн, эдийн засгийн болон бусад гаднын хүчин зүйлсийг тайлбарлах хүүрнэсэн хэлбэрийн тодруулга хийхийг тайлан бэлтгэгч нараас шаардахыг УСНББОУСЗ хүлээн зөвшөөрсөн.

ДҮ122. Нийгмийн халамжийн тэтгэмжийн хөтөлбөр нь даатгалын хандлага ашиглан тайлагнах шалгуурыг хангасан тохиолдолд байгууллага нь тодруулга хийх хэрэгтэй гэсэн нэмэлт саналыг тэдгээр хариулт ирүүлсэн хүмүүс гаргасан. Энэ нь нийгмийн халамжийн тэтгэмжийн хөтөлбөрийн шинж чанарын талаархи чухал мэдээлэл бөгөөд даатгалын хандлага ашиглах шалгуур хангагдсан тохиолдолд байгууллага нь тодруулга хийх хэрэгтэй гэдгийг УСНББОУСЗ зөвшөөрсөн.

Даатгалын хандлага (26-31-р параграф)

Даатгалын хандлагын мөрдөлт

ДҮ123. Зарим буюу бүх нийгмийн даатгалын шимтгэлийн хөтөлбөрийн хувьд даатгалын нягтлан бодох бүртгэлд үндэслэсэн хандлагыг УСНББОУСЗ нь ЗББ, *Нийгмийн Халамжийн Тэтгэмжийн Хүлээн Зөвшөөрөлт ба Хэмжилт*-д санал болгосон. Энэ хандлага нь даатгалын гэрээний хувьд НББОУСЗ-ийн санал болгосон ба Саналын Төсөл СТ/2013/7, *Даатгалын Гэрээ* (2013 оны 6-р сар)-д тусгасан СТОУС-д үндэслэвэл зохино гэдгийг УСНББОУСЗ мэдэгдсэн. Уг СТ-ийг цаашид боловсруулж, СТОУС 17, *Даатгалын Гэрээ* болгож гаргасан.

ДҮ124. ЗББ-т хариулт ирүүлсэн хүмүүс нь олон асуудлуудыг дэвшүүлэн гаргасан боловч даатгалын хандлагын талаархи УСНББОУСЗ-ийн саналыг ерөнхийдөө дэмжсэн. Хариулт ирүүлсэн хүмүүс нь даатгалын хандлагыг зөвхөн цөөн хязгаарлагдмал нөхцөлд мөрдөх хэрэгтэй гэж үзсэн. Ийм нөхцөлд дараах зүйлс хамаарна: нийгмийн халамжийн тэтгэмжийн хөтөлбөр нь даатгалын гэрээтэй ижил арга замаар ажиллаж, үйлчилдэг байх; хөтөлбөрийг татварын ерөнхий орлогоор биш, харин тусгайлан зориулсан орлогын эх үүсвэрээр санхүүжүүлдэг байх. Үүнээс бусад нийгмийн халамжийн тэтгэмжийн хөтөлбөрийн хувьд даатгалын хандлагыг мөрдөх нь тухайн хөтөлбөрийн эдийн засгийн мөн чанарыг үнэн зөв илэрхийлэхгүй гэж тэдгээр хариулт ирүүлсэн хүмүүс дүгнэсэн.

ДҮ125. УСНББОУСЗ нь энэ байр суурьтай санал нэг байсан. Иймээс даатгалын хандлагыг зөвхөн дараах тохиолдолд мөрдөхийг УСНББОУСЗ зөвшөөрсөн:

- (а) Нийгмийн халамжийн тэтгэмжийн хөтөлбөрийг нийгмийн даатгалын шимтгэлээр бүрэн санхүүжүүлэх санаа зорилготой байх; ба
- (б) Байгууллага нь даатгалын гэрээ гаргагчтай ижил арга замаар хөтөлбөрийг удирдан зохицуулдаг, үүн дотроо тухайн хөтөлбөрийн санхүүгийн үр дүн ба санхүүгийн байдлыг тогтмол үечилсэн сууриар үнэлдэг гэсэн нотолгоотой байх.

УСНББОУС 42-НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТЭТГЭМЖ

- ДҮ126. Зохих шалгуур хангасан нийгмийн халамжийн тэтгэмжийн хөтөлбөрийн хувьд даатгалын хандлага нь албан журмын эсвэл сайн дурын байх эсэхийг УСНББОУСЗ нь СТ 63-ыг боловсруулах үедээ харгалзан үзсэн.
- ДҮ127. Даатгалын хандлага ашиглах шалгуурыг хангадаг нийгмийн халамжийн тэтгэмжийн хөтөлбөрийн хувьд уг хандлага нь хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагад хамгийн сайн нийцэх тийм мэдээллийг бүрдүүлэх эсэхийг УСНББОУСЗ нь харгалзан үзсэн. Нийгмийн халамжийн тэтгэмжийн хөтөлбөрийн санхүүгийн гүйцэтгэлийг уг байгууллага зохих ёсоор удирдан зохицуулж буй эсэхийг үнэлэхийн тулд хэрэглэгчид нь тухайн хүлээгдэж буй өр төлбөрийг барагдуулахад нийгмийн даатгалын шимтгэл хангалттай эсэх талаархи мэдээллийг шаарддаг. Даатгалын хандлагын дагуу алдагдал тайлагнасан тохиолдолд энэ нь нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ эсвэл тэтгэмжийг өөрчлөхгүйгээр тухайн хөтөлбөр тогтвортой байж чадах эсэхэд хэрэглэгч нар эргэлзэхэд хүргэх мэдээллээр хангах юм. Үүнтэй адилаар, нийгмийн халамжийн тэтгэмжийн хөтөлбөр нь байнга их хэмжээний ашигтай гардаг тохиолдолд тус хөтөлбөр нь зарим зарлагыг буцалтгүй тусламжаар санхүүжүүлдэг эсэх, хэрэв тийм бол ингэж санхүүжүүлэх нь тохиромжтой эсэх талаар асуудал үүсэхэд хүргэнэ. Хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагыг даатгалын хандлагаар хамгийн сайн хангаж буй нь даатгалын хандлагыг албан журмын болгох гол шалтгаан болно гэж УСНББОУСЗ нь анх дүгнэж байсан.
- ДҮ128. Гэвч даатгалын хандлага нь ерөнхий хандлагаас илүү их өртөг зардалтай ба нарийн төвөгтэй байхаар хүлээгдэж байна. Ерөнхий хандлагын дагуу актуар тооцоолол шаардлагагүй байж болох юм. Даатгалын хандлага нь хөтөлбөрийн хугацаан дахь мөнгөн орлогын гүйлгээ ба мөнгөн зарлагын гүйлгээний тооцоолол хийхийг шаарддаг. Түүнчлэн, НББОУСЗ нь СТОУС 17-г дөнгөж саяхан гаргасан бөгөөд уг Стандарт нь даатгалыг зохицуулдаг, одоо оршин буй үндэсний олон стандартуудаас ихээхэн өөр шаардлагуудтай байдаг. Иймээс практикын аливаа асуудлуудыг бүрэн тодорхойлж, авч үзэхэд тодорхой хугацаа шаардаж болох юм. Эдгээр шинэ шаардлагуудыг нийгмийн халамжийн тэтгэмжид мөрдөхөд илүү нарийн цогц асуудал үүсгэх билээ. Даатгалын хандлагыг ашиглахгүй байх өртөг/өгөөжийн учир үндэслэл байж болох бөгөөд иймээс энэ нь даатгалын хандлагыг сонголтот хандлага болгох үндсэн шалтгаан болсон гэж УСНББОУСЗ үзсэн.
- ДҮ129. Хэрэв байгууллага нь нийгмийн халамжийн тэтгэмжийн хөтөлбөрийг багц даатгалын гэрээ байдлаар удирдан зохицуулдаг бол тухайн байгууллага нь угаасаа даатгалын хандлагыг хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээлэлтэй байж болох юм гэдгийг УСНББОУСЗ тэмдэглэсэн. Нийгмийн халамжийн тэтгэмжийн хөтөлбөрийг үр дүнтэйгээр удирдан зохицуулах боломжтой болохын тулд мөн ийм мэдээлэл шаардлагатай байж болно. Нийгмийн халамжийн тэтгэмжийн хөтөлбөр нь даатгалын хандлагын дагуу тайлагнах шалгуурыг хангадаг тохиолдолд ингэж тайлагнахтай холбоотой өртөг зардал нь анх төсөөлж байсантай адил тийм ч өндөр биш байж болно гэж үзсэн.
- ДҮ130. Байгууллага нь даатгалын хандлагыг мөрдөх шалгуур хангагдсан эсэхийг тодорхойлоход төвөгтэй тохиолдолд даатгалын хандлагыг сонголтот хувилбар болгосны цаашдын давуу тал гарна гэж УСНББОУСЗ үзсэн. Ерөнхий хандлагыг мөрдөх сонголт хийснээр байгууллага нь ингэж тодорхойлохтой холбоотой нэмэлт нөөцийн зарцуулалтаас зайлсхийж чадах юм.
- ДҮ131. Гэвч даатгалын хандлагыг сонголтот хувилбар болгосноор уг хандлагыг маш цөөхөн байгууллага мөрдөх ба зарим нийгмийн халамжийн тэтгэмжийн хөтөлбөрийн талаархи хамгийн зохистой мэдээллээр хэрэглэгчдийг хангахгүй болно гэдгийг УСНББОУСЗ хүлээн зөвшөөрсөн. Даатгалын хандлагын дагуу тайлагнах нийгмийн халамжийн тэтгэмжийн хөтөлбөр нь бусад нийгмийн халамжийн тэтгэмжийн хөтөлбөртэй харьцуулахад ерөнхий хандлагаар бүрэн тусган харуулж чадахгүй эрс өөр эдийн засгийн мөн чанартай байх магадлалтай юм.
- ДҮ132. Нэгтгэн дүгнэвэл, УСНББОУСЗ нь дээр дурдсан өртөг/өгөөжийн учир шалтгаанд үндэслэн даатгалын хандлагыг сонголттой хэрэглэж болно гэж үзсэн. Байгууллагууд нь СТОУС-ын шинэ Стандартууд болон СТ 63-д санал болгосон даатгалын хандлагыг мөрдөх туршлага хуримтлуулсны дараа үүнийг ирээдүйд дахин авч үзнэ гэж УСНББОУСЗ мэдэгдсэн.

УСНББОУС 42-НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТЭТГЭМЖ

СТ 63, *Нийгмийн Халамжийн Тэтгэмж*-д ирүүлсэн хариултууд

- ДҮ133. Дээр дурдсанчлан, даатгалын хандлагыг сонголттой мөрдөхөөр СТ 63-д санал болгосон. СТ 63-т хариулт ирүүлсэн хүмүүс нь уг саналын хувьд янз бүрийн байр суурьтай байсан. Зарим хүмүүс нь даатгалын хандлагыг сонголттой мөрдөхийг зөвшөөрсөн. Харин өөр зарим хүмүүс нь шалгуурыг тухайн хөтөлбөр хангаж байх тохиолдолд даатгалын хандлагыг заавал мөрддөг байвал зохино гэж үзэж байсан.
- ДҮ134. Эдгээр хариулт ирүүлсэн хүмүүсийн гаргасан шалтгаан үндэслэл нь УСНББОУС3-ийн өмнөх хэлэлцүүлгийг тусгасан байна гэдгийг Зөвлөл цохон тэмдэглэсэн. Үүний гол асуудал нь: даатгалын хандлагаар бүрдүүлэх арай сайн мэдээллийн өгөөж нь тэрхүү мэдээллийг бэлтгэх өртөг зардлаас давж илүү гарах эсэх явдал юм. Нэг УСНББОУС-ыг сонголттой мөрдөх боломжтой байх нь байгууллагууд хооронд зэрэгцүүлэлт хийх хэрэглэгчдийн чадвар боломжийг бас бууруулна гэж зарим хүмүүс үзэж байсан.
- ДҮ135. СТ 63-т ирүүлсэн хариултууд нь уг СТ 63 дахь саналыг өөрчлөн засварлахад хүргэх хангалттай итгэл үнэмшилтэй шинэ мэдээллийг бий болгоогүй гэж УСНББОУС3 эцэст нь дүгнэсэн. Иймээс УСНББОУС3 нь даатгалын хандлагыг энэхүү Стандартад сонголтот хандлага байдлаар хэвээр үлдээхийг зөвшөөрсөн.
- ДҮ136. Гэвч хариулт ирүүлсэн хүмүүс хоорондоо зөвшилцөлд хүрээгүй байдал, энэ Стандарт болон СТОУС 17-г мөрдөх явцад байгууллагууд практик туршлага олж авснаар практикт хөгжил дэвшил гарах магадлалыг харгалзан УСНББОУС3 нь энэхүү асуудлыг мөн цаашид хянан үзэх хэрэгтэй гэж үзсэн. Ийм практик туршлага нь өртөг-өгөөжийн тэнцвэрийн талаархи өөрийн байр суурийг УСНББОУС3 дахин авч үзэх шалтгаан болж болох юм.
- ДҮ137. Даатгалын хандлага хэрэглэхийг байгууллагад зөвшөөрөх эсэхийг тодорхойлох шалгуур нь тохиромжтой гэж СТ 63-т хариулт ирүүлсэн ихэнх хүмүүс үзэж байсан. Гэвч нийгмийн халамжийн тэтгэмжийн хөтөлбөрийг нийгмийн даатгалын шимтгэлээр бүрэн санхүүжүүлэх санаа зорилготой байх гэсэн шаардлагын хувьд зарим хүмүүс эргэлзэж байв.
- ДҮ138. Хөтөлбөрийг нийгмийн даатгалын шимтгэлээр бүрэн биш гэхэд мэдэгдэхүйц их хэмжээгээр санхүүжүүлдэг бол СТОУС 17-гийн шаардлагууд тохиромжтой тийм тохиолдлууд байдаг гэж эдгээр хариулт ирүүлсэн хүмүүс үзсэн. Өөрөө хариуцаж чадахааргүй этгээдийн өмнөөс өөр нэг байгууллага шимтгэлийг төлсөн боловч нэгтгэсэн санхүүгийн тайланд тухайн хөтөлбөрийг бүрэн санхүүжүүлсэн гэж ангилдаггүй тохиолдолд уг бие даасан байгууллага нь тэрхүү хөтөлбөрийг бүрэн санхүүжүүлсэн гэж ангилах боломжтой гэдэгт тусгайлан санаа зовж байсан. Хөтөлбөрийн менежмент нь санхүүжилтийн хандлагаас илүү чухал ач холбогдолтой гэж тэдгээр хариулт ирүүлсэн хүмүүс үзэж байв.
- ДҮ139. УСНББОУС3 нь эдгээр асуудалд анхаарал хандуулсан. Ерөнхий татварын орлогоор хэсэгчлэн санхүүжүүлэхээр зохиомжилсон хөтөлбөрийг даатгалын багцтай ижил арга замаар удирдан зохицуулдаггүй гэсэн байр сууриа УСНББОУС3 хэвээр хадгалсан.
- ДҮ140. Гэвч өөрөө хариуцаж чадахааргүй этгээдийн өмнөөс байгууллага нь шимтгэлийг төлсөн тохиолдолд тэдгээр төлбөрийг шимтгэл гэж үзэх ба уг хөтөлбөрийг шимтгэлээр бүрэн санхүүжүүлсэн гэж ангилах хэрэгтэй гэдгийг УСНББОУС3 зөвшөөрсөн. Энэ асуудлыг тодруулахын тулд УСНББОУС3 нь Мөрдөх Заавар Удирдамж оруулахыг зөвшөөрсөн.
- ДҮ141. Даатгалын хандлагыг мөрдөх шалгуур хангагдсан эсэх талаархи шийдвэр нь хэлбэрээс илүү мөн чанарт голлон чиглэвэл зохино гэдгийг хариулт ирүүлсэн зарим хүмүүс бас санал болгосон. Хэлбэрээс илүү мөн чанар гэсэн санаа нь *Онолын Үзэл Баримтлал*-ын үнэн зөв толилуулгын ухагдахуунд агуулагдсан гэдгийг УСНББОУС3 цохон тэмдэглэсэн. Гэвч даатгалын хандлагыг мөрдөх шалгуурын үнэлгээнд хэлбэрээс илүү мөн чанарыг харгалзах шаардлагатайг онцлон илэрхийлсэн, нэмэлт Мөрдөх Заавар Удирдамж нь тайлан бэлтгэгч нарт ач тустай гэдгийг УСНББОУС3 хүлээн зөвшөөрсөн.

УСНББОУС 42-НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТЭТГЭМЖ

Нягтлан бодох бүртгэлийн шаардлагууд

ДҮ142. Даатгалын хандлага нь НББОУСЗ-ийн Саналын Төсөлд үндэслэх хэрэгтэй гэдгийг УСНББОУСЗ нь ЗББ, *Нийгмийн Халамжийн Тэтгэмжийн Хүлээн Зөвшөөрөлт ба Хэмжилт*-санал болгосон.

ДҮ143. УСНББОУСЗ нь даатгалын хандлагыг нэвтрүүлэх гурван сонголтыг СТ 63-г тодорхойлсон:

- (а) Даатгалын хандлагыг СТ 63-аар боловсруулах. Энэхүү сонголт нь ЗББ-ийн саналуудтай нийцэх бөгөөд нийгмийн халамжийн тэтгэмжүүдийн хувьд тохиромжтой гэдгийг УСНББОУСЗ тэмдэглэсэн. Гэвч энэ сонголт нь төслийн хугацааг мэдэгдэхүйц ургасгах ба уг сонголтыг өргөн хүрээтэй мөрдөхөөргүй байсан.
- (б) Даатгалын талаархи тусдаа УСНББОУС-ыг боловсруулах. Энэ нь УСНББОУСЗ-ийн хэвлэл бүтээлийн цоорхойг нөхөж, нийгмийн халамжийн тэтгэмжүүдийг харгалзан тусгах ба өргөн хүрээнд мөрдөгдөнө гэдгийг УСНББОУСЗ тэмдэглэсэн. Гэхдээ ийм УСНББОУС-ыг УСНББОУСЗ-ийн ажлын төлөвлөгөөнд тусгаагүй бөгөөд шинэ Стандартын боловсруулалт нь уг нийгмийн халамжийн тэтгэмжийн төслийн хугацааг хойшлуулахад хүргэнэ гэдгийг УСНББОУСЗ мэдэгдсэн.
- (в) Даатгалын хандлагыг мөрдөх шалгуурыг хангасан, нийгмийн халамжийн тэтгэмжийн хөтөлбөрийн хувьд СТОУС 17-г (эсвэл даатгалыг зохицуулдаг үндэсний нягтлан бодох бүртгэлийн холбогдох стандартыг) адилтган мөрдөх чиглэлийг тайлан бэлтгэгч нарт өгөх. Энэ нь арай бага нөөц шаардах ба СТОУС-тай нийцсэн болохыг ханган магадлана гэж УСНББОУСЗ мэдэгдсэн. Гэхдээ нийгмийн халамжийн тэтгэмжийн тусгай асуудлуудын талаархи заавар удирдамж шаардлагатай байж болох юм.

ДҮ144. Өөрт нь даатгалын хандлага хамааралтай, тийм тайлан бэлтгэгчдийн тоо цөөхөн байх магадлалтай гэдгийг УСНББОУСЗ дурдсан. Даатгалын хандлагыг мөрдөх шалгуур нь даатгалын гэрээтэй ихээхэн төсөөтэй зөвхөн тэдгээр нийгмийн халамжийн тэтгэмжийн хөтөлбөрүүдэд хамааралтай гэсэн утгатай болохыг УСНББОУСЗ бас цохон тэмдэглэсэн.

ДҮ145. Иймээс СТ 63-аар эсвэл даатгалын тусдаа УСНББОУС байдлаар даатгалын хандлагыг хөгжүүлэн боловсруулахад шаардлагатай нэмэлт цаг хугацаа болон нөөцийг зөвтгөн баталж чадахгүй гэж УСНББОУСЗ дүгнэсэн. Дараах нийгмийн халамжийн тэтгэмжийн хөтөлбөрийн хувьд СТОУС 17-г (эсвэл даатгалыг зохицуулдаг үндэсний нягтлан бодох бүртгэлийн холбогдох стандартыг) адилтган мөрдөх чиглэлийг тайлан бэлтгэгч нарт өгөхийг УСНББОУСЗ зөвшөөрсөн:

- (а) Даатгалын хандлагыг мөрдөх шалгуурыг хангасан; ба
- (б) Даатгалын хандлагын дагуу тайлагнахаар байгууллагын сонгосон.

ДҮ146. Нийгмийн халамжийн тэтгэмжийн хөтөлбөрийн хувьд СТОУС 17-г (эсвэл даатгалыг зохицуулдаг үндэсний нягтлан бодох бүртгэлийн холбогдох стандартыг) адилтган мөрдөх тохиолдолд нийгмийн халамжийн тэтгэмжийн тусгай асуудлуудын талаархи ямар нэг заавар удирдамж шаардлагатай эсэхийг УСНББОУСЗ авч хэлэлцсэн. Ялангуяа, дискаунтын хувь ба эрсдийн залруулгын талаархи СТОУС 17-гийн зохицуулалт нь нийгмийн халамжийн тэтгэмжийн хөтөлбөрийн хувьд тохиромжтой эсэхийг УСНББОУСЗ харгалзсан. СТОУС 17-г эсвэл СТОУС 17-той бараг ижил зарчим баримталдаг үндэсний стандартыг тухайн байгууллага лавлагаа болгодог зөвхөн тийм тохиолдлоор уг даатгалын хандлагын хэрэглээг хязгаарлахыг УСНББОУСЗ нь эдгээр асуудлыг авч үзэх үедээ хүлээн зөвшөөрсөн. Яагаад гэвэл, бусад стандартууд тухайлбал, СТОУС 4, *Даатгалын Гэрээ* (болон СТОУС 4-д суурилсан үндэсний стандартууд) нь хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагыг хангах ба чанарын шинжүүдийг биелүүлэх мэдээллээр хангахгүй байж болох юм.

ДҮ147. Сонгосон дискаунтын хувь нь мөнгөний цаг хугацааны үнэ цэнийг тусгахын тулд ирээдүйн мөнгөн гүйлгээг тохируулдаг байвал зохино гэдгийг СТОУС 17-гийн шаардлагуудад тусгайлан заасан. Ийм хувь хэмжээ нь даатгалын гэрээний хугацаа, валют, хөрвөх чадвартай уялдах тийм

УСНББОУС 42-НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТЭТГЭМЖ

мөнгөн гүйлгээ бүхий хэрэглүүрийн ажиглаж болох зах зээлийн үнэтэй нийцсэн байна. Дискаунтын хувь хэмжээнд хөрвөх чадварын залруулга хийгээгүй тохиолдолд эдгээр шаардлагууд нь УСНББОУС 39, *Ажилтны Тэтгэмж*-ийн шаардлагуудаас өөр байна гэдгийг УСНББОУСЗ тэмдэглэсэн.

- ДҮ148. Статистикийн тайлагнал нь ажилтны тэтгэмжийн болон нийгмийн халамжийн тэтгэмжийн тайлагналд дискаунтын тогтвортой хувь хэмжээ ашигладаг гэдгийг УСНББОУСЗ онцлон дурдсан. Статистикийн тайлагналтай нийцэхийн тулд УСНББОУС 39-д заасан, дискаунтын хувиудыг уг хандлагад мөрдөнө гэсэн үг юм.
- ДҮ149. УСНББОУСЗ нь хөрвөх чадварын залруулгын шинж төрлийг харгалзан үзсэн. Санхүүгийн зах зээл нь хөрвөх чадваргүй тохиолдолд санхүүгийн хэрэглүүрийг гаргагч нь тухайн хэрэглүүрийн хувьд арай бага үнийг хүлээн зөвшөөрөх шаардлагатай болно. Ингэснээр тэднээс зах зээлийн арай өндөр өгөөж шаардахад хүргэж болох юм. Урт хугацааны даатгалын гэрээг хөрвөх чадваргүй гэж үзэж болох юм. Нийгмийн халамжийн тэтгэмжийн нөхцлүүдийг засгийн газраас тогтоодог тохиолдолд зах зээлийн өндөр өгөөж шаардах даатгалын гэрээ эзэмшигчийн санаа зорилго ач холбогдолтой эсэхэд УСНББОУСЗ нь ЗББ-ийг боловсруулах үедээ эргэлзэж байсан.
- ДҮ150. ЗББ-ийг боловсруулж байх үедээ ийм шалтгааны улмаас УСНББОУСЗ нь даатгалын хандлагын дагуу ашиглах дискаунтын хувь хэмжээнд хөрвөх чадварын залруулгыг тусгах хэрэггүй гэсэн байр суурьтай болсон. Харин энэ үед УСНББОУСЗ нь УСНББОУС 39-д заасан, дискаунтын хувь хэмжээний хандлага тохиромжтой гэсэн байр суурийг илэрхийлсэн. ЗББ-г хариулт ирүүлсэн хүмүүс нь энэ байр суурьтай ерөнхийдөө санал нэгтэй байсан.
- ДҮ151. СТОУС 17 нь эрсдлийн залруулга ашиглахыг шаарддаг гэдгийг УСНББОУСЗ тэмдэглэсэн. Нийгмийн халамжийн тэтгэмжийн хувьд эрсдлийн залруулга тохиромжтой эсэх талаар янз бүрийн байр суурьтай байдаг гэдгийг УСНББОУСЗ нь ЗББ-ийг боловсруулах үедээ дурдсан:

6.42 Нийгмийн хамгааллын зарим хөтөлбөрийн хувьд ирээдүйн мөнгөн гүйлгээний талаархи тодорхойгүй байдал нь харьцангуй бага байдаг. Жишээ нь; хүлээн авсан нийгмийн даатгалын шимтгэл ба олгосон тэтгэмжийн аль алины түвшин харьцангуй тогтвортой гэдгийг өмнөх туршлага харуулж буй тохиолдол юм. Ийм тохиолдолд тухайн хөтөлбөртэй холбоотой уг байгууллагын өр төлбөрийн хамгийн сайн тооцооллын талаархи мэдээлэл нь санхүүгийн тайлангийн хэрэглэгчдэд хамгийн их ач холбогдолтой байж болох юм.

6.43 Нийгмийн хамгааллын өөр зарим хөтөлбөрийн хувьд ирээдүйн мөнгөн гүйлгээний талаар мэдэгдэхүйц тодорхойгүй байдалтай байж болох юм. Ийм тохиолдолд төсөөлсөн үнийн хэмжилтийн суурь ашиглах нь илүү тохиромжтой байж болно гэсэн саналыг зарим хүмүүс илэрхийлсэн. Эрсдлийн залруулгын талаархи мэдээлэл нь тухайн хөтөлбөрийг эрхлэн ажиллуулж буй байгууллагын хүлээх эрсдлийг илүү сайн үнэлэх боломжийг уг санхүүгийн тайлангийн хэрэглэгчдэд олгож болох юм гэж тэд үзсэн. Тухайн өр төлбөрийг хариуцах гуравдагч этгээд байхгүй тохиолдолд ийм төсөөлсөн үнийн хэмжилтийн суурь ашиглах нь улсын секторын хувьд тохиромжгүй гэсэн санааг өөр зарим хүмүүс илэрхийлсэн. Эрсдлийн залруулга хийх нь тухайн хөтөлбөртэй холбоотойгоор уг байгууллагын нөөцөд гаргах нэхэмжлэлийн хамгийн сайн тооцооллоос өөр тооцооллыг бий болгох үр дүнтэй гэж тэд үзэж байсан; ийм тооцоолол нь төв голч бус, иймээс үнэн зөв толилуулга чанарын шинжийг хангахгүй байж болох юм.

- ДҮ152. ЗББ-г хариулт ирүүлсэн хүмүүс нь эрсдлийн залруулгын хувьд ямар байр суурьтай байгааг УСНББОУСЗ сонирхсон. Эрсдлийн залруулгыг агуулдаггүй, гүйцэтгэлийн өртөг хэмжилтийн суурь нь нийгмийн халамжийн тэтгэмжийн хувьд хамгийн тохиромжтой хэмжилтийн суурь гэж тэдгээр хариулт ирүүлсэн хүмүүс ерөнхийдөө үзэж байсан.

УСНББОУС 42-НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТЭТГЭМЖ

- ДҮ153. Эдгээр саналууд, НББОУС3-өөс гаргасан СТОУС 17, түүнчлэн СТОУС 17-г (эсвэл үндэсний нягтлан бодох бүртгэлийн холбогдох стандартыг) адилтган мөрдөх чиглэлийг тайлан бэлтгэгч нарт өгсөн шийдвэр зэргийг харгалзан УСНББОУС3 нь ЗББ дэх өөрийн дүгнэлтийг дахин авч үзсэн.
- ДҮ154. ЗББ-т авч хэлэлцсэн байр суурь нь одоо ч хүчин төгөлдөр хэвээрээ байгаа гэдгийг УСНББОУС3 мэдэгдсэн. УСНББОУС 39-д заасан, дискаунтын хувийг мөрдөх ба эрсдлийн залруулгыг тусган оруулахгүй байх нь ерөнхий хандлагын дагуу хүлээн зөвшөөрч, хэмжсэн нийгмийн халамжийн тэтгэмжийн хөтөлбөртэй илүү сайн нийцтэй болно гэдгийг УСНББОУС3 бас хүлээн зөвшөөрсөн. Харин эсрэгээр, СТОУС 17-д заасан, дискаунтын хувийг хэвээр хадгалах ба эрсдлийн залруулгыг хийх нь тухайн санхүүгийн тайланд мэдэгдэхүйц өөр дүнгүүд тусган оруулахад хүргэж болох юм.
- ДҮ155. Түүнчлэн, төлөвлөөгүй гэнэтийн үр дагавар гаргахгүйн тулд стандартын хувьд нэлээд нухацтай албан үйл ажиллагааг зөвхөн гүйцэтгэснээр СТОУС 17-гийн шаардлагуудад нэмэлт өөрчлөлт оруулж болно гэдгийг УСНББОУС3 мэдэгдсэн. Энэ нь мэдэгдэхүйц хэмжээний нөөц зарцуулахыг шаардах бөгөөд СТОУС 17-г (эсвэл үндэсний нягтлан бодох бүртгэлийн холбогдох стандартыг) адилтган мөрдөх чиглэлийг тайлан бэлтгэгч нарт өгөх УСНББОУС3-ийн санаа зорилгыг үгүйсгэх юм (дээрх ДҮ145-р параграфыг үзнэ үү).
- ДҮ156. Дискаунтын хувь хэмжээний мөрдөлтийн тууштай бус байдал нь өргөн хүрээтэй асуудал бөгөөд стандарт тогтоогч олон байгууллагууд, үүн дотроо НББОУС3 нь энэ талаар ажиллаж байгаа гэдгийг УСНББОУС3 мөн мэдэгдсэн.
- ДҮ157. Эцэст нь, УСНББОУС3 даатгалын хандлага бол шаардлага биш, харин сонголттой мөрдөж болно гэдгийг цохон тэмдэглэсэн (хэдийгээр дээрх ДҮ132-р параграфт ингэж дурдсан боловч хожим үүнийг дахин авч үзэж болох юм). Дискаунтын янз бүрийн хувь хэмжээ ашиглах нь асуудалтай гэж үздэг байгууллага нь ерөнхий хандлагыг мөрдсөнөөр өөрийн бүх нийгмийн халамжийн тэтгэмжийн хөтөлбөрүүдийг тайлагнах сонголт хийж болно.
- ДҮ158. Эдгээр шалтгааны улмаас УСНББОУС3 нь СТОУС 17-г нийгмийн халамжийн тэтгэмжийн хөтөлбөрүүдэд адилтган мөрдөх тохиолдолд уг Стандартын шаардлагуудад нэмэлт өөрчлөлт оруулахгүй байхыг СТ 63-аар зөвшөөрсөн.
- СТ 63, *Нийгмийн Халамжийн Тэтгэмж*-д ирүүлсэн хариултууд
- ДҮ159. Хариулт ирүүлсэн хүмүүс нь СТОУС 17-г эсвэл СТОУС 17-той бараг ижил зарчим баримталдаг үндэсний стандартуудыг мөрдөх чиглэлийг тайлан бэлтгэгч нарт өгөх УСНББОУС3-ийн саналыг ерөнхийдөө хүлээн зөвшөөрсөн.
- ДҮ160. Гэвч хариулт ирүүлсэн цөөн хүмүүс нь даатгалын хандлагыг нийгмийн халамжийн тэтгэмжүүдэд мөрдөх талаархи нэмэлт заавар удирдамж ач холбогдолтой гэж үзэж байсан. Тухайлбал, арилжааны даатгалын гэрээний дискаунтын хувь хэмжээ, эрсдлийн залруулгаас өөр байж болох учраас нийгмийн халамжийн тэтгэмжүүдийн дискаунтын хувь хэмжээ болон эрсдлийн залруулгын талаархи заавар удирдамжаар УСНББОУС3 хангах хэрэгтэй гэсэн саналыг тэдгээр хариул ирүүлсэн хүмүүс илэрхийлсэн.
- ДҮ161. Нийгмийн халамжийн тэтгэмжүүдийн дискаунтын хувь хэмжээ болон эрсдлийн залруулгын талаархи заавар удирдамжаар хангах нь тайлан бэлтгэгч нар даатгалын хандлагыг мөрдөхөд туслалцаа үзүүлж болох юм гэдгийг УСНББОУС3 хүлээн зөвшөөрсөн. Гэвч дээрх ДҮ154-ДҮ158-р параграфт дурдсан, учир шалтгааны улмаас УСНББОУС3 нь СТОУС 17-г нийгмийн халамжийн тэтгэмжийн хөтөлбөрүүдэд адилтган мөрдөх тохиолдолд уг Стандартын шаардлагуудад нэмэлт өөрчлөлт оруулахгүй байхыг зөвшөөрсөн.
- ДҮ162. Байгууллагууд нь дискаунтын хувь хэмжээ болон эрсдлийн залруулгатай холбоотой шаардлагуудыг анхааралтай авч үзэх шаардлагатай гэдгийг УСНББОУС3 тэмдэглэсэн. Тухайлбал, эрсдлийн залруулга нь байгууллагын тусгайлсан залруулга бөгөөд байгууллагууд

УСНББОУС 42-НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТЭТГЭМЖ

нь эрсдлийн залруулгыг тодорхойлохдоо өөрийн өвөрмөц нөхцөл байдлыг харгалзах шаардлагатай юм.

ДҮ163. Зарим үндэсний стандарт тогтоогчид нь дискаунтын хувь хэмжээ болон эрсдлийн залруулгатай холбоотой СТОУС 17 (эсвэл даатгалын үндэсний стандарт)-ын шаардлагуудыг нийгмийн халамжийн тэтгэмжүүд болон улсын секторын ижил төсөөтэй тусгай ажил гүйлгээнүүдэд хэрхэн мөрдөхийг харгалзан үзнэ гэдгийг УСНББОУСЗ бас тэмдэглэсэн. Ийм заавар удирдамжийг гармагц байгууллагууд нь түүнийг мөрдөх хэрэгтэй гэж УСНББОУСЗ үзсэн.

Хэрэгжүүлэх заавар удирдамж

Энэхүү хэрэгжүүлэх заавар удирдамж нь УСНББОУС 42-ыг дагалдах боловч түүний салиггүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.

ХЗУ1. Энэхүү Хэрэгжүүлэх Заавар Удирдамж нь УСНББОУС 42-ын шаардлагуудын зарим төлөв байдлыг үлгэрчлэн харуулах явдал юм.

УСНББОУС 42-ын цар хүрээ

ХЗУ2. УСНББОУС 42-ын цар хүрээ, нийгмийн халамжийн тэтгэмж ба бусад ажил гүйлгээний хоорондох хил заагийг дараах диаграммд үлгэрчлэн харуулсан.

УСНББОУС 42-НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТЭТГЭМЖ

Арилжааны бус зардлын төсөл

Нийгмийн халамжийн тэтгэмж

Бусад УСНББОУС/СТОУС

Ангилал	Буцалтгүй тусламж, Нийгмийн даатгалын шимтгэл ба Бусад шилжүүлэг	Яаралтай тусламж	Хамтын үйлчилгээ	Хувийн үйлчилгээ	Нийгмийн халамжийн тэтгэмж	Ажилтны тэтгэмж	Даатгалын гэрээ	Бараа, үйлчилгээн ий гэрээ
Жишээ	Улсын секторын бусад байгууллагад олгох буцалтгүй тусламж, Буяны байгууллагад олгох буцалтгүй тусламж	Яаралтай тусламж, Төлөвлөлт ба бэлтгэл ажиллагаа	Батлан хамгаалах, Гудамжны гэрэлтүүлэг	Боловсрол, Эрүүл мэнд	Улсын тэтгэвэр, Ажилгүйдлийн тэтгэмж, Орлогын дэмжлэг	Ажилтны тэтгэвэр, Эрүүл мэнд, Цалин хөлс	Автомашинны даатгал, Хувийн эрүүл мэндийн даатгал	Барааны худалдан авалт, Үйлчилгээний төлбөр
Арилжааны эсвэл арилжааны бус эсэх?	Хоёулаа	Арилжааны бус	Арилжааны бус	Арилжааны бус	Арилжааны бус	Арилжааны	Арилжааны	Арилжааны
Тодорхой хувь хүн/айл өрхөд мөнгөн шилжүүлэг байдлаар олгох	Зарим үед	Зарим үед	Үгүй	Үгүй	Тийм	Зарим үед	Үгүй	Үгүй
Зохих шалгуурыг хангадаг тодорхой хувь хүн/айл өрхөд олгох уу?	Зарим үед	Зарим үед	Үгүй	Зарим үед	Тийм	Тийм	Үгүй	Үгүй
Нийгмийн эрсдлийн үр нөлөөг бууруулах уу?	Үгүй	Үгүй	Үгүй	Зарим үед	Тийм	Тийм	Үгүй	Үгүй
Бүхэлдээ нийгмийн хэрэгцээ шаардлагыг харгалзан үзэх үү?	Зарим үед	Үгүй	Тийм	Тийм	Тийм	Үгүй	Үгүй	Үгүй

ЗГСС дахь нийгмийн халамжийн цар хүрээ

УСНББОУС 42-НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТЭТГЭМЖ

УСНББОУС 42 дахь өр төлбөрийн болон зардлын хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт

- ХЗУ3. **Тэтгэвэрт гарсны дараах тэтгэврийг сар бүр төлдөг тохиолдолд тухайн тайлангийн өдрөөрх өр төлбөр нь дараагийн сард төлөх дүнтэй ижил байдаг уу?**
- ХЗУ4. Тухайн тайлангийн өдрөөрх өр төлбөр нь дараагийн сард төлсөн дүнтэй яг ижил байх магадлал багатай юм. Зөрүүгийн хэмжээ нь тэтгэвэрт гарах үеийн тэтгэмжийн нөхцөл байдлаас хамаардаг. Зөрүүгийн хэмжээнд нөлөөлөх хүчин зүйлсэд дараах зүйлс хамаарна:
- (а) Цаг хугацааны зөрүү. Тайлангийн өдрийн дараагийн сарын төлбөр нь тухайн тайлангийн өдрөөрх өр төлбөрийн нэг хэсэг болохгүй тийм төлбөрүүдийг агуулсан байж болох юм. Жишээлбэл; байгууллага нь өөрийн санхүүгийн тайланг 12 дугаар сарын 31-ний байдлаар бэлтгэдэг. Хэрэв тэтгэврийн тэтгэмжийг сар бүрийн 15-нд төлдөг бол 01-р сарын 15-нд төлөх төлбөр нь 01-р сарын 01-ээс 01-р сарын 15-ны хоорондох хугацаанд тэтгэврийн насанд хүрсэн хувь хүмүүст төлөх төлбөрүүдийг агуулсан байж болно. 12-р сарын 31-ний байдлаар тэдгээр хувь хүмүүс нь тэтгэвэрт гарсны дараах тэтгэврийг авах шалгуурыг хангаагүй байсан тул тэдэнд төлөх төлбөр нь 12-р сарын 31-нээрх өр төлбөрийн нэг хэсгийг бүрдүүлэхгүй.
 - (б) Бүрэн бус мэдээлэл. Төлбөрийг тооцоолоход ашигладаг мэдээлэл нь бүрэн бус байж болно, үүний улмаас дараагийн сарын төлбөр нь тухайн тайлангийн өдрөөрх өр төлбөртэй яг тэнцүү биш байж болох юм. Жишээлбэл; төлбөр хийгдэхээс өмнөх өдрийн тоогоор төлбөрийг ихэвчлэн тооцоолдог. Тухайн өдрөөс хойш мэдэгдсэн нөхцөл байдлын өөрчлөлтүүдийг уг төлбөрт тусгахгүй, харин дараагийн тайлант үеүдэд залруулдаг.
- ХЗУ5. Тухайн тайлангийн өдрөөрх өр төлбөр хүлээн зөвшөөрөх эсэхийг авч үзэх үедээ байгууллага нь УСНББОУС 3, *Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлого*, *Нягтлан Бодох Бүртгэлийн Тооцооллын Өөрчлөлт ба Алдаа*-нд дурдсан, материаллаг байдлын хэлэлцүүлгийг лавлагаа болгох нь ач тустай гэж үзэж болох юм.
- ХЗУ6. **Нийгмийн халамжийн тэтгэмжийн хөтөлбөрийн зохих шалгуур хангалтын тасалдал нь өр төлбөрийн хүлээн зөвшөөрөлт ба хэмжилтэнд хэрхэн нөлөөлөх вэ?**
- ХЗУ7. Тасралтгүй ханган биелүүлэх зохих (амьд мэнд эсэх нь зохих шалгуур байх тохиолдолд түүнээс бусад) шалгууртай нийгмийн халамжийн тэтгэмжийн хөтөлбөрийн хувьд хувь хүн нь нийгмийн халамжийн тэтгэмжийн дараагийн төлбөрийг авах зохих шалгуурыг хангах тайлант үеүд болон уг зохих шалгуурыг хангахгүй тайлант үеүд ээлжлэн солигддог байж болно. Ийм нөхцөл байдалд тэрхүү зохих шалгуурыг хангах хувь хүний тохиолдол нэг бүрийг тусад нь хүлээн зөвшөөрч, хэмжинэ.
- ХЗУ8. Жишээлбэл; байгууллага нь өөрийн санхүүгийн тайланг 12 дугаар сарын 31-ний байдлаар бэлтгэдэг. Тухайн өдрийн байдлаар хувь хүн нь ажилгүй болсон ба ажилгүйдлийн тэтгэмж авах шалгуурыг хангаж байсан. Иймээс байгууллага нь тухайн тайлангийн өдрийн байдлаар тэрхүү хувь хүнд одоогийн үүрэгтэй болно. Уг хувь хүн нь 01-р сарын 10-нд түр ажилд орсноор ажилгүйдлийн тэтгэмж авах шалгуурыг хангаах больсон. Энэхүү ажил эрхлэлт 01-р сарын 24-нд дуусмагц тухайн хувь хүн нь ажилгүйдлийн тэтгэмж авах шалгуурыг дахин хангахаар болсон. Дараагийн тайлант үеийн хувьд зохих шалгуур нь тэрхүү тайлангийн өдөр өнгөрөх хүртэл хангагдахгүй тул ажилгүйдлийн зөвхөн эхний хугацаа нь тухайн тайлангийн өдрөөрх өр төлбөрт хамаарна.

Үлгэрчилсэн жишээ

Энэхүү үлгэрчилсэн жишээ нь УСНББОУС 42-ыг дагалдах боловч түүний салиггүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.

Цар хүрээ ба тодорхойлолт

УСНББОУС 42-ын 3-5-р параграф болон МЗУ1-МЗУ10-р параграфыг мөрдсөний үр дагаврыг үлгэрчлэн харуулах

ҮЖ1. Ажил гүйлгээ нь УСНББОУС 42, *Нийгмийн Халамжийн Тэтгэмж*-ийн цар хүрээнд хамаарах эсэхийг тодорхойлох үйл явцыг дараах хувилбаруудад үлгэрчлэн харуулав. Эдгээр хувилбарууд нь таамагласан нөхцөл байдлыг тусгасан. Хувилбаруудын зарим төлөв байдал нь бодит тохиолдлыг илэрхийлж болох боловч УСНББОУС 42-ыг мөрдөхдөө тухайн тохиолдлын бүх баримт материал болон нөхцөл байдлыг үнэлэх шаардлагатай юм.

Жишээ 1-Төрийн албан хаагчдад тэтгэвэрт гарсны дараа олгох тэтгэмж

ҮЖ2. А орон нутгийн ажилтнууд нь 65 нас хүрмэгц Хөдөлмөрийн гэрээний дагуу тэтгэвэрт гарсны дараах тэтгэмж авах эрхтэй болдог. Ажил эрхэлж байх үедээ ажилтнууд нь өөрсдийн цалингийн тодорхой хувийн жингээр нийгмийн даатгалын шимтгэл төлөх шаардлагатай байдаг. Тэтгэвэрт гарсны дараа олгох тэтгэмж нь тухайн ажилтны эцсийн цалин ба ажилласан жилээс хамаардаг.

ҮЖ3. Тэтгэвэрт гарсны дараах тэтгэмж нь зохих шалгуурыг хангасан, тодорхой хувь хүмүүст олгох мөнгөн шилжүүлэг байдаг. Тэтгэвэрт гарсны дараах тэтгэмж нь нийгмийн эрсдлүүдийг бууруулах, ингэснээр тэтгэврийн насанд хүрэх үедээ ажилтнууд хангалттай орлоготой байх эсэхийг ханган магадлах санаа зорилготой юм.

ҮЖ4. Гэхдээ уг тэтгэвэрт гарсны дараах тэтгэмжийг зөвхөн А орон нутгийн хуучин ажилтнуудад олгох боломжтой учраас нийгмийн хэрэгцээ шаардлагыг бүхэлд нь харгалзан үздэггүй. Тэтгэвэрт гарсны дараах тэтгэмжийг ажил эрхлэлтийн үйлчилгээний нөхөн төлбөр байдлаар олгодог. Иймээс тэтгэвэрт гарсны дараах тэтгэмж нь нийгмийн халамжийн тэтгэмжийн тодорхойлолтын элементүүдийг бүрэн хангадаггүй гэж дүгнэж болно. Үүний улмаас тэтгэвэрт гарсны дараах тэтгэмж нь УСНББОУС 42-ын цар хүрээнд хамаардаггүй. Тэтгэвэрт гарсны дараах тэтгэмж нь ажилтны тэтгэмж бөгөөд түүнийг УСНББОУС 39, *Ажилтны Тэтгэмж*-ийн дагуу тайлагнадаг.

Жишээ 2-Тэтгэвэрт гарсны дараах улсын тэтгэвэр

ҮЖ5. Тэтгэврийн 65 насанд хүрсэн бүх иргэд болон оршин суугчиддаа Б засгийн газар нь тэтгэвэрт гарсны дараах улсын тэтгэврийн доод хэмжээг төлдөг. Тэтгэвэрт гарсны дараах улсын тэтгэврийг хууль тогтоомжоор зохицуулдаг. Ажил эрхэлж байх хугацаандаа хувь хүмүүс нь өөрсдийн цалингийн дүнд үндэслэн нийгмийн даатгалын шимтгэл төлөх шаардлагатай байдаг. Гэвч төлсөн нийгмийн даатгалын шимтгэлийн дүнгээс үл хамааран уг тэтгэвэрт гарсны дараах улсын тэтгэврийг тэтгэвэр авагч бүрд ижил дүнгээр олгодог.

ҮЖ6. Тэтгэвэрт гарсны дараах тэтгэмжийг зохих шалгуурыг хангасан, тодорхой хувь хүмүүст мөнгөн шилжүүлэг байдлаар олгодог. Тэтгэвэрт гарсны дараах тэтгэмж нь нийгмийн эрсдлүүдийг бууруулах, ингэснээр тэтгэврийн насанд хүрэх үедээ хувь хүмүүс болон айл өрх нь хангалттай орлоготой байх эсэхийг ханган магадлах санаа зорилготой юм.

ҮЖ7. Уг тэтгэвэрт гарсны дараах тэтгэмж нь бүхэлдээ нийгмийн хэрэгцээ шаардлагыг харгалзан үздэг. УСНББОУС 42-ын МЗУ7-р параграфт “нийгмийн эрсдлийн үр нөлөөг бууруулахын тулд тэтгэмж олгож буй эсэх үнэлгээг тухайн нийгмийг бүхэлд нь харгалзан лавлагаа болгосноор хийдэг; тэтгэмж нь түүнийг хүлээн авагч нэг бүрийн хувьд нийгмийн эрсдлийн үр нөлөөг бууруулах албагүй юм. Жишээлбэл; тэтгэвэрт гарсны дараа орлого нь хүрэлцээгүй тийм

УСНББОУС 42-НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТЭТГЭМЖ

хүмүүсийн хэрэгцээг хангахын тулд засгийн газар нь орлого, хөрөнгө чинээнээс үл хамааран тодорхой наснаас дээш насны бүх хүмүүст тэтгэврийн тэтгэмж олгодог” гэж заасан.

ҮЖ8. Иймээс тэтгэвэрт гарсны дараах улсын тэтгэвэр нь УСНББОУС 42-ын цар хүрээнд хамаарна.

Жишээ 3-Эрүүл мэндийн нийтлэг үйлчилгээ

ҮЖ9. В засгийн газар нь өөрийн бүх иргэд, түүнчлэн оршин суух шаардлагыг хангасан бусад хувь хүмүүст эрүүл мэндийн суурь үйлчилгээг үзүүлдэг. Эрүүл мэндийн үйлчилгээг тухайн хүргэлтийн цэг дээр үнэ төлбөргүй үзүүлдэг.

ҮЖ10. Эрүүл мэндийн үйлчилгээг зохих шалгуурыг хангасан, тодорхой хувь хүмүүст үзүүлдэг. Эрүүл мэндийн үйлчилгээ нь нийгмийн эрсдлүүдийг бууруулах, ингэснээр өвчтэй хүмүүс нь хувь хүмүүс болон айл өрхийн ахуй амьдралд сөргөөр нөлөөлөхгүй гэдгийг ханган магадлах санаа зорилготой юм. Үүний тулд эрүүл мэндийн үйлчилгээ нь нийгмийн хэрэгцээ шаардлагыг бүхэлд нь харгалзан үздэг.

ҮЖ11. Гэхдээ В засгийн газар нь мөнгөн шилжүүлэг олгохгүй, харин үйлчилгээг үзүүлдэг. Иймээс эрүүл мэндийн үйлчилгээ нь УСНББОУС 42-ын цар хүрээнд хамаарахгүй юм.

Жишээ 4-Тахир дутуугийн тэтгэвэр

ҮЖ12. Г мужийн засгийн газар нь наснаас үл хамааран ажил, хөдөлмөр эрхлэх боломжгүй, хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан хувь хүмүүст тахир дутуугийн тэтгэвэр олгодог. Хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан ба хөдөлмөрийн чадвар алдалт нь тухай хувь хүн цалинтай ажил, хөдөлмөр эрхлэх боломжгүй болгосон гэдгийг эмнэлгийн үзлэг шалгалтаар магадлан баталгаажуулсны дараа л тахир дутуугийн тэтгэврийг олгодог. Тахир дутуугийн тэтгэврийн хэмжээ нь тухайн хувь хүнээс хамаарах бөгөөд үндсэн хэрэгцээ шаардлагыг хангаж, зохих тусламж, үйлчилгээний төлбөрийг төлөх боломжийг уг хувь хүнд олгох зорилготой байдаг.

ҮЖ13. Тахир дутуугийн тэтгэврийг зохих шалгуурыг хангасан, тодорхой хувь хүмүүст мөнгөн шилжүүлэг байдлаар олгодог. Тахир дутуугийн тэтгэвэр нь эрүүл мэндэд муугаар нөлөөлж буй нийгмийн эрсдлийг бууруулах, ингэснээр тахир дутуу байдал нь хувь хүмүүс болон айл өрхийн ахуй амьдралд сөргөөр нөлөөлөхгүй гэдгийг ханган магадлах санаа зорилготой юм. Үүний тулд тахир дутуугийн тэтгэвэр нь нийгмийн хэрэгцээ шаардлагыг бүхэлд нь харгалзан үздэг.

ҮЖ14. Иймээс тахир дутуугийн тэтгэвэр нь УСНББОУС 42-ын цар хүрээнд хамаарна.

Жишээ 5-Ажилгүйдлийн тэтгэмж

ҮЖ15. Д орон нутаг нь тухайн орон нутагт оршин суудаг ба ажилгүй болсон хувь хүмүүст ажилгүйдлийн тэтгэмж олгодог. Ажилгүйдлийн тэтгэмжийг хамгийн уртдаа нэг жилийн хугацаанд олгодог бөгөөд ажилгүйдлийн тэтгэмжийг төлөхөөс өмнө хоёр долоо хоногийн ‘хүлээх хугацаа’-тай байдаг.

ҮЖ16. Ажилгүйдлийн тэтгэмжийг зохих шалгуурыг хангасан, тодорхой хувь хүмүүст мөнгөн шилжүүлэг байдлаар олгодог. Ажилгүйдлийн тэтгэмж нь нийгмийн эрсдлүүдийг бууруулах, ингэснээр ажилгүй үедээ хувь хүмүүс болон айл өрх нь хангалттай орлоготой байх эсэхийг ханган магадлах санаа зорилготой юм. Үүний тулд ажилгүйдлийн тэтгэмж нь нийгмийн хэрэгцээ шаардлагыг бүхэлд нь харгалзан үздэг.

ҮЖ17. Иймээс ажилгүйдлийн тэтгэмж нь УСНББОУС 42-ын цар хүрээнд хамаарна.

УСНББОУС 42-НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТЭТГЭМЖ

Жишээ 6-Яаралтай тусламж

- ҮЖ18. Бүс нутагт их хэмжээний хохирол учруулсан газар хөдлөлтийн дараа Е засгийн газар нь сэргээн босголтын ажилд туслах, газар хөдлөлтөд нэрвэгдсэн хүмүүст түр оршин суух байр олгох зэрэг яаралтай тусламжийг үзүүлдэг.
- ҮЖ19. Зарим өртөг зардал нь зохих шалгуурыг хангасан, тодорхой хувь хүмүүст мөнгөн шилжүүлэг байдлаар олгох тэтгэмжтэй холбоотой байна. Бусад зардал нь хөрөнгө ба үйлчилгээтэй, тухайлбал газар хөдлөлтөөр эвдэрсэн авто замын сэргээн засварлалттай холбоотой байна.
- ҮЖ20. Авто замын сэргээн засварлалт эсвэл тодорхой хувь хүмүүст үзүүлэх үйлчилгээ гэх мэт хөрөнгийн зарлага нь мөнгөн шилжүүлэг биш, иймээс УСНББОУС 42-ын цар хүрээнд хамаарахгүй юм.
- ҮЖ21. Мөнгөн шилжүүлэг байдлаар үзүүлэх яаралтай тусламж нь нийгмийн эрсдлийн үр нөлөөг бууруулахгүй, харин газар зүйн эрсдлийн, өөрөөр хэлбэл газар хөдлөлтийн эрсдлийн үр нөлөөг бууруулах юм. Хувь хүмүүс ба/буюу айл өрхийн шинж байдалтай холбоогүй, тухайлбал; газар хөдлөлт эсвэл үер усны эрсдэл гэх мэт газар зүйн буюу уур амьсгалын шинж чанартай холбоотой эрсдэл нь нийгмийн эрсдэл биш гэдгийг УСНББОУС 42-ын МЗУ10-р параграфт тайлбарласан. Иймээс яаралтай тусламж нь УСНББОУС 42-ын цар хүрээнд хамаарахгүй юм.
- ҮЖ22. Байгалийн гамшгийн дараа, хувь хүмүүс ба/буюу айл өрх нь бусад тэтгэмжийн жишээлбэл, ажилгүйдлийн тэтгэмжийн шалгуурыг хангаж болох юм. Хэрэв нийгмийн халамжийн тэтгэмжийн тодорхойлолтыг (үүн дотроо, энэ нь мөнгөн шилжүүлэг байх ба нийгмийн эрсдлийг бууруулах гэсэн шаардлагыг) хангавал ийм тэтгэмж нь нийгмийн халамжийн тэтгэмж болж болох юм.

Жишээ 7-Батлан хамгаалах

- ҮЖ23. Ж засгийн газар нь улс орноо батлан хамгаалахын тулд арми, тэнгисийн цэрэг, нисэх хүчнийг бүрдүүлж, бэлэн байлгадаг.
- ҮЖ24. Эдгээр батлан хамгаалах үйлчилгээ нь зохих шалгуурыг хангасан, тодорхой хувь хүмүүст олгодог мөнгөн шилжүүлэг биш боловч дараах утга агуулгатай хамтын үйлчилгээ юм:
- (а) Энэхүү үйлчилгээг тухайн нийгэм буюу нийгмийн хэсгийн гишүүн бүрд нэгэн зэрэг хүргэн үзүүлдэг; ба
 - (б) Хувь хүмүүсийг тухайн хамтын бараа, үйлчилгээний өгөөжөөс хасаж, хүртүүлэхгүй байх боломжгүй.
- ҮЖ25. Иймээс батлан хамгаалах үйлчилгээ нь УСНББОУС 42-ын цар хүрээнд хамаарахгүй юм.

Ерөнхий хандлага: Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт

УСНББОУС 42-ын 6-21-р параграф болон МЗУ11-МЗУ18-р параграфыг мөрдсөний үр дагаврыг үлгэрчлэн харуулах

Жишээ 8

- ҮЖ26. Тэтгэвэрт гарсны дараах тэтгэврийн хувьд өр төлбөр ба зардлыг хүлээн зөвшөөрч, хэмжих үйл явцыг дараах жишээнд үлгэрчлэн харуулав. Энэхүү жишээ нь бодит ажил гүйлгээнд үндэслээгүй болно.
- ҮЖ27. И засгийн газар нь өөрийн иргэд болон байнгын оршин суугчдад тэтгэвэрт гарсны дараах тэтгэврийг олгодог. Тухайн тэтгэврийн хөтөлбөр нь тэтгэврийн 65 насанд хүрсэн хүн бүрд сар болгон тогтмол 250 ТН төлдөг. Зохих шалгуурыг өмнөх сарын эцсийн байдлаар бүрэн хангаж буй хүмүүст энэхүү дүнг бүтнээр нь төлдөг.

УСНББОУС 42-НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТЭТГЭМЖ

ҮЖ28. И засгийн газар нь өөрийн санхүүгийн тайланг 12 дугаар сарын 31-ний байдлаар бэлтгэдэг. Тэтгэвэрт гарсны дараах тэтгэврийг сар бүрийн эцэст төлдөг.

ҮЖ29. 20X1 оны 12-р сарын 31-ний байдлаар И засгийн газар нь тэтгэвэрт гарсны дараах тэтгэврийн хувьд 1,950,500 ТН-ийн өр төлбөрийг хүлээн зөвшөөрсөн. 20X2 онд И засгийн газар нь тэтгэвэрт гарсны дараах тэтгэврийг доорх байдлаар төлсөн:

Сар	Төлсөн тэтгэвэр (ТН)
20X2 оны 01-р сар	1,950,500
20X2 оны 02-12-р сар	22,258,000
Нийт дүн	24,208,500

ҮЖ30. 20X3 оны 01-р сард И засгийн газар нь нийт 2,095,750 ТН-ийн тэтгэвэрт гарсны дараах тэтгэврийг төлсөн.

ҮЖ31. 20X2 оны 12-р сарын 31-нд И засгийн газар нь тухайн өдрийн байдлаар зохих шалгуурыг хангасан хувь хүмүүст төлөх тэтгэвэрт гарсны дараах тэтгэврийн өглөгийн хувьд өр төлбөрийг хүлээн зөвшөөрсөн. Үүний үр дүнд И засгийн газар нь 2,095,750 ТН-ийн өр төлбөр хүлээн зөвшөөрсөн ба уг тэтгэвэрт гарсны дараах тэтгэврийг 01-р сард бүтэн дүнгээр төлсөн.

ҮЖ32. 20X2 онд зардал гэж хүлээн зөвшөөрсөн нийт дүн 24,353,750 ТН байна. Энэхүү дүнгийн задаргааг доор харуулав:

	ТН
20X2 оны 02-р сараас (20X2 оны 01-р сард хүлээн зөвшөөрсөн) 20X2 оны 12-р сарын (20X2 оны 11-р сард хүлээн зөвшөөрсөн) хооронд төлсөн тэтгэвэр	22,258,000
20X3 оны 01-р сард (20X2 оны 12-р сард хүлээн зөвшөөрсөн) төлсөн тэтгэвэр	2,095,750
Нийт дүн	24,353,750

Жишээ 9

ҮЖ33. Тэтгэвэрт гарсны дараах тэтгэврийн хувьд өр төлбөр ба зардлыг хүлээн зөвшөөрч, хэмжих үйл явцыг дараах жишээнд үлгэрчлэн харуулав. Энэхүү жишээ нь бодит ажил гүйлгээнд үндэслээгүй болно.

ҮЖ34. К засгийн газар нь өөрийн иргэд болон байнгын оршин суугчдад тэтгэвэрт гарсны дараах тэтгэврийг олгодог. Тухайн тэтгэврийн хөтөлбөр нь тэтгэврийн 70 насанд хүрсэн хүн бүрд сар болгон тогтмол 100 ТН төлдөг (төлөх үүрэгтэй). Хувь хүн нь тэтгэврийн насанд хүрсэн сард болон нас барсан сард дүнг хувь тэнцүүлэн тооцоолдог.

ҮЖ35. К засгийн газар нь өөрийн санхүүгийн тайланг 12 дугаар сарын 31-ний байдлаар бэлтгэдэг. Тэтгэвэрт гарсны дараах тэтгэврийг сар бүрийн эцэст төлдөг.

ҮЖ36. 20X7 оны 12-р сарын 31-ний байдлаар К засгийн газар нь тэтгэвэрт гарсны дараах тэтгэврийн хувьд 2,990,656 ТН-ийн өр төлбөрийг хүлээн зөвшөөрсөн. 20X8 онд К засгийн газар нь тэтгэвэрт гарсны дараах тэтгэврийг доорх байдлаар төлсөн:

Сар	Төлсөн тэтгэвэр (ТН)
20X8 оны 01-р сар	3,024,997
20X8 оны 02-12-р сар	33,435,183
Нийт дүн	36,460,180

УСНББОУС 42-НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТЭТГЭМЖ

ҮЖ37. Энэ жишээнд К засгийн газар нь тэтгэвэрт гарсны дараах тэтгэврийг төлөх өдрөөр иж бүрэн мэдээлэлтэй байсан гэж үзсэн. Иймээс 20X8 оны 01-р сард төлсөн дүн (3,024,997ТН) ба 20X7 оны 12-р сарын 31-ний байдлаар хүлээн зөвшөөрсөн өр төлбөр (2,990,656ТН) хоорондох зөрүү нь 20X8 оны 01-р сард тэтгэврийн насанд хүрсэн хүмүүст төлсөн, тэтгэвэрт гарсны дараах хувь тэнцүүлэн тооцсон тэтгэврийн дүнг (34,341ТН) илэрхийлнэ.

ҮЖ38. 20X9 оны 01-р сарын 31-д К засгийн газар нь нийт 3,053,576 ТН-ийн тэтгэвэрт гарсны дараах тэтгэврийг төлсөн. Энэхүү төлбөр нь дараах гурван бүрэлдэхүүнтэй байв:

	ТН
20X8 оны 12-р сарын 31-нээр шалгуур хангаж байсан бөгөөд 20X9 оны 01-р сарын 31-нээр шалгуур хангасан хэвээр байгаа тэтгэвэр авагчдад төлсөн бүрэн тэтгэвэр	2,979,600
20X8 оны 12-р сарын 31-нээр шалгуур хангаж байсан боловч 20X9 оны 01-р сард нас барсан тэтгэвэр авагчдад төлсөн, хувь тэнцүүлэн тооцсон тэтгэвэр	36,420
20X9 оны 01-р сард тэтгэврийн насанд хүрсэн тэтгэвэр авагчдад төлсөн, хувь тэнцүүлэн тооцсон тэтгэвэр	37,556
Нийт дүн	3,053,576

ҮЖ39. 20X8 оны 12-р сарын 31-нд К засгийн газар нь тухайн өдрийн байдлаар зохих шалгуурыг хангасан хувь хүмүүст төлөх тэтгэвэрт гарсны дараах тэтгэврийн өглөгийн хувьд өр төлбөрийг хүлээн зөвшөөрсөн. 20X9 оны 01-р сарын тэтгэврийг төлсний дараа, өөрийн 20X8 оны санхүүгийн тайланг бэлтгэж гаргасан учраас К засгийн газар нь тухайн санхүүгийн тайланг бэлтгэх үед бэлэн боломжтой болсон мэдээллийг ашигласан.

ҮЖ40. Иймээс К засгийн газар нь 3,016,020 ТН-ийн өр төлбөрийг хүлээн зөвшөөрсөн. Энэ нь 20X8 оны 12-р сарын 31-нээр шалгуур хангаж байсан бөгөөд 20X9 оны 01-р сарын 31-нээр шалгуур хангасан хэвээр байгаа тэтгэвэр авагчдад төлсөн бүрэн тэтгэвэр (2,979,600 ТН), түүнчлэн 20X8 оны 12-р сарын 31-нээр шалгуур хангаж байсан боловч 20X9 оны 01-р сард нас барсан тэтгэвэр авагчдад төлсөн, хувь тэнцүүлэн тооцсон тэтгэвэр (36,420 ТН)-ээс бүрдэнэ. 20X9 оны 01-р сард тэтгэврийн насанд хүрсэн тэтгэвэр авагчид нь 20X8 оны 12-р сарын 31-нээр зохих шалгуурыг хангаагүй байсан учраас тэдэнд төлсөн, хувь тэнцүүлэн тооцсон тэтгэвэр нь энэхүү өр төлбөрийн дүнд тусгагдаагүй болно.

ҮЖ41. 20X8 онд зардал гэж хүлээн зөвшөөрсөн нийт дүн 36,485,544 ТН байна. Энэхүү дүнгийн задаргааг доор харуулав:

	ТН
20X8 оны 01-р сард тэтгэврийн насанд хүрсэн тэтгэвэр авагчдад төлсөн (20X8 оны 01-р сард хүлээн зөвшөөрсөн), хувь тэнцүүлэн тооцсон тэтгэвэр	34,341
20X8 оны 01-р сарын 01-нээс 20X8 оны 12-р сарын 31 дуусталх санхүүгийн жилд хүлээн зөвшөөрч, 20X8 оны 02-р сараас 20X8 оны 12-р сарын хооронд төлсөн тэтгэвэр	33,435,183
20X8 оны 12-р сарын 31-нээр шалгуур хангаж байсан бөгөөд 20X9 оны 01-р сарын 31-нээр шалгуур хангасан хэвээр байгаа тэтгэвэр авагчдад төлсөн (20X8 оны 12-р сард хүлээн зөвшөөрсөн), бүрэн тэтгэвэр	2,979,600
20X8 оны 12-р сарын 31-нээр шалгуур хангаж байсан боловч 20X9 оны 01-р сард нас барсан тэтгэвэр авагчдад төлсөн (20X8 оны 12-р сард хүлээн зөвшөөрсөн), хувь тэнцүүлэн тооцсон тэтгэвэр	36,420
Нийт дүн	36,485,544

УСНББОУС 42-НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТЭТГЭМЖ

Жишээ 10

- ҮЖ42. Ажилгүйдлийн тэтгэмжийн хувьд өр төлбөр ба зардлыг хүлээн зөвшөөрч, хэмжих үйл явцыг дараах жишээнд үлгэрчлэн харуулав. Энэхүү жишээ нь бодит ажил гүйлгээнд үндэслээгүй болно.
- ҮЖ43. Л засгийн газар нь өөрийн иргэд болон байнгын оршин суугчдад ажилгүйдлийн тэтгэмж олгодог. Ажилгүйдлийн тэтгэмжийн хөтөлбөр нь тухайн хувь хүний өмнөх сарын цалингийн 50 хувьтай тэнцүү боловч сард хамгийн ихдээ 500 ТН-ийн тэтгэмжийг сар бүр төлдөг. Түүнчлэн, ажилгүйдлийн тэтгэмжийг хамгийн уртдаа 18 сарын хугацаанд олгодог. Тэтгэмж авах эрхтэй болохын тулд хувь хүн нь сүүлийн 12 сарын хугацаанд тус Мужид хамгийн багадаа 100 хоног цалинтай ажил, хөдөлмөр эрхэлсэн байх шаардлагатай юм. Хувь хүн ажлаас гарснаас хойш 14 хоногийн дараа тэтгэмж авах эрх үүсдэг. Хувь хүн нь зохих шалгуурыг анх хангасан сард болон түүний тэтгэмж авах эрх дууссан (цалинтай ажилд орсон, хувиараа бизнес эрхлэх болсон, хамгийн урт 18 сарын хугацаа дууссан, өөр Муж руу нүүж шилжсэн, нас барсан) сард дүнг хувь тэнцүүлэн тооцоолдог.
- ҮЖ44. Л мужийн засгийн газар нь өөрийн санхүүгийн тайланг 6 дугаар сарын 30-ны байдлаар бэлтгэдэг. Ажилгүйдлийн тэтгэмжийг сар бүрийн 15-нд төлдөг.
- ҮЖ45. 20X1 оны 6-р сарын 30-ний байдлаар Л засгийн газар нь ажилгүйдлийн тэтгэмжийн хувьд 125,067 ТН-ийн өр төлбөрийг хүлээн зөвшөөрсөн. 20X1 оны 7-р сарын 01-нээс 20X2 оны 6-р сарын 30 дуусталх санхүүгийн жилд Л засгийн газар нь ажилгүйдлийн тэтгэмжийг доорх байдлаар төлсөн:

Сар	Төлсөн ажилгүйдлийн тэтгэмж (ТН)
20X1 оны 7-р сар	129,745
20X1 оны 8-р сараас 20X2 оны 6-р сар	1,582,131
Нийт дүн	1,711,876

- ҮЖ46. Энэ жишээнд Л мужийн засгийн газар нь ажилгүйдлийн тэтгэмжийг төлөх өдрөөр иж бүрэн мэдээлэлтэй байсан гэж үзсэн. Иймээс 20X1 оны 7-р сарын 15-нд төлсөн дүн (129,745ТН) ба 20X1 оны 6-р сарын 30-ны байдлаар хүлээн зөвшөөрсөн өр төлбөр (125,067ТН) хоорондох зөрүү нь 20X1 оны 7-р сарын 01-нээс 20X1 оны 7-р сарын 15 дуусталх хугацаанд ажилгүйдлийн тэтгэмжийн шалгуурыг хангасан хүмүүст төлсөн, ажилгүйдлийн тэтгэмжийн хувь тэнцүүлэн тооцсон дүнг (4,678ТН) илэрхийлнэ.
- ҮЖ47. 20X2 оны 7-р сарын 15-нд Л мужийн засгийн газар нь нийт 132,952 ТН-ийн ажилгүйдлийн тэтгэмж төлсөн. Энэхүү төлбөр нь дараах дөрвөн бүрэлдэхүүнтэй байв:

УСНББОУС 42-НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТЭТГЭМЖ

	ТН
20X2 оны 6-р сарын 15-наар шалгуур хангаж байсан бөгөөд 20X2 оны 7-р сарын 15-наар шалгуур хангасан хэвээр байгаа ажилгүй хүмүүст төлсөн ажилгүйдлийн тэтгэмж	113,120
20X2 оны 6-р сарын 15-наар шалгуур хангаж байсан боловч 20X2 оны 7-р сарын 15 гэхэд эрхийн хугацаа дуусаж буй ажилгүй хүмүүст төлсөн, хувь тэнцүүлэн тооцсон ажилгүйдлийн тэтгэмж	9,975
20X2 оны 6-р сарын 15-наас 20X2 оны 6-р сарын 30-ны хооронд шалгуур хангасан, ажилгүй хүмүүст төлсөн, хувь тэнцүүлэн тооцсон ажилгүйдлийн тэтгэмж	5,045
20X2 оны 7-р сарын 01-нээс 20X2 оны 7-р сарын 15-ны хооронд шалгуур хангасан, ажилгүй хүмүүст төлсөн, хувь тэнцүүлэн тооцсон ажилгүйдлийн тэтгэмж	4,812
Нийт дүн	132,952
ҮЖ48. 20X2 оны 6-р сарын 30-нд Л засгийн газар нь тухайн өдрийн байдлаар зохих шалгуурыг хангасан хувь хүмүүст төлөх ажилгүйдлийн тэтгэмжийн өглөгийн хувьд өр төлбөрийг хүлээн зөвшөөрсөн. 20X2 оны 7-р сарын ажилгүйдлийн тэтгэмжийг төлсний дараа, өөрийн 20X1 оны 7-р сарын 01-нээс 20X2 оны 6-р сарын 30-ны санхүүгийн тайланг бэлтгэж гаргасан учраас Л мужийн засгийн газар нь тухайн санхүүгийн тайланг бэлтгэх үед бэлэн боломжтой болсон мэдээллийг ашигласан.	
ҮЖ49. Иймээс Л мужийн засгийн газар нь 128,140 ТН-ийн өр төлбөр хүлээн зөвшөөрсөн. Энэ нь дараах зүйлсээс бүрдэж байна:	
(а) 20X2 оны 6-р сарын 15-наар шалгуур хангаж байсан бөгөөд 20X2 оны 7-р сарын 15-наар шалгуур хангасан хэвээр байгаа ажилгүй хүмүүст төлсөн ажилгүйдлийн тэтгэмж (113,120 ТН);	
(б) 20X2 оны 6-р сарын 15-наар шалгуур хангаж байсан боловч 20X2 оны 7-р сарын 15 гэхэд эрхийн хугацаа дуусаж буй ажилгүй хүмүүст төлсөн, хувь тэнцүүлэн тооцсон ажилгүйдлийн тэтгэмж (9,975 ТН); ба	
(в) 20X2 оны 6-р сарын 15-наас 20X2 оны 6-р сарын 30-ны хооронд шалгуур хангасан, ажилгүй хүмүүст төлсөн, хувь тэнцүүлэн тооцсон ажилгүйдлийн тэтгэмж (5,045 ТН).	
ҮЖ50. 20X2 оны 7-р сарын 01-нээс 20X2 оны 7-р сарын 15-ны хооронд шалгуур хангасан, ажилгүй хүмүүс нь 20X2 оны 6-р сарын 30-наар зохих шалгуурыг хангаагүй байсан учраас тэдэнд төлсөн, хувь тэнцүүлэн тооцсон ажилгүйдлийн тэтгэмж нь энэхүү өр төлбөрийн дүнд тусгагдаагүй болно.	
ҮЖ51. 20X 1 оны 7-р сарын 01-нээс 20X2 оны 6-р сарын 30 дуусталх санхүүгийн жилд зардлаар хүлээн зөвшөөрсөн нийт дүн нь 1,714,949 ТН байна. Энэхүү дүнгийн задаргааг доор харуулав:	

УСНББОУС 42-НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТЭТГЭМЖ

	ТН
20X1 оны 7-р сарын 01-нээс 20X1 оны 7-р сарын 15-ны хооронд шалгуур хангасан, ажилгүй хүмүүст 20X1 оны 7-р сард төлсөн (20X1 оны 7-р сард хүлээн зөвшөөрсөн), хувь тэнцүүлэн тооцсон ажилгүйдлийн тэтгэмж	4,678
20X1 оны 7-р сарын 01-нээс 20X2 оны 6-р сарын 30 дуусталх санхүүгийн жилд хүлээн зөвшөөрч, 20X1 оны 8-р сараас 20X2 оны 6-р сарын хооронд төлсөн ажилгүйдлийн тэтгэмж	1,582,131
20X2 оны 6-р сарын 15-наар шалгуур хангаж байсан, ажилгүй хүмүүст 20X2 оны 7-р сард төлсөн ажилгүйдлийн тэтгэмж, үүнд 20X2 оны 7-р сарын 15-наар шалгуур хангасан хэвээр байгаа болон уг өдрөөр эрхийн хугацаа дуусаж буй ажилгүй хүмүүсийн аль алинд; түүнчлэн 20X2 оны 6-р сарын 15-наас 20X2 оны 6-р сарын 30-ны хооронд шалгуур хангасан, ажилгүй хүмүүст төлсөн (20X2 оны 6-р сард хүлээн зөвшөөрсөн) ажилгүйдлийн тэтгэмж	128,140
Нийт дүн	<hr/> 1,714,949

ЗГСС-ТАЙ ХАРЬЦУУЛАЛТ

УСНББОУС 42, *Нийгмийн Халамжийн Тэтгэмж*-ийг боловсруулахдаа, УСНББОУСЗ нь Засгийн Газрын Санхүүгийн Статистик (ЗГСС)-ийн тайлагналын зааврыг харгалзан үзсэн.

ЗГСС-тай харьцуулахад гол ижил төсөөтэй ба ялгаатай талууд дараах байдалтай байна:

- УСНББОУС 42 нь ЗГСС-тай ижил төсөөтэй ойлголт ухагдахууныг ашигладаг. Тухайлбал; ЗГСС дахь “нийгмийн эрсдэл” гэсэн ойлголт нь УСНББОУС 42-д тодорхойлсон нэр томъёо бөгөөд нийгмийн халамжийн тэтгэмж тодорхойлолтын үндэслэл болсон.
- УСНББОУС 42 нь ЗГСС дахь нийгмийн халамжийн тэтгэмж тодорхойлолтоос арай явцуу хүрээтэй, нийгмийн халамжийн тэтгэмж тодорхойлолтыг ашигласан. УСНББОУС 42 нь өөрийн нийгмийн халамжийн тэтгэмж тодорхойлолтыг мөнгөн шилжүүлгээр (үүн дотроо, мөнгөтэй адилтгах хөрөнгөөр) хязгаарладаг. ЗГСС-ийн дагуу нийгмийн халамжийн тэтгэмжийг мөнгөөр эсвэл мөнгөн бус хэлбэрээр (жишээлбэл; эрүүл мэндийн үйлчилгээгээр) олгож болох юм.
- УСНББОУС 42-ын дагуу байгууллага нь зохих шалгуурыг хангах шаардлагатай дараагийн цэг хүртэл өөрийн төлөх мөнгөн шилжүүлгийн хувьд өр төлбөрийг хүлээн зөвшөөрдөг. ЗГСС-т хэдийгээр санхүүжүүлсэн нийгмийн даатгалын хөтөлбөрт хамаарах өр төлбөрийг бүртгэдэг боловч нийгмийн халамжийн тэтгэмжийн хувьд ийм өр төлбөрийг ерөнхийдөө хүлээн зөвшөөрдөггүй.
- УСНББОУС 42 нь холбогдох нийгмийн халамжийн тэтгэмжийг даатгалын хандлага ашигласнаар хүлээн зөвшөөрч, хэмжихийг зөвшөөрдөг. ЗГСС-ийн хувьд ийм сонголт байдаггүй.
- ЗГСС-т байдаггүй тийм тодруулгын шаардлагуудыг УСНББОУС 42 агуулсан байдаг.

ЗОХИОГЧИЙН ЭРХ, ХУДАЛДААНЫ ТЭМДЭГ, ЗӨВШӨӨРЛИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт, Саналын Төсөл, Зөвлөлдөх Баримт Бичиг, Санал Болгосон Практик Удирдамж болон УСНББОУС3-ийн бусад хэвлэлүүдийг ДНБХ-оос хэвлэн гаргасан бөгөөд түүний зохиогчийн эрхэд хамаарна.

Энэхүү хэвлэлд тусгагдсан материалуудад итгэл үзүүлэн үйлдэл хийсэн эсвэл үйлдлээ больсоны улмаас хэн нэгэнд хохирол учирсан тохиолдолд хохирол нь хайнга байдал буюу бусад шалтгаанаар үүссэн эсэхээс үл хамааран УСНББОУС3 болон ДНБХ нь уг хохирлын хувьд хариуцлага хүлээхгүй болно.

‘International Public Sector Accounting Standards Board’ (Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл), ‘International Public Sector Accounting Standards’ (Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт), ‘Recommended Practice Guidelines’ (Санал Болгосон Практик Удирдамж), ‘International Federation of Accountants’ (Дэлхийн Нягтлан Бодогчдын Холбоо), ‘IPSASB’ (УСНББОУС3), ‘IPSAS’ (УСНББОУС), ‘RPG’ (СБПУ), ‘IFAC’ (ДНБХ), ‘IPSASB’ гэсэн лого, ‘IFAC’ гэсэн лого нь АНУ болон бусад улс орнууд дахь ДНБХ-ны худалдааны тэмдэг буюу бүртгэгдсэн худалдааны тэмдэг ба үйлчилгээний тэмдэг юм.

Зохиогчийн эрх © 2019 оны 01 дүгээр сар, Дэлхийн Нягтлан Бодогчдын Холбоо (ДНБХ). Бүх эрх хамгаалагдсан. Энэхүү баримт бичгийг хувиран олшруулах, хадгалах, шилжүүлэх буюу бусад адилтгах байдлаар ашиглахын тулд ДНБХ-ноос бичгэн зөвшөөрөл авах шаардлагатай. permission@ifac.org хаягаар хандана уу.

ДНБХ-ноос хэвлэв





**Улсын Секторын Нягтлан
Бодох Бүртгэлийн Олон
Улсын Стандартын Зөвлөл™**

529 тавдугаар өргөн чөлөө,
Нью Йорк, Нью Йорк 10017
Утас: + 1 (212) 286-9344
Факс: + 1 (212) 286-9570
www.ipsasb.org

УСНББОУС 42-НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТЭТГЭМЖ

УСНББОУС 42, *Нийгмийн Халамжийн Тэтгэмж*-ийн зарим үг хэллэгийн хувьд орчуулагчийн зүгээс хийсэн тайлбар

№	Параграф буюу лавлагаа	Тайлбар
1	УСНББОУС 1, <i>Санхүүгийн Тайлангийн Толлуулга</i> -д оруулсан нэмэлт өөрчлөлт, Хэрэгжүүлэх заавар удирдамж	Superannuation-Тэтгэвэр, тэтгэмжийн хөтөлбөр гэдэг нь өөрийн ажилтнуудын тэтгэвэр, тэтгэмжинд зориулан компанийн үүсгэн бий болгосон, тэтгэврийн хөтөлбөр юм. Орч.Ч.Д.